




ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



“ТӨРӨӨС МАЛЧДЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гүйцэтгэгч: “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ

Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



2019 оны 11-р сарын 1-ний өдөр



Энэхүү тайлан нь Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгат зөвлөх үйлчилгээний ажлын үр дүнг эмхэтгэсэн бүтээл бөгөөд тус ажлыг 190820/10-303 тоот гэрээний дагуу “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” төрийн бус байгууллага (ТББ) гүйцэтгэв.

ЗОХИОГЧИД

Гончигсумлаагийн Ганзориг (Доктор, PhD)

Гүржавын Энх-Амгалан (Магистр, MSc)

Цабатширын Батнаран (Магистр, MSc)

ЗОХИОГЧИЙН ЭРХ

© Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ, 2019 он

САНАМЖ

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлангийн агуулга нь захиалагч байгууллагын бодлого, үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Боловсролын болон бусад арилжааны бус зориулалтаар энэхүү материалыг хуулбарлахыг бүрэн хүлээн зөвшөөрсөн бөгөөд эх сурвалжийг заавал дурдах шаардлагатай болно.

ТАЛАРХАЛ

Тус тайланг боловсруулах ажлыг санхүүжүүлсэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, үнэтэй саналаа хуваалцсан эрдэмтэн, судлаачид, тоон мэдээлэл ирүүлсэн аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, мэргэжилтнүүд болон санал асуулгад оролцсон малчдад гүн талархлаа илэрхийлж байна.

ХОЛБОО БАРИХ ХАЯГ

“Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ
Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 11-р хороо
ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн байрны 215 тоот
Имэйл хаяг: ganzorig.g@muls.edu.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
НЭГ. УДИРТГАЛ	7
1.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА	7
1.2 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	8
1.3 АЖЛЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОЙМ	8
1.4 БОДЛОГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
1.4.1 Бодлогын зорилго	10
1.4.2 Бодлогын чиглэл	10
1.4.3 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн зорилт	10
1.4.4 Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга зам	14
1.4.5 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат	14
1.4.6 Бодлого хэрэгжсэнээр бий болох хүлээгдэж байгаа үр дүн	14
ХОЁР. АРГА ЗҮЙ	16
2.1 АРГА ЗҮЙН ТОЙМ	16
2.2 ХАМРАХ ХҮРЭЭ	16
2.3 ТОО МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	16
ГУРАВ. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	18
3.1 БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ	18
3.1.1 Хийгдсэн ажил	18
3.1.2 Хэрэгжсэн болон хэрэгжээгүй ажлууд	26
3.1.3 Зарцуулагдсан төсөв	29
3.2 БОДЛОГОД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	31



3.2.1 Бодлого хэрэгжүүлснээр гарсан үр дүн (Ерөнхий).....	31
3.2.2 Хүлээгдэж байсан үр дүнд хүрсэн эсэх (Шалгуур үзүүлэлтээр).....	46
3.2.3 Орон нутгаас ТМТББ-ын хэрэгжилтэд өгсөн санал, шүүмж	56
3.3 МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН.....	59
3.3.1 Ерөнхий мэдээлэл.....	59
3.3.2 Бодлогын баримт бичгийн талаарх малчдын ойлголт, үнэлгээ	59
3.3.3 Малчдын санал.....	61
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.....	62
ТАВ. ЗӨВЛӨМЖ	64
ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	66
ДОЛОО. ХАВСРАЛТ.....	68
7.1 ХАВСРАЛТ 1. БҮХ АЙМГУУДЫН ХХААГ-Т ХҮРГҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ	68
7.2 ХАВСРАЛТ 2. УВС АЙМАГТ АЖИЛЛАСАН ИЛТГЭХ ХУУДАС	71
7.3 ХАВСРАЛТ 3. АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС ТМТББ-Т ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ.....	73
7.4 ХАВСРАЛТ 4. МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН МАЯГТ	79
7.5 ХАВСРАЛТ 5. ТМТББ-ЫН ХҮРЭЭНД 2017, 2018 ОНД ХИЙСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН	80
7.6 ХАВСРАЛТ 6. ГУРВАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.....	84



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	– Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮХС	– Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИТХ	– Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАА	– Мал аж ахуй
МУЗГ	– Монгол Улсын засгийн газар
МЭГ	– Мал эмнэлгийн газар
МЭҮТ	– Мал эмнэлэг, үржлийн тасаг
ОУБ	– Олон улсын байгууллага
ТББ	– Төрийн бус байгууллага
ТМТББ	– Төрөөс малчдын талаар баримтлах бодлого
УИХ	– Улсын их хурал
ҮСХ	– Үндэсний статистикийн хороо
ХХААГ	– Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	– Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХШҮДАГ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЭМГ	– Эрүүл мэндийн газар



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын гүйцэтгэлийн тойм.....	9
Хүснэгт 2. 2017 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажил, түүний үр дүн	18
Хүснэгт 3. 2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажил, түүний үр дүн	20
Хүснэгт 4. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 100% хэрэгжсэн арга хэмжээнүүд	27
Хүснэгт 5. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хэрэгжээгүй арга хэмжээнүүд.....	28
Хүснэгт 6. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зарцуулсан орон нутгийн төсөв (21 аймаг, нийслэлийн хэмжээнд).....	29
Хүснэгт 7. “Төрөөс малчдын талаар баримтлах” бодлогын улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн	31
Хүснэгт 8. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хүлээгдэж буй үр дүн буюу шалгуур үзүүлэлтийн хангасан талаарх үнэлгээ.....	46
Хүснэгт 9. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээ	61



ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын үндсэн 3 чиглэл.....	7
Зураг 2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт	26
Зураг 3. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, чиглэл тус бүрээр (%).....	27
Зураг 4. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зарцуулсан орон нутгийн төсвийн бүтэц (%).....	30
Зураг 5. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д зарцуулсан орон нутгийн төсвийн зардал.....	31
Зураг 6. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” шалгуур үзүүлэлтийн биелэлт (2017, 2018 он).....	55
Зураг 7. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажлын өөрчлөлт	56
Зураг 8. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын талаарх малчдын ойлголт, насны бүлгээр	59
Зураг 9. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын малчдад үзүүлж буй нөлөө	60

НЭГ. УДИРТГАЛ

Мал аж ахуйн салбар нь 2018 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 10%, ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн 84%, экспортын орлогын 7.6%-ийг тус тус бүрдүүлж, нийт ажиллах хүчний 23%-ийг ажлын байраар хангасан байна (ҮСХ, 2019). “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” нь малчин түмний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн асуудлыг бодлогын түвшинд авч үзсэн стратегийн баримт бичиг юм (УИХ, 2009).

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг УИХ-ын 2009 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд үүнд үндсэн 3 чиглэлийг тусгасан. Үндсэн 3 чиглэлийг доорх диаграммд харуулав.

Зураг 1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын үндсэн 3 чиглэл



Эх сурвалж: УИХ (2009)

1.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцад ХХААХҮЯ-наас хэд хэдэн төрлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-г хагас жил, жилийн давтамжтай хийгдэж байсан байна. Үүнд:

1. ХХААХҮЯ-ны 2017, 2018 онд хийсэн тус бодлогын хэрэгжилтийн ХШҮ,
2. “Улаанбаатар аудит корпорац” ХХК-ний 2016-2018 онд ХХААХҮЯ-ны санхүүжилттэйгээр хийсэн “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”,
3. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ХШҮ” (ХХААХҮЯ, 2019),



4. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Тус яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн ХШҮ” (ХХААХҮЯ, 2019),
5. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн ХШҮ-ний танилцуулга (2018 оны жилийн эцсийн байдлаар)”,
6. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ажлын товч танилцуулга”.

Одоогоор тус бодлогын хэрэгжилтийн явцад **хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй байна**. МУЗГ (2017)-аас баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2.1.5-д <<“хөндлөнгийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн ХШҮ-г хэлнэ>> гэж заасан.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн **8.6**-д “Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэж заасан байдаг боловч “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д хөндлөнгийн үнэлгээ огт хийгдээгүй байна.

ХХААХҮЯ 2019 оны төсөвт “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д хөндлөнгийн үнэлгээ хийх төсвийг суулгаж, өдгөө энэ ажлыг “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” төрийн бус байгууллага (ТББ) гүйцэтгэж, энэхүү тайланд үнэлгээний үр дүнг танилцуулж байна.

1.2 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэж, зөвлөмж боловсруулах нь тус зөвлөх үйлчилгээний зорилго болно.

1.3 АЖЛЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОЙМ

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг хэрхэн гүйцэтгэсэн талаар доорх хүснэгтэд тоймлон оруулав.



Хүснэгт 1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын гүйцэтгэлийн тойм

№	Захиалагчийн шаардлага	Гүйцэтгэсэн байдал	Ажил гүйцэтгэхэд оролцсон зөвлөхийн тоо
1	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн тайланд шинжилгээ хийх: Эхний үе шат (2009-2015 он), Хоёр дахь үе шат (2016-2020 он)	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн ХШҮ-ний 2017-2018 оны тайлангууд дээр шинжилгээ хийв. Хийсэн шинжилгээг тус тайлангийн 3.1, 3.2 дугаар хэсэгт оруулсан болно.	3
2	Хэрэгжилтийн тайланд шинжилгээ хийсэн явцын мэдээлэл танилцуулах	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т тус бодлогын баримт бичгийн ХШҮ-ний тайланд хийсэн шинжилгээний урьдчилсан үр дүнг 2019 оны 9-р сарын 10, 10-р сарын 20-нд 2 удаа танилцуулж, санал, зөвлөмжийг авсан болно.	2
3	Шаардлагатай тохиолдолд Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад ажиллаж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үр дүнтэй танилцах	2019 оны 8-р сарын 28-30-ны өдрүүдэд Увс аймагт томилолтоор ажиллаж аймгийн ХХААГ-ын дарга Д.Төмөр-Очир, Мал аж ахуйн албаны дарга н.Лантуу нартай уулзаж “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, үр дүн, тулгарч буй бэрхшээлийн талаар судалгаа хийж, зохих уулзалт зохион байгуулсан. Томилолтоор ажилласан үр дүнг тус тайлангийн Хавсралт 2-т оруулсан болно. Мөн Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хэрлэн багийн 22 малчин өрхөөс “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын талаарх ойлголт, тус хөтөлбөрийн хэрэгжилт, малчдад өгч байгаа үр дүнг тандан судлах зорилгоор санал асуулга авсан болно. Санал асуулгын үр дүнг 3.3 дугаар хэсэгт оруулсан болно.	3
4	Тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулгыг ХШҮДАГ-с тодруулна	Орон нутгаас нэмэлт мэдээлэл цуглуулах талаар ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас тодруулга авсны үндсэн дээр 21 аймаг, нийслэлийн ХХААГ-аас тоо мэдээ цуглуулах ажлыг ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулсан. Ингэхийн тулд ХХААХҮЯ-ны ТЗУГ-ын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбалцэрэнгээс 21 аймаг, нийслэлийн ХХААГ-т тоо мэдээ цуглуулах тухай тоот 01/3581 тоот албан бичгийг 2019 оны 9-р сарын 18-ны өдөр хүргүүлж мэдээлэл цуглуулсан болно (Хавсралт 1). Аймаг, нийслэлээс ирсэн тоо мэдээнд үндэслэсэн судалгааны үр дүнг тус тайлангийн 3.1, 3.2 дугаар хэсэгт оруулав.	1
5	Үнэлгээ хийх аргачлал	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн боловсруулсан аргачлалыг тус тайлангийн 2-р бүлэгт оруулсан болно.	3
6	Цаашид малчдын талаар баримтлах төр засгийн бодлогод тусгах зөвлөмж боловсруулах	Хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид энэ төрлийн бодлогын баримт бичигт тусгах зөвлөмжийг тус тайлангийн 5-р бүлэгт оруулсан.	3
7	Хөндлөнгийн үнэлгээний ажлын явцыг захиалагчид 2 удаа, үр дүнг эцсийн байдлаар 1 удаа хэлэлцүүлэн дүгнүүлэх	Хөндлөнгийн үнэлгээний ажлын явцыг ХХААХҮЯ-ны байранд 2019 оны 09-р сарын 10-нд, 2019 оны 10-р сарын 20-нд ХХААХҮЯ-ны 4 давхрын 401 тоот өрөөнд ХШҮДАГ-ын дарга Ч.Тавинжил, ахлах мэргэжилтэн С.Сонгууль, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Б.Төгс-Эрдэнэ нарт танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулав. Эцсийн хэлэлцүүлгийг 2019 оны 10-р сарын 22-нд ХХААХҮЯ-ны 8 давхрын хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын дарга Ч.Тавинжил, ахлах мэргэжилтэн Д.Батхуяг, ахлах мэргэжилтэн С.Сонгууль, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Г.Мөнхмаргад, МААХБЗГ-ын мэргэжилтэн Д.Мөнхгэрэл, Б.Төгс-Эрдэнэ, Д.Хүрэлбаатар, МГНХ-ийн мэргэжилтэн П.Баясгалан нар оролцов (Хавсралт 6). Эдгээр хэлэлцүүлгүүдээс гарсан саналыг тайланд тусгаж, эцсийн тайланг хүлээлгэн өгөв. Эцсийн хэлэлцүүлэгт ХХААХҮЯ-ны ТЗУГ, НБТГ-ын мэргэжилтнүүдийг урьсан боловч бусад ажилтай давхацсан тул ирээгүй.	3
8	Ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлагын талаар мэдээлэл ирүүлэх	Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн (БОХААЭЗХ) ТББ-ын захирал Т.Эрдэнэчулуун, гишүүн Г.Ганзориг нар 2018 онд “Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө”-г НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилттэйгээр боловсруулж ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулсан болно. Мөн тус ТББ-ын гишүүн Г.Энх-Амгалан нь “Баруун бүсийн хувийн хэвшлийг дэмжих төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийн саналыг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэйгээр гүйцэтгэж, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт 2018 оны 11-р сард хүлээлгэн өгсөн. БОХААЭЗХ ТББ-ын гишүүн Г.Ганзориг нь 2019 оны 4-р сараас эхлэн “НҮБ-ын бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна. Мөн тэрээр 2014-2015 онд “Ногоон хөгжлийн бодлогын 4-р стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсгийн 4-р багийн ахлагчаар, 2014 онд “Ногоон хөгжлийн бодлогыг боловсруулах нь” ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилласан.	3

1.4 БОДЛОГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.4.1 Бодлогын зорилго

УИХ-ын 2009 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийн зорилго нь малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг, орлогыг нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршиж байна.

1.4.2 Бодлогын чиглэл

Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж, бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох, Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах.

1.4.3 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн зорилт

Зорилт 1. Нэгдүгээр үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх стратегийн зорилтууд:

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хүрэлцэх хэмжээний газрыг эзэмшүүлэх, отрын бүс нутаг байгуулах, сумдад бэлчээр ашиглалтын хороог ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлж, бэлчээр ашигласны төлбөрийг эдийн засаг, экологийн үнэлгээнд үндэслэн ялгавартай тогтоох, уг төлбөрийн 30-аас доошгүй хувиар сумын бэлчээр хамгаалах, сэргээх болон мал аж ахуйн эрсдлийн сан байгуулж, зарцуулж байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхийг мал, амьтан, эд хөрөнгийн даатгал, санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах, хөрөнгийн гэрчилгээ, харилцах данс, бүртгэлтэй болгож банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, лизингийн үйлчилгээнд хамрагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Малчин өрх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл нь бизнесийн өөр төрлийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх,
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн харилцааны хэв шинжийг судалж, туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон

нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан орлого багатай малчдыг өөр салбарт шилжин ажиллах, бизнес эрхлэхийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,

- Малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх,
- Мал аж ахуйн салбарт хүүхэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, шалгуурыг тодорхой болгож, тус салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг арилгах бодлого хэрэгжүүлэх,
- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээ авах,
- Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлэх,
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрхийг малын чанараа сайжруулах болон өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг арвин ашиг шимт нэг төрлийн мал дагнан төрөлжүүлэн зах зээлийн мэдээлэл, бизнес төлөвлөгөө бүхий аж ахуйн хэв шинжийг олоход нь дэмжлэг үзүүлэх,
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа өрхийг эдийн засгийн ашиг сонирхол дээр тулгуурласан малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр хамтын аж ахуй эрхлэх эрх зүй, санхүү, эдийн засгийн нөхцөлийг бий болгон хөгжүүлэх,
- Богд шилжүүлснээр бэлчээрийн 100 хүртэл малтай, зөвхөн түүнээс өрхийн орлого нь бүрдэж байгаа малчин өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг эдийн засгийн бусад салбарт шилжүүлэх, эсхүл малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлд хамруулан ажлаар хангах бодлого хэрэгжүүлэх.

Зорилт 2. Хоёрдугаар бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх стратегийн зорилтууд:

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, чанарыг сайжруулах,
- Малчдын өөрсдийнх нь санал болгосон хүнийг тусгайлан сургах замаар малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн удирдлагыг бэлтгэх арга хэмжээг төрөөс санаачлан хэрэгжүүлэх, орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нарт энэ чиглэлээр сургалт зохион байгуулах,
- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг тодорхой болгон нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Мах үйлдвэрлэл", "Сүү үйлдвэрлэл", "Арьс, шир бэлтгэл", "Ноос, ноолуур бэлтгэл" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэх,
- Бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах зах зээлийн тогтолцоог бүс нутгийн онцлогт нийцүүлэн бий болгож хөгжүүлэх,



- Малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур, өлөн гэдэс, эвэр, туурай, яс, хялгас зэрэг)-ийг худалдан авах, түүнд чанарын анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх,
- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт, түүнийг хэрэглэх заавар, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх,
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгөөр усны хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг гаргах, засварлахын зэрэгцээ малчдын үүсгэл, санаачилгаар худаг гаргах, засварлах, цас, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрөм байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих,
- Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, тэжээл бэлтгэх зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулах,
- Шилжин суурьшсан малчин байсан иргэдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээнд хамруулах, ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх,
- "Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,
- Малчин өрх бүрийг 2015 он гэхэд 100 хувь радиотой болгох, цахилгааны эх үүсвэртэй болгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх, малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээллийг гар утсаар хүргэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Малчдыг байгалийн гамшгийн үед өмсөхөд зориулсан дулаан, тохиромжтой хувцсаар хангах, энэ чиглэлээр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болгох, техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулж байх,
- Өвс, тэжээлийн чанар, сав, баглаа боодлын стандартыг шинэчлэн тогтоож шинэ технологи нэвтрүүлэн овор багатай, чанар сайтай тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Тэжээлийн нөөцийн хэмжээ, хүртээмж, байршлыг оновчтой тогтоох, түүний хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын менежментийг сайжруулах, сум, багийн түвшинд өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээ бий болгох,
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тэжээлийн ургамлын улсын үрийн нөөцтэй болж нутагшсан сортын үрийг баталгаажуулж, түүнийг тариалах ажлыг өргөжүүлэх, уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх,
- Малын хашаа, дулаан байрны зураг төсөл гаргаж материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх,
- Мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх,



- Аймаг, сумын түвшинд арвин ашиг шимтэй мал, амьтан бойжуулж, борлуулах үржлийн аж ахуйг бий болгон хөгжүүлэх, тухайн орон нутгийн малын чанарыг сайжруулах арга хэмжээг дэмжих,
- Малд зайлшгүй үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх нэгжийг сум бүрт ажиллуулах,
- Мал, амьтны шүлхий, мялзан өвчнөөс тайван орны жагсаалтад орж, тодорхой бүс нутгийг малын гоц халдварт болон нэн аюултай зооноз өвчнөөс эрүүлжүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний нэрийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд өрсөлдөх бодлогыг алхам алхмаар хэрэгжүүлэх.

Зорилт 3. Гуравдугаар бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх стратегийн зорилтууд:

- Малчны өөрөө өөрийгөө удирдах анхан, дунд, дээд шатны байгууллага бий болгох, анхан шатны байгууллагыг удирдлага, менежмент, зохион байгуулалтын нэгдсэн хэлбэрт оруулах бүтэц бий болох боломж, нөхцөлийг бүрдүүлэх, малчдын дунд сургалт явуулж оролцооны аргаар албан ёсны зохион байгуулалтын бүтцэд шилжих үйл явцыг төрөөс дэмжин хөгжүүлэх,
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх,
- Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, холбоог бэхжүүлэх зорилгоор тэдгээрийг гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөрт хамруулах,
- Малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаарх мэдээллийн цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах,
- Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар тусгайлсан төсөл, хөтөлбөрийг бүс нутгийн онцлог байдлыг харгалзан боловсруулж хэрэгжүүлэх,
- Малчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол, бүрэн хамруулж, зардлыг төрөөс хариуцах арга хэмжээг хэрэгжүүлэх, сум, багийн эмнэлгийг боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны болон зайны сургалтад хамруулах,
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг судалж, мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчнөөс малчид, хүн амыг хамгаалах болон осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, ахуйн болон ундны цэвэр усаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Малчин өрхийн эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх, сургагч багш нарыг сум бүрт бэлтгэж мэргэшүүлэх,
- Малчдад зориулсан сургалтыг орон нутагт үйлдвэрлэлийн явцад хэрэгжүүлэх байгууллага, малчны байнгын болон түр сургуулийг бий болгон бэхжүүлэх, түүгээр дамжуулан шат дараалсан сургалт (анхан шатны танин мэдэхүйн сургалтаас эхлээд технологи дамжуулах, нутагшуулах, инноваци нэвтрүүлэх зэрэг)-ыг зохион байгуулах,



- Залуу болон ирээдүйн малчдыг мэргэжлийн, түр болон албан бус сургалтаар хэтийн төлөвлөгөөтэй бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх,
- Малчдад зориулсан сонин, сэтгүүл тогтмол гаргахыг дэмжих, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, тусгай хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх,
- Орлого багатай малчдыг бусад төрлийн аж ахуй эрхлэх, бие даан бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ, чадавх, санаачилгыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх,
- Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох, ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх.

1.4.4 Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга зам

Малчдын амьдралын түвшинг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно, Малчдын амьдралыг сайжруулах, малчдын аж ахуйг хөгжүүлэхэд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ,

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг үе шат бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулан гүйцэтгэнэ.

1.4.5 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Эхний үе шат буюу 2009-2015 он,

Хоёрдугаар үе шат буюу 2016-2020 он

1.4.6 Бодлого хэрэгжсэнээр бий болох хүлээгдэж байгаа үр дүн

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат (2009-2015 он)-нд дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ;
- Малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно;
- Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ;
- Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна;



- Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ;
- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ;
- Эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50 хувиар өснө;
- Эхний үе шатанд эрүүл мэндийн даатгалд малчдын 70-аас доошгүй хувийг, нийгмийн даатгалд малчдын 50-аас доошгүй хувийг хамруулсан байна.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат (2016-2020 он)-нд дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно;
- Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;
- Хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 80 хувиар өснө.



ХОЁР. АРГА ЗҮЙ

2.1 АРГА ЗҮЙН ТОЙМ

“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг гүйцэтгэв (УИХ, 2015; МУЗГ, 2017).

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ эхлээд ХХААХҮЯ-ны хяналт-шинжилгээ үнэлгээ (ХШҮ)-ний тайлангууд, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” зэрэг эх материалыг судлав (ХХААХҮЯ, 2016). Мөн Увс, Хэнтий аймгуудад томилолтоор ажиллан аймгийн тамгын газар болон орон нутгийн удирдлагуудтай уулзан ярилцаж, малчин өрхүүдээс түүвэр судалгаа авлаа.

Түүнээс гадна ХХААХҮЯ-ны мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтнүүд, болон мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай уулзалт ярилцлага зохион байгуулав.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д зарцуулсан орон нутгийн төсвийн зарцуулалтын талаар тоо мэдээ цуглуу

тьлүүтолж, зохих тоон судалгааг гүйцэтгэв.

2.2 ХАМРАХ ХҮРЭЭ

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” нь орон даяар хэрэгждэг, тиймээс судалгааны хамрах хүрээ нь нэгдүгээрт Монгол Улсын хэмжээнд, хоёрдугаарт 21 аймаг, нийслэлийн түвшинд хийгдэв. Хавсралт 1-д 21 аймаг, нийслэлд явуулсан албан бичгийг оруулав.

2.3 ТОО МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Хөндлөнгийн үнэлгээнд ашиглагдсан тоо мэдээг үндсэнд нь 4 ангилав. Үүнд:

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд өнөөг хүртэл хийсэн ХШҮ-ний тайлангууд, хууль, эрх зүйн орчин, бодлогын баримт бичгийн судалгаа хийв.

Увс аймгийн ХХААГ-ын дарга Д.Төмөр-Очир, МЭГ-ын н.Лантуу нартай томилолтоор очиж уулзсан (Томилолтоор ажилласан илтгэх хуудсыг Хавсралт 2-т оруулав). Мөн “Бодлого судлалын төв”-ийн захирал А.Энх-Амгалан, ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан нартай уулзалт ярилцлага хийв.



“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан орон нутгийн төсөв, мөн тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн, дутагдалтай тал, сайжруулах арга зам зэрэг мэдээллийг агуулсан тоо мэдээг 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ)-аас гаргуулан авав (Хавсралт 1, 3).

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хэрлэн багийн санамсаргүй сонгогдсон 22 малчин өрхөөс “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, үр дүнгийн талаар санал асуулга авлаа (Хавсралт 4-өөс малчдаас авсан санал асуулгын маягтыг үзнэ үү). Санал асуулгын маягтад тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн, мөн малчдын тус бодлогод өгөх хувь хүний үнэлгээ, цаашид сайжруулах арга зам, зөвлөмж зэргийг тусгасан болно.

Бид анхдагч болон хоёрдогч тоо мэдээллийг шинжлэхдээ аналитик шинжилгээний арга зүй, харьцуулалтын аргыг ашиглав.

ХХААХҮЯ-наас “Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын” хэрэгжилтийн 2017, 2018 оны тайлангууд дээр үндэслэн тус бодлогыг хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлснийг судалсан бөгөөд гүйцэтгэлийг үнэлэхдээ тухай ажил хэрэгжээгүй бол 0%, хэрэгжилт удаашралтай бол 40%, хэрэгжилт сайн бол 70%, хэрэгжиж дууссан бол 100%-иар үнэлсэн болно (ХХААХҮЯ, 2019).



ГУРАВ. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ

3.1.1 Хийгдсэн ажил

Дараах хоёр хүснэгтэд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажил, түүний үр дүнг харуулав. Энд оруулсан мэдээллийг ХХААХҮЯ-наас гаргасан 2017, 2018 оны тайлангаас авсан болно.

Хүснэгт 2. 2017 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажил, түүний үр дүн

Үндсэн чиглэл	Хийсэн ажил
2.2.1.хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх;	Хурал, зөвлөгөөн зохион байгуулах
2.2.2.төрөөс малчин өрхийн эдийн засгийн чадавх, бололцоо, хүсэл сонирхолд нь нийцсэн дэмжлэг үзүүлэх;	Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох
2.2.3.хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, тэргүүний арга, туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эзэмшүүлэх, нутагшуулах;	Малын үржил селекцийн ажлыг хянан магадлах, баталгаажуулах зорилгоор хавар, намрын хугацаанд орон нутагт ажилласан.
2.2.4.малчин хүний ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах, туслан хөгжүүлэх үйл ажиллагааг аль болох анхан шатны нэгжид, баг, хорооны түвшинд хөхүүлэн дэмжих;	Сум, аймгийн аварга, улсын аварга малчин, хошой аварга малчин, аварга саалчин, аварга фермер шалгаруулав.
-	Малын үржлийг сайжруулах
	Малчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх
	Залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх үр чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, малчид орон нутагтаа мал маллаж түүний ашиг шимийг хүртэж байнгын ажлын байртай болоход хувь нэмэр оруулах зорилгоор "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг жил бүр шинэчлэн тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.
	Малчдын амьжиргааг дээшлүүлэх
	Малчдын хашаа, саравч сайжруулах, амьжиргааг дээшлүүлэх
	Усан хангамж нэмэгдүүлэх
	Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох
	ЭМААХДхөтөлбөр болон “Монгол Мал” үндэсний хөтөлбөрөөр Өвс тэжээлийн нөөц Малчдын бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийн оновчтой сүлжээг бий болгох Малын үүлдэр угсааг сайжруулах Өвс тэжээлийн нөөц
2.3.3.Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах.	Малчдын бүлэг байгуулах, зохион байгуулалтыг дээшлүүлэх
3.1.1.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хүрэлцэх хэмжээний газрыг эзэмшүүлэх, отрын бүс нутаг байгуулах, сумдад бэлчээр ашиглалтын хороог ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх / хэлэлцүүлэг хийх
3.1.6.Малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх;	Малчдын нийгмийн асуудлыг дээшлүүлэх
3.2.1.эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, чанарыг сайжруулах;	ЭМААХДхөтөлбөр боловсруулах



3.2.2.Малчдын өөрсдийнх нь санал болгосон хүнийг тусгайлан сургах замаар малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн удирдлагыг бэлтгэх арга хэмжээг төрөөс санаачлан хэрэгжүүлэх, орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нарт энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;	Малчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх
3.2.5.Малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур, өлөн гэдэс, эвэр, туурай, яс, хялгас зэрэг)-ийг худалдан авах, түүнд чанарын анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх;	Түүхий эдийн анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгосон
-	Бэлчээрийн усан хангамж сайжруулах Усан хангамж нэмэгдүүлэх
3.2.10."Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;	Малчдын орон байр, сууцны хүрэлцээг нэмэгдүүлэх
3.2.13.Бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болгох, техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулж байх;	Өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх
3.2.18.Мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;	Автомат хашааг танилцуулах, ач холбогдлыг ойлгуулах
3.2.21.Мал, амьтны шүлхий, мялзан өвчнөөс тайван орны жагсаалтад орж, тодорхой бүс нутгийг малын гоц халдварт болон нэн аюултай зооноз өвчнөөс эрүүлжүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний нэрийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд өрсөлдөх бодлогыг алхам алхмаар хэрэгжүүлэх.	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
3.3.2.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;	Нэгдсэн зохион байгуулалт, холбоо байгуулах
3.3.4.Малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаарх мэдээллийн цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах;	Мэдээллийн сантай болсон байх
3.3.8.Малчин өрхийн эдийн засаг, бизнес, үр чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх, сургагч багш нарыг сум бүрт бэлтгэж мэргэшүүлэх;	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
6.1.2.Малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно;	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бий болгох
6.1.3.Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ;	Малын эрүүл мэндийг сайжруулах
6.2.2.Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;	Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх

Эх сурвалж: ХХААХҮЯ (2018)



Хүснэгт 3. 2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажил, түүний үр дүн

Үндсэн чиглэл 1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх		
Стратегийн зорилт	Хийсэн ажил	Үр дүн
1.1	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх.	Сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3,6 хувийн хүүтэй зээл, мах, сүүний үхрийн фермерийн 30 аж ахуйн нэгжид 14.1 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.
1.1	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох эрх зүйг бүрдүүлэх	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 389 малчдын бүлэг 3890 га бэлчээрийг бэлчээр ашиглах гэрээ байгуулан 15 жилийн хугацаатай бэлчээрийг гэрээгээр ашиглаж байна.
1.1	Бэлчээр хамгаалах хуулийн төсөл боловсруулах, санал авах	Хуулийн төсөлд санал авахаар бусад яаманд хүргүүлсэн байна.
1.1	Хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлөх	Үр дүн гарах болоогүй
1.1	Малын тооноос хамааралтайгаар бэлчээрийн татварыг бий болгох, татварыг орон нутгийн санд төвлөрүүлэх эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын нөхцлийг бүрдүүлэх	“Мал аж ахуйн тогтвортой хөгжил 2018” малчдын улсын зөвлөгөөн зохион байгуулж, бүх аймаг, сумдын нийт 12916 хүнээс авсан бэлчээр ашигласны төлбөрийн тухай санал асуулгын дүнг хэлэлцүүлэв. Монголын олон нийтийн үндэсний радио, телевизийн “Бэлчээрийн доройтол гарц, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, 21 аймгийн малчид, эрдэмтэн судлаачдын төлөөлөл нийт 50 хүнийг оролцуулан бэлчээр ашигласны төлбөрийн асуудлыг хэлэлцүүлэв.
1.1	Малчдаас хураасан татвараар мал аж ахуйн эрсдлийн сан байгуулах	Үр дүн гарахгүй болоогүй, татварын асуудал шийдэгдээгүй
1.3	Мал, амьтан, эд хөрөнгийн даатгалд хамруулах	Үр дүн гарахгүй болоогүй, татварын асуудал шийдэгдээгүй
1.3	Малчдыг малчин мэргэжлийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, үйлдвэрлэгч гэсэн гэрчилгээ, харилцах данс, тэмдэгтэй болгох.	Малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх тухай, Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх тухай журмуудыг боловсруулж "Малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх тухай" журмыг баталж, ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн боловч дахин боловсруулах шаардлагатай гарсан.
1.4	Малчдын хадлан бэлтгэх ажлыг хөнгөвчлөх, богино хугацаанд бэлтгэх бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хөдөлгөөнт гар хадуур нийлүүлэх	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
1.5	Малчдын хөдөлмөрийн харилцааг сайжруулах	“Гэрээт малчин – өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-ийг 2018 оны 8 дугаар сараас хэрэгжүүлсэн ба 2018 оны эцсийн байдлаар нийт 225 ажил олгогч малчин, 223 гэрээт малчин өрхийн 406 иргэн ажлын байраар хангагдаж 51,0 сая төгрөг зарцуулсан байна.
1.5	Малчдыг мэдлэгжүүлэх болон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн зайн сургалтыг давтамжтай явуулах	“Мал аж ахуйн тогтвортой хөгжил” малчдын улсын зөвлөгөөнийг 2018,05,17-ны өдөр Улаанбаатар хотод 800 гаруй төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулав. Малчдын зөвлөгөөнөөр мал аж ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулав. УИХ-аар шинээр батлагдсан “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Малын генетик нөөцийн тухай” хуулийг танилцууллаа. “Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулж, 21 аймаг 330 сумын 12600 малчдаас “Бэлчээр ашигласны төлбөр авах тухай санал асуулгын дүнг танилцуулж хэлэлцүүлэв. Мөн малчдын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгааллын талаар мэдээлэл хийв. Малчдын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг сайдад өргөн барив. 2018 оны 4-р сард Дундговь, Өмнөговь аймгуудад томиллоор явж “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд Дундговь аймгийн 14 сумын 120 хүн оролцсон. Үүнд сумдын засаг дарга, мал зүйч, малын эмч, аймгийн удирдлагууд, малчид оролцуулан “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулсан. 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Төв аймгийн Борнуур суманд “Сүү үйлдвэрлэгч фермерүүдийн зөвлөлдөх уулзалт, зөвлөгөөнд оролцож ЭМАА-өнөөгийн байдал цаашдын зорилтын талаар болон “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулав. Малын генетик нөөцийн тухай болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиудыг орон нутагт сурталчлах, сургалт зохион байгуулах ажил батлагдсан хуваарийн дагуу нийт нийслэл, аймгуудад 100 хувь хийлээ. Уг сургалтыг нэг аймаг 2-3 бүс болгон Тойргийн сумдын малчид мал аж ахуйн мэргэжилтнүүдийг оролцуулав. Нийт 21 аймаг, нийслэлд нийт 8000 гаруй хүн хамрагдсан болно.
1.6	-	“Малчин, хувяараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль” баталсан. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг Засгийн

		газар батална гэж заасан. Мөн хуулийн 8 дугаар зүйлд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж тус тус заасан тул ХНХЯам энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрөөр малгүй болон цөөн малтай 18-45 насны өрхийг малжуулах, аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамруулах, туршлага солилцох уулзалт, нэгдсэн өдөрлөг яармаг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд 2018 оны эцсийн байдлаар 3663 өрхийг хамруулж, 5,828,6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна.
1.7	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах	“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос ноолуур бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний дүгнэлт, санал боловсруулсан.
1.8	Бэлчээрийн үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг боловсруулж нэвтрүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.2.2, 3.2.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.27.1 дэх заалт, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-57 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын XII.1.5.1 дэх заалтыг хэрэгжүүлж, Махны чиглэлийн өндөр ашиг шимт хонины үржлийн аж ахуй байгуулах зорилгоор төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, махны чиглэлийн нийт 651 толгой үржлийн эм хонь, 36 толгой хуц, бүгд 687 толгой хонь импортлохоос нийт 621 толгой үржлийн эм, 36 толгой хуц бүгд 657 хонийг 2017 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Франц улсаас импортлон оруулж ирсэн. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-216 дугаар тушаалын 2 дахь заалтын дагуу хоёрдугаар үе шатны гэрээ буюу хонины үржлийн аж ахуй байгуулж, өсгөн үржүүлэх гэрээг “Тайшир-Өргөө” ХХК-тай байгуулав. 2018 онд дээрх хониноос 200 гаруй төл бойжуулаад байна. 2011 онд “Гацуурт” ХХК-тай байгуулсан “Махны цэвэр үүлдрийн үхэр импортлох үржлийн аж ахуй эрхлэх төсөлд дэмжлэг үзүүлэх” зээлийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулж, эргэн төлөлтийн 200 толгой өсвөр үхрийг хүлээн авч ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-135 дугаар тушаалаар хуваарилав. 2018 онд Улсын төсвийн санхүүжилтээр Булган аймагт “Цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт бух, хуц, ухна, гүн хөлдөөсөн үр, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерт зарлаж “Геррефорд” үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100-н толгой, Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160 толгой, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200 толгой, Эрчимийн хар үүлдрийн үржлийн өсвөр ухна 180 толгой, Геррефорд үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үр 6000 ширхэг, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлүүлэх ажлыг Булган аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/446 тоот захирамжаар байгуулагдсан бараа хүлээж авах ажлын хэсгийн хүлээн авсан тухай актыг үндэслэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/181 дугаар тушаалаар Мал аж ахуйн чиглэлээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэг малыг хүлээн авч Булган аймгийн ХХААГазарт хүлээлгэн өгөв. Энэ ажил бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 665 малчин болон аж ахуйн нэгжийн малд сайжруулагчаар ашиглах болсон.
1.8	Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үүлдрийн үхрийг өсгөж үржүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2011 онд “Гацуурт” ХХК-тай байгуулсан “Махны цэвэр үүлдрийн үхэр импортлох үржлийн аж ахуй эрхлэх төсөлд дэмжлэг үзүүлэх” зээлийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг ажиллуулж, эргэн төлөлтийн 200 толгой өсвөр үхрийг хүлээн авч ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-135 дугаар тушаалаар хуваарилав. Сүү болон сүү-мах, махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн үржлийн аж ахуй байгуулах төсөл сонгон шалгаруулж “Газар агро” ХХК нь 2017 онд ОХУ-аас 150 толгой махны чиглэлийн “Геррефорд” үүлдрийн үхэр, “Сэлэнгэ тариа” ХХК Герман улсаас “Лимузэн” үүлдрийн 60 толгой үхрийг тус тус импортлон өсгөн үржүүлж энэ төрлийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйнуудыг сайн чанарын цэвэр үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчээр хангахаар ажиллаж байна “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан. Ингэснээр эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих эрх зүйн зохицуулалт бүрдсэн ба зээлийн эргэлтийн сангийн хэмжээ нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн. ЭМААХДҮХөтөлбөрийг болон хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үхэр импортлон үржүүлэхээр тусгагдсан байгаа. 2018 онд Улсын төсвийн санхүүжилтээр “Шинэ хөдөө, жимс, жимсгэнэ” төслийг Булган аймагт хэрэгжүүлж “Цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт бух, хуц, ухна, гүн хөлдөөсөн үр, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерт зарлаж “Геррефорд” үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100-н толгой, Геррефорд үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үр 6000 ширхэг, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлүүлсэн. Энэ ажил бэлчээрийн маллагаатай үхрийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 300 малчин болон аж ахуйн нэгжийн малд сайжруулагчаар ашиглах боллоо. 2018 онд 509.0 сая төгрөгийн дэмжлэгийг сүүний болон махны үхрийн 27 аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. 2018 оны 10 дугаар сард гэрээ байгуулан хөнгөлөлттэй зээлийг жилийн 3,6 хувийн хүүтэй, 5-н жилийн хугацаатай олгосон. 2019 онд 900 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг төвийн бүсийн ойролцоо мах болон сүүний



		чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 30-с доошгүй аж ахуйн нэгжид олгохоор төлөвлөөд ажиллаж байна.
1.9	Мал хамгаалах санг түшиглэн малчид, фермерүүдэд дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох сан байгуулах	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.1	-	Улсын хэмжээнд мал үржүүлэг, технологийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 121 аж ахуй нэгж байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн хүрээнд мал үржүүлэг, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нэгжийг орон нутагт шинээр байгуулж, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх зөвлөмжийг аймгийн ХХАА-н газарт хүргүүлэв. ХХААХҮ-ийн Сайдын А-123 тушаалын дагуу сонгон шалгаруулалт зарлаж, 7 аймгийн 8 аж ахуйн нэгжид 185.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Нэгжийг чадавхжуулахад 2019 оны төсөвт 100 сая төгрөгийг төсөвлөөд байна.
2.2	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах нөхцөлийг сайжруулж, чанар, эрүүл ахуйн олон улсын стандартад нийцүүлэх.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцаа ТА 8960 MON” төслийн хүрээнд Завхан, Архангай аймгийн сүү боловсруулах үйлдвэр, цех, хоршоо, фермер, малчдын бүлгүүдэд “Сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах” сэдэвт сургалтыг 2017 оны 12-р сарын 7-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад дээрх 2 аймгийн нийт 15 хоршоо, 90 гаруй малчин хамрагдсан
2.2	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгон нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх	НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “Монгол улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (Бүрэлдэхүүн хэсэг 2): Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төслийн санхүүжилтээр сүүний цехийн тоног төхөөрөмжийг Дорнод, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн 6 сумын эмэгтэйчүүдийн сүү үйлдвэрлэгчдийн бүлгүүдэд хоногт 500 л сүү боловсруулах хүчин чадалтай нийт 63 гаруй сая төгрөгийн гэр цехийн тоног төхөөрөмжийг 2018 оны 6 дугаар сард хүлээлгэн өгсөн. Сүүний боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор “Сүүний хөргөлтийн танк, цахилгаан хөдөлгөөнт саалтуур” нийлүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нийлүүлсэн тоног төхөөрөмжийг 2018 оны 11-р сарын 23-нд хүлээн авч Мал хамгаалах санд шилжүүлсэн. Энэ арга хэмжээний дүнд 10 ширхэг сүүний хөргөлтийн танк, 144 ширхэг цахилгаан хөдөлгөөнт саалтуурыг сүүний чиглэлийн эрчимжсэн үхрийн фермер, аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон. “Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, малын гаралтай нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ”-г сургалт зохион байгуулав.
2.3	Түүхий эдийн борлуулалтын зах зээл дэх ченжийн тогтолцоог өөрчлөх, Зах зээлийг тэлэх буюу гадаад зах зээлд борлуулах	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.4	Малын гаралтай түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийхэд өрхийн үйлдвэрлэлд зориулагдсан шинэ техник технологийг нэвтрүүлэх	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.4	Малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.5	Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох	Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9 заасны дагуу ХХААХҮСайдаар батлуулахаар Малын бүртгэлийн журмын төслийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтээс санал авч эцэслэн боловсруулж байна. Тус журманд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн бүртгэлээр дамжуулан мал болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох заалтууд тусган бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг сайжруулах боломж бүрдсэн. Малын гаралтай түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал, орон нутагт түүхий эдийн тордолтын цэг байгуулах шаардлага, сайжруулах арга замын талаарх судалгааг хийсэн.
2.6	Уст цэгийн хайгуул судалгааны ажлыг орон нутгийн малчдын санал, санаачилгыг харгалзан улсын төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.6	Шинэ худаг гаргахад шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг ашиглагчаас нь гаргуулах замаар ашиглагчдын хариуцлагыг өндөржүүлнэ	2018 онд улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 154, гадаадын төсөл, хөтөлбөрийн 368.1 сая төгрөгөөр 26, орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгөөр 206 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачилгаар 296 гар худаг, нийт 6. 0 тэрбум төгрөгөөр 682 худаг гаргасан нь 930.5 мянган га бэлчээр буюу 2.7 мянган малчин өрхийн 1.4 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон.
2.6	Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан газрын гүнээс ус татах зориулалттай өргүүрээр инженерийн хийцтэй худгийг	Булган аймгийн Баян-Агт, Могод, Булган, Гурванбулаг, Хангал, Тэшиг, Хишиг-Өндөр, Баяннуур, Бугат сумдад инженерийн хийцтэй 9 худаг шинээр гаргаж, нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах ажлыг 247,640,814.0 төгрөгөөр гүйцэтгэн Булган аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон



	ТОНОГЛОХ	ажлын хэсэг улсын комиссоор хүлээн авч ашиглалтанд оруулсан.
2.6	Цас, борооны ус тогтоох, хөв цөөрөм байгуулах, гар худаг гаргах, бэлчээрийн тодорхой хэсгийг усжуулах арга ажиллагаанд малчдыг сургах	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.7	Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтадтай тэмцэх ажилд малчид, малчдын бүлгийн оролцоог хангаж түр ажлын байраар хангах	2018 оны бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 15 аймгийн 113 сум, отрын 3 бүс нутгийн 730.0 мянга га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажилд нийт 5200 гаруй хүнийг түр ажлын байраар хангаж нийт 306.8 сая төгрөгийн ажлын хөлс олгож ажилласан.
2.7	-	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.8	-	-
2.9	-	Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутагт ажиллаж байгаа болон ажиллахгүй байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехүүдийн судалгааг авч нэгтгэв. Манай улсын хэмжээнд 117 тэжээлийн үйлдвэр, цех байгаагаас 68 нь байнгын болон түр ажиллагаатай, 49 нь огт ажиллагаагүй байна. Судалгаан дээр тулгуурлан тэжээлийн үйлдвэрүүдийн байршлыг бүсчлэн гаргав. 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтад зориулж 22 аймаг, нийслэлийн бүх сум, дүүрэгт тэжээл худалдаалах цэгийг аж ахуйн нэгжүүдтэй хамтран байгуулав. Энэхүү тэжээл борлуулах сүлжээг цаашид тогтвортой байлгах чиглэлээр аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.
2.1	-	Манай улсад нутагшсан бургалтай сортын царгасны үр үржүүлэх аж ахуйн нэгжийг бий болгож байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад уурагт таримал тэжээл тариалах ажлыг эхлүүлж Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалах, үр үржүүлэх ажилд дэмжлэг үзүүлж тэжээл үйлдвэрлэлийг 2018 онд 1200 тн ногоон тэжээлээр нэмэгдүүлсэн ба царгасны үр үржүүлэх 720 га талбай, хөх тарианы үр үржүүлэх 200 га талбайг нэмэгдүүлж малын тэжээл тариалалтыг 0,03 хувиар өсгөсөн байна. Сайн чанарын тэжээлийн үр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх төслөөр тэжээлийн арвай, хошуу буудай, хөх тариа, царгасны үр үржүүлж нийт 192,2 тн-ыг бэлтгэж нийлүүлэх боломж бүрдсэн байна. “Атаршиж орхигдсон газрыг нөхөн сэргээж, таримал хадлан болгон ашиглах” сэдэвт инновацийн төслийг хэрэгжүүлж нийт 368 га талбайд нэг наст арвай, овъёос, хөх тариа, вандуй, олон наст царгасны нийт 73,6 тн үр цацаж тариалж тэжээлийн олон найрлагат эрдэс тэжээлийн бэлдэц нийт 7500 ширхэг буюу 37,5 тн үйлдвэрлэж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлсэн. Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилгоор “Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх” төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосноор энэ онд тэжээлийн ургамал тариалалт 1000 га-гаар нэмэгдэв.
2.11	-	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.
2.12	Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үүлдрийн үхрийг үржлийн аж ахуй байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2011 онд “Гацуурт” ХХК-тай байгуулсан “Махны цэвэр үүлдрийн үхэр импортлох үржлийн аж ахуй эрхлэх төсөлд дэмжлэг үзүүлэх” зээлийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг ажиллуулж, эргэн төлөлтийн 200 толгой өсвөр үхрийг хүлээн авч ХХААХУ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-135 дугаар тушаалаар хуваарилав. “Гацуурт” ХХК -иас эргэн төлөлтөөр авах 100 толгой хээлтүүлэгчээс аймгуудын ХХААГазарт дараах хуваарийн дагуу олгов. Сэлэнгэ-65, Дархан-4, Дорнод-5, Хэнтий-5, Төв-5, Архангай-5, УСҮТ-5, МХС-6, хээлтэгчээс УСҮТ-20, Үлдсэн 80 толгой хээлтэгчийг Мал хамгаалах сангийн мэдэлд авч төсөл сонгон шалгаруулалтаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгохоор бэлтгэл хангаад байна. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эрчимжүүлэх зорилгоор 2017 онд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр “Махны болон сүүний чиглэлийн үхэр” үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл шалгаруулалтыг зохион байгуулж нийт 52 аж ахуйн нэгжид үйл ажиллагаанаас нь хамааруулан 10-20 сая төгрөгийн хөнгөлөлттэй 5 жилийн хугацаатай зээл олгов. Нийт төсөвт өртөг 800.0 зуун сая төгрөг. 2018 онд сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа нийслэлийн ойролцоох аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг хэлэлцэн Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан нийт 39 төсөл ирүүлснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн малын чанарыг сайжруулах, фермийн байр засах, тэжээлийн нөөц бүрдүүлэх болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нь зориулж сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3,6 хувийн хүүтэй олгохоор ХХААХУС-ын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-163 дугаар тушаал гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулсан. Мөн энэ онд ЖДҮХС-аас төслийн шаардлага хангасан мах, сүүний үхрийн фермерийн 30 аж ахуйн нэгжид 14.1 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв. Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үүлдрийн үхрийн үржлийн аж ахуйг дэмжих зорилгоор 2018 онд Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Архангай Сэлэнгэ аймгууд болон Малын удмын сангийн үндэсний төвд Махын чиглэлийн лимузн, Улаан болон хар ангус үхрийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч нийт 188толгойг хөнгөлөлттэй зээлийн нөхцлөөр хүлээлгэн өгөөд байна.
2.13	-	Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэр төрлийг тогтоож, баримтлах жишиг үнийн тарифыг Хууль зүйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/222 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу боловсруулж Хүнс хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 18 -ний А-



		68 тоот тушаалаар батлуулж эрх зүйн актын улсын нэгдсэн бүртгэлийн 3911 дугаарт бүртгүүлээ. Мөн ХХААХҮ-ийн сайд аймгуудын ХХААГ-ын дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд 50.0 мянган мал тутамд нэг үйлчилгээний нэгж байгуулах талаар чиглэл өгч орон нутгийн удирдлагуудад зөвлөмж хүргүүлээ.
2.14	-	Хөдөлмөр халамж үйлчилгээний Ерөнхий газраас Зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй гэр бүлийг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгоход чиглэгдсэн юм. Улмаар энэ оны эхний 10 сарын байдлаар нийт 511 иргэн хамрагдаж 90,991.9 мянган төгрөг зарцуулж 511 ажлын байр бий болсон байна. Тодруулбал, Сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 6 аймгийн 30 бүлгийн 176 иргэд хамрагдаж 49,767.3 мянган төгрөгийг; Хорооны ажилгүй иргэдийг багийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 9 дүүргийн 56 багийн 335 иргэд хамрагдаж 41,224.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
2.15	-	Иргэдийн орон нутгаас нийслэл хот руу чиглэсэн хөдөлгөөнийг багасгах, нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж шинээр мал аж ахуй, газар тариалан эрхлэхийг санхүүгийн болон санхүүгийн бус хэлбэрээр дэмжих замаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын хүн амын төвлөлийг сааруулан, агаарын бохирдлыг бууруулах, улмаар малчид, тариаланчдын залуу халааг бэлтгэхэд аяны зорилгоор "Шинэ хөдөө шинэ амьдрал" аяны баримт бичгийг ХХААХҮ-ийн сайдын А-106 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж бүх яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх талаар Монгол улсын Засгийн газрын хуралдаанд мэдээлэл, танилцуулга хийж, 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэл гарсан. Энэхүү тэмдэглэлээр: 1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор иргэдийг байнгын ажлын байртай, тогтмол орлоготой болгох Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийг батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгав. 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт үүрэг болгов. Энэ хүрээнд: - Нэгдүгээрт, Хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгох зорилгоор "Гэрээт малчин – өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл"-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/206 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлээ.
3.1	-	Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль"-ийг баталж, нийгмийн даатгалын байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 4 жил гаруй хугацаанд уг хуулийг хэрэгжүүлснээр нийт 607,7 үүнээс 112.0 мянган малчин хамрагдаж 11 хүртэл жил ажилласнаар нөхөн тооцуулсан. Энэ хуулийн зорилт өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-2000 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох боломж олгосон болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль" баталсан. Энэ хуулиар 1995 оноос энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь тасарсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нар тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 хувиар тооцон нэг удаа нөхөн төлөх харилцааг зохицуулсан болно.
3.2	-	Монгол улсын хэмжээнд нийт 52,419 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагджээ. Нийт үзүүлсэн хүмүүсийн 66% (20,847) нь цалин хөлстэй ажиллагсад байсан бол үүний дараа хувиараа хөдөлмөр эрхлэгчид 27% (8,481)-ийг эзэлж байна. Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан, товлон, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцыг баталж, тогтвортой тогтолцоо бий болголоо. Энэхүү товлон, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцын хүрээнд 30 наснаас эхлэн нас, хүйсийн онцлогт нийцүүлж, элэг, бүдүүн шулуун гэдэс, ходоод, хөх, умайн хүзүү, түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгт Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хамрагдах боломж бүрдсэн. Энэхүү үйл ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойших 2 сарын хугацаанд 52 000 гаруй иргэн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна. Нийт үзлэгийн 67% (35,135) эмэгтэйчүүд давамгайлж, эрэгтэйчүүд 33% (178351)-тай байна. Үүнээс насны бүлгээр ангилахад 46-64 насны эмэгтэйчүүдийн хамрагдалт хамгийн өндөр 29%-тай байна. 2018 онд 158,065 малчныг даатгалд хамруулахаас 112,145 малчин иргэнийг хамруулж хамралт 71%-тай байна.
3.3	-	Сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс 2018 онд үндсэн мэргэжлээр нийт 63 их эмчийг төгсөлтийн дараах сургалтад элсүүлсний 61 буюу 96.8 хувьд, төрөлжсөн мэргэжлээр 5 их эмч элссэний 20 хувьд, төрөлжсөн



		сувилахуйгаар 63 сувилагч элссэний 53,9 хувьд төрийн сангийн санхүүжилт олгосон байна. Мөн онд 70 их эмч үндсэн мэргэжлээр төгссөний 53,8 хувь нь, төрөлжсөн сувилахуйгаар 52.2 хувь төрийн сангийн санхүүжилтээр суралцсан байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 "...өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн ..., тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох", 29.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох"-оор заасныг мөрдөн ажиллаж байна.
3.4	-	Монгол улсад 2018 онд зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог өвчнөөр ангилан үзэхэд тарваган тахал 0.5% (7), боом 0.8% (10), хачигт энцефалит 14.3% (181), хачигт боррелиоз 7.5% (96), хачигт риккетсиоз 64.7% (819), хумхаа 0.15% (2), галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан 9.6% (122), денге чичрэг 0.07% (1), бэтэг 2% (25), токсоплазмоз 0.07% (1)-ийг эзлэж байна. Сэжигтэй тохиолдлын тоо өнгөрсөн оныхоос 14.6% буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 61,4% өссөн байна. Үүнээс тарваган тахал, хачгаар дамжих халдварууд, галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулсан сэжигтэй тохиолдлын тоо өмнөх оноос буурсан байна. Мөн хачигт риккетсиозын 1, хачигт энцефалитын 1, нийт 2 нас баралт бүртгэгдсэн.
3.5	-	2018 оны 4-р сарын 26-28-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Монгол улсын Шадар сайдын 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журмыг хэрэгжүүлэх, үйл явдалд суурилсан тандалтын програмыг турших сургалт, дадлага сургуулилтыг амжилттай зохион байгуулагдлаа. Гамшгийн эрсдэлийг бууруулах, салбар хоорондын байгууллагуудын мэдээлэл солилцох механизмыг бүрдүүлэх, хамтын ажиллагаа, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг авах харилцааг зохицуулсан журмыг хэрэгжүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулахад дадлага сургуулилтын ач холбогдол оршино. Уг үйл ажиллагаанд Шадар сайдын ажлын алба, ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймгийн салбар хоорондын байгууллагуудын төлөөлөл 50 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан байна. Эрүүл мэндийн (Health Cluster)-ийн олон улсын хамтын ажиллагааны бүлгэмийн анхдугаар хурлыг зохион байгуулж, яаралтай тусламжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ОУ-ын байгууллагуудад танилцуулж, хэлэлцүүлэг хийлээ.
3.6	-	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/508 дугаар тушаалын дагуу 2018 оны 08 дугаар сараас эхлэн ЭМЯ-аас отроор яваа нийт иргэдийн тоо, түүнээс 5 хүртэлх насны хүүхдийн тоо, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, иргэдийн тоог 14 хоног тутам авч нэгтгэж дүгнэлт өгч, дээрх зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг авч ажиллаж байна. 2018 оны 12 сарын сүүлийн байдлаар ихэнх аймгийн нутаг дэвсгэрт цас бага тогтсон бөгөөд баруун аймгуудын нутгаар (Увс, Баян-өлгий, Завхан) цастай байна. 21 аймгийн хэмжээнд нийт 10077 иргэн отроор нүүдэллэж байгаагаас, жирэмсэн эх-237, 0-5 насны хүүхэд-1439, өндөр настан-681, хөгжлийн бэрхшээлтэй-292 болон архаг суурь өвчтэй-402 иргэд байна
3.7	-	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шатлал хоорондын зохицуулалтыг боловсронгуй болгох замаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болгож байгаа “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт”-ыг хэрэгжүүлж, “Хүн төвтэй тусламж үйлчилгээний цогц загвар”-ыг бий болгохыг зорин ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа төвөөс алслагдсан болон эмзэг бүлгийн хүн ам, малчдад сум, өрхийн эмч мэргэжилтнүүдээр дамжуулан хүргэж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, мобайл технологийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2015-2018 онд ДЭМБ, Солонгосын олон улсын эрүүл мэндийн сан, Солонгосын иргэдийн сангийн дэмжлэгтэйгээр 15 аймгийн 30 сумын ЭМТ, аймаг, дүүргийн 11 Өрхийн ЭМТ нийт 41 анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг 25 нэр төрлийн нэн шаардлагатай зөөврийн мобайл тоног төхөөрөмж, оношлуур, хэрэгслээр хангаж, эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулж, эмнэлгийн сурах бичиг, гарын авлагаар хангасан. Ингэснээр эмнэлгийн мэргэжилтний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвар нэмэгдэж, мобайл тоног төхөөрөмж ашиглан явуулын тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон. "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх" журмыг ЭМСС-ын 2016 оны А/147 дугаар тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна.
3.8	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн


		<p>A/26 тоот тушаал батлагдсан. Уг тушаалаар гэрээт малчин-өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрт ажил олгогч малчин болон гэрээт малчин өрхийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг, мөн гэрээт малчин өрхийн гэр бүлийн 2 гишүүний эрүүл мэндийн даатгалыг 100 хувь уг хөтөлбөрөөс хариуцахаар заасан. Уг хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр улсын хэмжээнд 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 448 гэрээт малчин нийгмийн даатгалд хамрагдсан байна.</p>
--	--	--

Эх сурвалж: ХХААХҮЯ (2019)

3.1.2 Хэрэгжсэн болон хэрэгжээгүй ажлууд

2017 он гэхэд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” –ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй байсан бөгөөд харин 2018 онд тус бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна ХХААХҮЯ (2018, 2019). Эдгээр тайлангуудад шинжилгээ хийхэд 2 жилийн хугацаанд тус бодлогын хүрээнд 169 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнээс хэрэгжээгүй 7 (4.1%), хэрэгжилт удаашралтай буюу 40%-ийн хэрэгжилттэй 59 (34.9%), хэрэгжилт сайн буюу 70%-ийн хэрэгжилттэй 64 (37.9%), хэрэгжиж дууссан буюу 100%-ийн гүйцэтгэлтэй 24 (14.2%), хугацаа нь болоогүй 15 (8.9%) ажил тус тус байна.

Зураг 2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт




Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)-ны тоо мэдээнд үндэслэсэн зохиогчдын тооцоо

Дээрх зургаас харахад 3 бодлогын чиглэл тус бүрт хэрэгжсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн түвшин ялгаатай байна. Тухайлбал, 2017-2018 онд 1-р чиглэл буюу малчдын тав тухтай амьдрах орчны бүрдүүлэхэд 39 ажил хийгдсэнээс 70-100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн ажлын тоо нь 22 (56.4%) байна.

Харин 2-р бодлогын чиглэл буюу үр ашигтай МАА эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд нийт 85 ажил хийгдсэн боловч тэдгээрийн 39 (46%) нь удаашралтай буюу 40%-ийн

гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2-р чиглэлийг хэрэгжүүлэх стратегийн зорилт бусад 2 чиглэлээс хавьгүй олон, хамрах хүрээ ихтэй байгаатай холбоотой.

Зураг 3. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, чиглэл тус бүрээр (%)



Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)-ны тоо мэдээнд үндэслэсэн зохиогчдын тооцоо

Дээрх зургаас харахад тухтай амьдрах 1-р чиглэлийн гүйцэтгэл 68%, малчдын боловсрол, эрүүл мэндийг сайжруулах 3-р чиглэлийн гүйцэтгэл 64% байгаа боловч үр ашигтай МАА эрхлэх 2-р чиглэлийн гүйцэтгэл 54%-тай байна.

Тус бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил тус бүрийн хэрэгжилтийн түвшинг Хавсралт 5-д харууллаа. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2017-2018 онд 24 арга хэмжээг 100% гүйцэтгэсэн бөгөөд үүнээс 46% нь 1-р чиглэл, 37% нь 2-р чиглэл, 17%-нь 3-р чиглэлийн хүрээнд хийгдсэн ажил байв.

Хүснэгт 4. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 100% хэрэгжсэн арга хэмжээнүүд

Бодлогын чиглэл	100% Хэрэгжсэн стратегийн зорилт		100%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн ажлын тоо		Нийт
	Дугаар	Стратегийн зорилт	2017	2018	
1	3	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхийг мал, амьтан, эд хөрөнгийн даатгал, санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах, хөрөнгийн гэрчилгээ, харилцах данс, бүртгэлтэй болгож банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, лизингийн үйлчилгээнд хамрагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2	0	2
	5	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн харилцааны хэв шинжийг судалж, туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан орлого багатай малчдыг өөр салбарт шилжин ажиллах, бизнес эрхлэхийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;	1	1	2
	6	Малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх;	1	0	1
	7	Мал аж ахуйн салбарт хүүхэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, шалгуурыг тодорхой болгож, тус салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг арилгах бодлого хэрэгжүүлэх;	0	1	1
	8	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээ авах;	3	1	4
	11	Бэлчээрийн мал аж ахуй эрхлэж байгаа өрхийг эдийн засгийн ашиг сонирхол	1	0	1



		дээр тулгуурласан малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр хамтын аж ахуй эрхлэх эрх зүй, санхүү, эдийн засгийн нөхцөлийг бий болгон хөгжүүлэх;			
		Нийт	8	3	11
2	6	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт, түүнийг хэрэглэх заавар, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;	0	1	1
	7	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгөөр усны хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг гаргах, засварлахын зэрэгцээ малчдын үүсгэл, санаачилгаар худаг гаргах, засварлах, цас, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрөм байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих;	0	1	1
	11	Малчин өрх бүрийг 2015 он гэхэд 100 хувь радиотой болгох, цахилгааны эх үүсвэртэй болгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх, малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээллийг гар утсаар хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;	3	0	3
	12	Малчдыг байгалийн гамшгийн үед өмсөхөд зориулсан дулаан, тохиромжтой хувцсаар хангах, энэ чиглэлээр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	0	1	1
	15	Тэжээлийн нөөцийн хэмжээ, хүртээмж, байршлыг оновчтой тогтоох, түүний хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын менежментийг сайжруулах, сум, багийн түвшинд өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээ бий болгох;	3	0	3
		Нийт	6	3	9
3	2	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;	0	1	1
	3	Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, холбоог бэхжүүлэх зорилгоор тэдгээрийг гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөрт хамруулах;	3	0	3
		Нийт	3	1	4
		НИЙТ ДҮН	17	7	24

Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)

Тус бодлогод тусгагдсан ч хэрэгжээгүй ажлын жагсаалтаас харахад (Зураг 4), 7 стратегийн зорилттой холбоотой ажлууд хэрэгжээгүйгээс 3 нь 2-р чиглэлийн арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 5. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хэрэгжээгүй арга хэмжээнүүд

Он	Чиглэл	Хэрэгжээгүй буюу ямар нэгэн ажил хийгдээгүй стратегийн зорилт	
		Дугаар	Стратегийн зорилт
2017	1	9	Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлэх;
	2	7	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгөөр усны хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг гаргах, засварлахын зэрэгцээ малчдын үүсгэл, санаачилгаар худаг гаргах, засварлах, цас, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрөм байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих;
	2	9	Шилжин суурьшсан малчин байсан иргэдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээнд хамруулах, ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх;
	2	10	"Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
	3	12	Орлого багатай малчдыг бусад төрлийн аж ахуй эрхлэх, бие даан бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ, чадавх, санаачилгыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх;
2018	1	2	Хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлж, бэлчээр ашигласны төлбөрийг эдийн засаг, экологийн үнэлгээнд үндэслэн ялгавартай тогтоох, уг төлбөрийн 30-аас доошгүй хувиар сумын бэлчээр хамгаалах, сэргээх болон мал аж ахуйн эрсдлийн сан байгуулж, зарцуулж байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
	2	8	Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, тэжээл бэлтгэх зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулах;

Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)

Төлөвлөгдсөн ажил хэрэгжихэд орон нутагт үүсч байгаа хүндрэл бэрхшээлүүдийн талаар Увс аймгийн ХХААГ-ын холбогдох албан тушаалтнууд онцлон хэлсэн (Хавсралт 2). Тухайлбал, аймгийн ХХААГ-аас Мал эмнэлгийн алба тусгаарлагдаж, Мал эмнэлгийн газар (МЭГ) байгуулагдсан нь хоорондын ажил үүргийн уялдаа, харилцаа алдагдсан. Аймгийн МЭГ босоо тогтолцоотой болсон нь ХХААГ-тай хамтран ажиллах байдал суларсан. Цаашилбал, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулинд тус хуулийг



хэрэгжүүлэх төсөв санхүүгийн асуудал тодорхой тусгагдсан тул энэ хуулийн хэрэгжилт нь Малын генетик нөөцийн тухай хуулийг бодвол илүү хэрэгжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, хуулийн хэрэгжилтэд олгох төсвийг ижил зарчмаар оновчтой хуваарилах шаардлагатай байна.

3.1.3 Зарцуулагдсан төсөв

Улсын төсвөөс

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зориулж улсын төсөв хөрөнгө суулгаж байгаагүй. Гэхдээ мал аж ахуйн салбар, тэр дундаа малчдын амьжиргааг дээшлүүлэх, орон нутгийн дэд бүтэц, зам, эмнэлэг, сургууль барих ажил жил бүр орон нутагт хийгддэг. Гэвч улсын төсвөөс тус бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилт олгодоггүй. Хэдийгээр тус бодлогод зориулж улсын төсвөөс хөрөнгө зарцуулдаггүй ч бусад төрлийн үйл ажиллагааны санхүүжилтэд тус бодлогод туссан ажлууд хийгддэг.

Орон нутгийн төсвөөс

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д зарцуулсан орон нутгийн төсвийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зарцуулсан орон нутгийн төсөв (21 аймаг, нийслэлийн хэмжээнд)


№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 оны 9-р сарын байдлаар	Нийт	Дундаж
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Сая.төг)	916.5	861.2	881.7	1,082.4	3,741.8	935.5
2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Сая.төг)	70.3	70.8	82.7	272.8	496.6	124.2
3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтанд зориулан зарцуулсан зардал (Сая.төг)	17.8	332.2	279.1	163.8	792.9	198.2
4	Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлахад зарцуулсан зардал (Сая.төг)	1,231.0	1,520.1	1,454.5	2,397.4	6,603.0	1,650.8
5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Сая.төг)	291.7	242.0	370.2	232.9	1,136.8	284.2
6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Сая.төг)	22.5	38.0	41.5	38.3	140.3	35.1
7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Сая.төг)	35.5	41.7	43.8	42.0	163.0	40.8
8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Сая.төг)	20.7	40.4	62.7	60.6	184.4	46.1
9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Сая.төг)	300.4	301.9	515.9	464.5	1,582.7	395.7
10	Дэд бүтцийн зардал (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Сая.төг)	58.1	59.0	585.0	2,221.3	2,923.4	730.9
11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Сая.төг)	158.7	144.3	192.2	223.6	718.8	179.7
Нийт (Сая.төг)		3,123.1	3,651.6	4,509.3	7,199.5	18,483.5	4,620.9
Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь (%)			17%	24%	60%	-	33%

Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь олон нийтэд хэвлэгдэж байгаагүй тоо мэдээ)

Эндээс харахад орон нутгийн төсвөөс 2016-2019 онд нийт 18.5 тэрбум төгрөг, жилд дунджаар 4.6 тэрбум төгрөгийг “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулсан ба орон нутгийн төсвийн зарцуулалтын өсөлт жилд дунджаар 33%-иар өсч байна. Хавсралт 3-т орон нутгийн төсвөөс “Төрөөс

малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардлыг аймаг, нийслэл тус бүрээр задлан харуулав.

Зураг 4. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зарцуулсан орон нутгийн төсвийн бүтэц (%)




Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй тоо мэдээ), Зохиогчдын тооцоолол

Дээрх зургаас харахад 2016-2019 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д зарцуулагдсан орон нутгийн нийт төсвийн 35.7%-ийг ус, худаг гаргах, 20.2%-ийг малын эрүүл мэндийг сайжруулах, 15.8%-ийг дэд бүтэц буюу зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт хөрөнгө оруулалтад, үлдсэн 29.3%-ийг бусад үйл ажиллагаанд зарцуулжээ.

2019 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д 7.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан өмнөх онуудаас хамгийн өндөр байна. Үүний гол шалтгаан нь 2.2 тэрбум төгрөгний дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зардал (Завхан аймагт 1.5 тэрбум төгрөгний зам тавьсан, мөн 350 сая төгрөгөөр МАА-н түүхий эд боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж авсан гэх мэт) энэ онд гарсантай холбоотой. Сүүлийн 4 жилд тус хөтөлбөрт зарцуулсан төсвийг дараах зурагт үзүүлэв.

Зураг 5. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д зарцуулсан орон нутгийн төсвийн зардал



Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй), Зохиогчдын тооцоолол

3.2 БОДЛОГОД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.2.1 Бодлого хэрэгжүүлснээр гарсан үр дүн (Ерөнхий)

Улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

Хүснэгт 7. “Төрөөс малчдын талаар баримтлах” бодлогын улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

Үндсэн чиглэл	Хийгдсэн ажил-Үр дүн
2.2.1.хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх;	Малчдын төрийн бодлогын талаарх ойлголт нэмэгдсэн.
2.2.2.төрөөс малчин өрхийн эдийн засгийн чадавх, бололцоо, хүсэл сонирхолд нь нийцсэн дэмжлэг үзүүлэх;	21 аймгийн 332 сум, нийслэлийн 6 дүүргийн нийт 92,885 малчин, мал бүхий этгээдэд, нийт 20,599 тонн ноосонд 22.6 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.
-	21 аймгийн 332 сум, нийслэлийн 6 дүүргийн нийт 64,255 малчин, мал бүхий этгээдэд, нийт 3,124,932 ширхэг арьс, ширэнд 12.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.
2.2.3.хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, тэргүүний арга, туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эзэмшүүлэх, нутагшуулах;	Сүү-ноосны чиглэлийн “Ламын гэгээний улаан” тэмээг үржлийн хэсгээр, Ноолуурын чиглэлийн “Эрчим хар” ямаа, мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Сутай” хонь, өөх-мах-бүдүүвтэр ноосны чиглэлийн Цагаан-Уул хонийг үүлдрээр тус тус баталгаажуулахаар ажлын хэсгийн тайлан, хянан магадлагааны дүн, 2018-2028 онд явуулах үржил селекцийн ажлын төлөвлөгөө, үржүүлгийн бүдүүвч зэргийг ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бие даасан үүлдэр, үржлийн хэсгээр тус тус баталгаажуулав. Үүний дүнд Монгол улсад баталгаажсан үүлдэр, омгийн малын тоо 47 болов.
-	Сүү болон сүү-махны, махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн үржлийн аж ахуй байгуулах төсөл сонгон шалгаруулж “Газар агро” ХХК ОХУ -аас 150 толгой махны чиглэлийн Геррефорд үүлдрийн үхэр, “Сэлэнгэ тариа” ХХК Герман улсаас Лимүзэн үүлдрийн 60 толгой үхрийг тус тус импортлон үржлийн аж ахуй байгуулав (Энэ ажилд 2 тэрбум төгрөгний хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн).
-	Франц улсаас Махны чиглэлийн Суффолк үүлдрийн эм хонь-161, хуц-10, Меринос үүлдрийн эм хонь -205, хуц-10, Бершон душер үүлдрийн эм хонь-190, хуц-10, Романов үүлдрийн эм хонь-65, хуц-6 толгой, нийт 621 толгой үржлийн эм хонь, 36 толгой хуц бүгд 657 хонийг импортлон үржлийн аж ахуй байгуулав.
2.2.4.малчин хүний ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах, туслан хөгжүүлэх үйл ажиллагааг аль болох анхан шатны нэгжид, баг, хорооны түвшинд хөхүүлэн дэмжих;	Жилдээ дунджаар нэг суманд сумын аварга малчин 10, аймгийн аварга малчин 30, улсын аварга 100 орчим жил бүр шалгаруулдаг. Нийт дүндээ дунджаар улсын хэмжээнд сумын аварга малчин 3300, аймгийн аварга малчин 630, улсын аварга малчин 100 гаар тооцоход нэг жилд ямар нэгэн хэмжээгээр 4000 гаруй малчин аварга болдог.
-	Ангус үүлдрийн 140 үхрийг ХХААХҮ-ийн сайдын А-146 тушаалаар хээлтүүлэгчийг аймгуудад, хээлтэгчийг ААН, иргэдэд эргэж төлөгдөх нөхцлөөр гэрээ байгуулан олгов.



-	- 22.7 сая төгрөгийн үнэ бүхий “Хүчит тэжээлийн цех”-ийг 1 аж ахуйн нэгжтэй түрээсийн гэрээ байгуулж олгов. - 5 ширхэг хаман боогчийг Дархан-Уул, Улаанбаатар, Хэнтий аймагт тус бүр 1, МСҮТ-д 2 ширхгийг лизингээр олгов. - 53.3 сая төгрөгийн үнэ бүхий хадлангийн иж бүрдэл техникийг Завхан аймгийн Улиастай сумын ЭМАА эрхлэгч иргэнд 7 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулан олгов. - Таримал тэжээл тариалах, тэжээлийн нөөц бий болгох зорилгоор 3 аж ахуйн нэгжид 300.0 сая төгрөгийн зээл олгов.
-	- 44 аж ахуйн нэгжид 655.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгов. - 60 эх зөгий, үүр хайрцгийн хамт 4 иргэн аж ахуйн нэгжид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгов.
-	Малчдад өгөх уламжлалт зөвлөгөө, Малчин түмний алдар зэрэг брошур номуудыг хэвлэн олны хүртээл болгосон. • Аж ахуй эрхлэлт, мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага солилцох уулзалтанд 1859 өрхийн 2458 малчин иргэн хамрагдаж 145,676.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.
-	Нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүсэн эхийн хүүхдээ харах хугацааны НДШ-ийг тэтгэмжийн даатгалын сангаас, бусад (ажил хөдөлмөр эрхэлж байсан эх хамаарахгүй) эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг төрөөс, 50 хувийг эх өөрөө хариуцахаар; • Нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулж тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцон тэтгэмж олгож байсныг 100 хувиар тооцож олгохоор; • "Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцохоор. • Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол, нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан.
-	Уг хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 12 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 3173 малчин өрхийн 4886 малчин иргэн хамрагдаж, 4,515,735.52 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.
-	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан болон Сум хөгжүүлэх сангаас нийт 1158 төсөлд 73 тэрбум 452 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгов. 2017 он хүртэл мал хамгаалах сангаар дамжуулан 53.3 сая төгрөгийн үнэ бүхий 25 ширхэг хадлангийн иж бүрдэл, 36.0 сая төгрөгийн үнэ бүхий 53 ширхэг том, жижиг өвс хаман боогч, 40.6 сая төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг, тэжээлийн үйлдвэр хөнгөлөлттэй үнээр олгов. 2013 онд Ховд, Увс, Завхан, Баянхонгор аймгуудад худгийн өрмийн машин олгосноор 2016 оны байдлаар 1,3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 77 худаг гарган бэлчээр ашиглалтыг сайжруулав.
-	“Ногоон ажлын байр-Чацаргана” дэд хөтөлбөрийн хүрээнд малчдад жимсний суулгац олгох тэдгээрийг тарих хураах, ажиллагааг хөнгөвчлөх, жимсний модыг өвчин хортон, мэрэгчдээс хамгаалах бодис, багаж, тоног төхөөрөмж авах, жимст цэцэрлэг үржүүлгийн талбайг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 120.0 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна.
-	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаар дамжуулан 2017 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 2811 малчин өрхийн 4332 малчин иргэн хамрагдаж 4,081,247.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнийг арга хэмжээ тус бүрээр авч үзвэл: • Малжуулах арга хэмжээнд 952 малчин өрхийн 1874 малчин иргэн хамрагдаж 35742 хонь, 42848 ямаа, 2341 үхэр, 176 адуу, 2 тэмээ худалдан авахад 3,935,571.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
-	Малчдын нийтийг хамарсан ажлын хөтөлбөрт хамрагдах, өвөлжөө, хаваржаагаа барих, засах ажлыг дэмжих, хүнсний ногоо тариалах хүлэмж барих, аялал жуучлалын гэр буудал барих зэрэг ажлуудыг дэмжих зорилгоор 15 аймгийн 45 сумын нийт 497 малчин өрхөд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаар дамжуулан нийт 841,2 сая төгрөгийг зарцуулав.
-	2017 оны улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 аймаг, отрын бүс нутагт 110, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 110, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 15, усны өрөмдлөгийн машины түрээсийн гэрээгээр 53, нийт 288 инженерийн хийцтэй худгийг шинээр барьж ашиглалтанд оруулснаар 432.0 мянган га бэлчээр, 806.4 мянган мал сүрэг, 1400 гаруй малчин өрхийн усан хангамжийг шийдвэрлэх боломж бүрдэх юм (200 гаруй худгийн ажил дууссан).
-	ЭМААХД хөтөлбөр болон “Монгол мал” хөтөлбөрийн санхүүжилтээр 2016 оны байдлаар малчдыг эрчимжсэн аж ахуй эрхлэхэд зориулан 218 тэрбум төгрөг, малын тэжээлийн хангамжийг сайжруулахад 3.5 тэрбум төгрөг, малчдын бүлгийг дэмжихэд 1.3 орчим тэрбум, “Хоршооллыг дэмжих жил”-ийн хүрээнд 19 аймгийн 96 хоршоонд 2.5 тэрбум төгрөгийг тус тус хөнгөлөлттэй зээл, болон тоног төхөөрөмжийн хөнгөлөлт үзүүлэв.



<p>2.3.3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах.</p>	<p>“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төслийг хэрэгжүүлснээр 15 суманд 120 малчны бүлэг байгуулагдаж тэдгээрт хамрагдаж буй 2771 орчим малчин өрхийн 10543 ам бүл төслийн үр шимийг хүртэх боломжтой болсон байна.</p>
<p>-</p>	<p>-</p>
<p>-</p>	<p>- Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, Сумын хадлангийн нөөц бэлтгэх зорилгоор өссөн дүнгээр 2015-2016 он 12 суманд 70,000 гаруй бэлчээрийг хамгаалалтад авсан, - Бэлчээр, хадлангийн талбайд олон наст ургамлын үрийг цацах зэрэг туршилт, үзүүлэх сургалтын журмаар хэрэгжүүлэх, бэлчээрийн төлөв байдлыг энгийн аргаар хянах (фото мониторингийн) аргыг сумдад нэвтрүүлсэн байна. Ногоон алт малын эрүүл мэнд төслийн нэгдсэн үе шатанд төсөл бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, малчдын хоршооны зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 11 байгууллагатай 12 гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс малчдыг БАХ-ийн зохион байгуулалтанд оруулах, БАГэрээгээр дамжуулан бэлчээр сайжруулах, малчдын байгууллагыг хөгжүүлэх ажлыг МБАНХолбоогоор дамжуулан хэрэгжүүлснээр төсөлд нийт 21 аймгийн 186 сум хамрагдаж байгаа нь Монгол орны нийт сумын 56 хувь болж байна. Малчдын байгууллагын эгнээ өргөжиж, 2017 онд эдгээр аймагт 5 АБАХ, 24 СБАХ, 147 БАХ шинээр байгуулагдсанаар нийт 12 АБАХ, 121 СБАХ, 1362 БАХ-ийн үйл ажиллагаа явуулж байна. МБАНХ нь БАХэсэг, малчдын эрх ашиг, сонирхлыг хамгаалах үндэсний хэмжээний дээвэр холбоо болж олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж байна. Үүний нэг баталгаа нь МБАНХ 2017 онд уул уурхайн 2 компани, олон улсын 2 байгууллагатай 2 аймгийн 4 суманд БАХ/БАГэрээний аргачлалыг нэвтрүүлэхээр байгуулсан гэрээ харуулж байна. МБАНХ-ноос төрийн болон төрийн бус, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, хувийн хэвшлийн болон малчдын 250 гаруй төлөөлөл оролцсон Монгол орны бэлчээрийн доройтлыг хязгаарлах, зүй зохистой ашиглалтыг нэвтрүүлэх, зохицуулалт, хариуцлагыг өндөржүүлэх бодлогын шинэчлэл, арга хэмжээний үндсэн чиглэлээр салбарын мэргэжилтнүүд болон ашиглагчид нэгдсэн ойлголтод хүрэх, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах зорилго бүхий "Монгол орны Бэлчээрийн үндэсний форум"-ыг анх удаа Монгол улсад амжилттай зохион байгууллаа. ХХААХҮЯамнаас МБАНХ-ны үйл ажиллагааг дэмжиж буйгаа илэрхийлж тус форумыг хамтран зохион байгууллаа. БАХ/БАГ-т суурилсан зохион байгуулалт, түүний үр дүн, ач холбогдлыг хөрш зэргэлдээ орнууд сонирхох болсноор Киргиз улсын ХААЯ-ны төлөөлөл, холбогдох мэргэжилтнүүд НАМЭМ төсөл, МБАНХ-ны туршлага судаллаа. Мөн Туркменистан улсын зүгээс МАА-н үйлдвэрлэл, бэлчээр зохион байгуулалтын анхан шатны бүтцийг бэхжүүлэх, улмаар хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор БАХ/БАГ-т суурилсан зохион байгуулалтын арга аргачлалыг нэвтрүүлэх хүсэлтээ ирүүлсний дагуу МБАНХ-ы мэргэжилтнүүд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.</p>
<p>-</p>	<p>ХХААЯ 2015 онд малчдаас бэлчээр ашигласны төлбөрийг бэлчээрийн байршил, төлөв байдал, малын төрлөөр ялгавартай тогтоож авах, уг төлбөрийн 80 хувийг сумын Мал аж ахуйн хөгжилд зарцуулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ онд хүн амын орлогын албан татварын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж малчдаас бэлчээр ашигласны төлбөрийг авах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр санал боловсруулан малчдаас санал авч холбогдох яамдтай хамтран ажиллаж байна.</p>
<p>3.1.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хүрэлцэх хэмжээний газрыг эзэмшүүлэх, отрын бүс нутаг байгуулах, сумдад бэлчээр ашиглалтын хороог ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p>	<p>“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн боловсруулах, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцооллыг хийх ажлыг махны үхэр, сүүний үхэр, хосолмол ашиг шимт үхэр, гахай, шувуу, зөгийн аж ахуй тус бүрээр тодорхойлох ажлыг гүйцэтгэж, мэргэжлийн холбоодтой хэлэлцүүлэг хийсэн. Тус хөтөлбөрийн төслийг боловсруулж, яамдаас санал авахаар хүргүүлээд байна.</p>
<p>-</p>	<p>2017 онд нийт 24,148 малчин өрхтэй МИД-ын гэрээг байгуулж, 2 тэрбум 329 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15.3 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5,410 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Малын даатгалыг өргөжүүлэх, сурталчлах зорилгоор “Малчдад ээлтэй багийн Засаг дарга” уралдааныг нийт 21 аймгийн 330 сумын 1600 багийн Засаг дарга нар дунд зохион байгуулсан Аймаг, сумдад зохион байгуулж буй малчдын зөвлөгөөн, уулзалтын үеэр МИД-ын талаар танилцуулга хийж, телевизийн 2 нэвтрүүлэг, 3 төрлийн шторк, Үндэсний радиогоор 4 төрлийн яриа нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн.</p>



	<p>Даатгалын сурталчилгааг Малчдадаа зориулан цаг тооны бичиг 20.0 мянган ширхгийг, “Даатгал” сонинг 40.0 мянган ширхэг, Төрийн болон Хаан банкны сурталчилгааны зурагт хуудас нийт 1000 ширхэг, 2000 ширхэг гарын авлагыг тараасан.</p>
	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “хөлсөөр мал маллаж байгаа ажилтны хөдөлмөрийн харилцаа”-тай холбоотой зохицуулалтыг шинээр тусгаж өгсөн.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хөлсөөр мал маллаж байгаа ажилтны цалин хөлсний 30 хувиас дээшгүй хувийг чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн, бусад эд хөрөнгөөр орлуулж болохоор заасан. Түүнчлэн хөлсөөр мал маллаж байгаа ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, амралтын асуудлыг тусгаж өгсөн.</p>
3.1.6.Малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх;	<p>Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр УИХ-аар баталсан. Энэ хуулийн зорилт нь нийгмийн шилжилтийн явцад хөдөлмөр эрхлэлтийн статус нь өөрчлөгдөж, эрхэлж байгаа ажил, үйлчилгээний онцлогоос хамааран тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн хугацаанд нь төлж чадаагүй малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжих юм.</p>
	<p>Нийт 11 аймаг, нийслэлийн ойролцоо, мах болон сүүний үхрийн аж ахуй эрхэлж буй 54 аж ахуйн нэгжид тус бүр 10-20 сая төгрөгийг жилийн 3,6 хувийн хүүтэй, 5-н жилийн хугацаатай, нийт 800.000.000.0 (Найман зуун сая) төгрөгийн зээлийг олгов.</p> <p>Улсын хэмжээнд 280.4 мянган малыг үзлэг, ангилалтанд хамруулахаар аймгуудын ХХААГ-тай гэрээ байгуулан хавар, намрын үзлэг, ангилалтын ажлыг технологит хугацаанд нь зохион байгуулав. Үзлэг ангилалтанд хамрагдсан 13 аймгийн ХХААГ-аар нь 45 сумын 27 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан 286.1 мянган малын анги чанарыг тогтоов. Ангилалтанд хамрагдсан нийт малын 80.1 хувийг бог, 19.9 хувийг бод мал эзэлж байна. Үзлэг ангилалтын дүнгээр нийт малын 19.3 хувь буюу 55.1 мянга нь цөм, 52.2 хувь буюу 149.3 мянга нь үржлийн, 28.5 хувь болох 81.5 мянган мал хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн байна. Үзлэг ангилалтанд хамрагдсан хээлтүүлэгчийн 41.0 хувь (7,403), хээлтэгчийн 17.8 хувь (47,700) нь цөм сүргийн шаардлага хангаж байна.</p>
	<p>Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд 120 малчдын бүлэгт 2,771 өрх, Ногоон алт малын эрүүл мэнд төслийн хүрээнд 1,362 бэлчээр ашиглагчдын хэсэгт 14,500 малчин өрх хамрагдан малын чанар сайжруулах, бэлчээрийг зохистой ашиглах зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөрөө хоршин ажиллаж орлогоо 20 хүртэл хувиар өсгөсөн.</p> <p>Мөн хүнсний ногоо, малын ногоон тэжээл тариалах, хадлан хамтран бэлтгэж өрхийн хэрэгцээнээс илүү гарсан бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж мал аж ахуйгаас өөр орлогын эх үүсвэрийг бий болголоо.</p>
3.2.1.эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, чанарыг сайжруулах;	<p>2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр улсын хэмжээнд 1,727 аж ахуйн нэгжид 74 мянган толгой сүүний чиглэлийн үхэр, 236 аж ахуйн нэгжид 28.7 мянган толгой махны чиглэлийн үхэр, 1511 аж ахуйн нэгжид 353.1 мянган толгой мах, ноосны хонь, 34 фермд 13.1 мянган толгой гахай, 40 фермд 766.9 мянган толгой тахиа, 31 ферм, 397 өрхийн 11,492 бүл зөгий тоологдлоо.</p>
3.2.2.Малчдын өөрсдийнх нь санал болгосон хүнийг тусгайлан сургах замаар малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн удирдлагыг бэлтгэх арга хэмжээг төрөөс санаачлан хэрэгжүүлэх, орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нарт энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;	<p>НАМЭМ төсөлд шинээр хамрагдсан 11 аймаг, 40 суманд байгуулагдсан БАХ-ийг чадавжуулах зорилгоор “Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох”, “Малчдын байгууллагыг байгуулах, хөгжүүлэх” чиглэлээр МБАНХ-ноос 4 үе шаттай сургалт семинарыг БМАХ-ийн 639 гишүүнд зохион байгуулсан.</p>
	<p>“MDM” ХХК-ийн санаачлан боловсруулсан “Монгол хуурай сүү” Хөгжлийн банкнаас эхний ээлжийн санхүүжилт болох 25.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авч, Хөвсгөл аймгийн Их-Уул суманд хуурай сүүний үйлдвэр байгуулсан.</p> <p>“Мах, сүүний анхдугаар аян”-ыг улсын хэмжээнд зохион байгуулахаар 5 зорилт, 50 арга хэмжээг тусгасан төлөвлөгөө боловсруулж, ХХААХУ-ийн сайдын 2017 оны А-45 дугаар тушаалаар батлуулсан байна.</p> <p>Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд “Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан нийт 15.8 мянган тн махыг өвөлжилт хүндэрсэн орон нутгаас бэлтгэсэн. Тус арга хэмжээнд хамрагдсан 13 үйлдвэр, аж ахуйн нэгжид Хөгжлийн банк, арилжааны банкнаас олгосон 63.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлсэн. Орон нутгаас бэлтгэсэн махыг 2017 оны 4-7 дугаар сард Улаанбаатар хотын 6 дүүрэгт 118 дэлгүүрээр, Орхон аймагт 6 дэлгүүрээр, Дархан-Уул аймагт 118 дэлгүүрээр дамжуулан үхрийн кг махыг 5750 төгрөг, ямааны махыг 4400, хонины махыг 5400 төгрөгөөр тус тус худалдан борлуулсан. Энэ нь хаварт махны хомсдол, үнийн хөөрөгдөл үүсэхээс сэргийлж, зах зээл дэх үнээс үхрийн махны хувьд 38 хувиар, хонины махны хувьд 26.7 хувиар, ямааны махны хувьд 9.7 хувиар тус тус хямд байсан ач холбогдолтой.</p>



	<p>Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр өвөлжилтийн бэлтгэлийн дутууг хангах, мал, мах бэлтгэлийн ажлыг эрчимжүүлэх, махны үйлдвэр, малчдын хооронд гэрээ байгуулан борлуулалт хийх ажлыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.</p>
	<p>Ноолуур хөтөлбөрийг батлуулсан.</p>
	<p>Мах-сүүний анхдугаар аяныг зарлан хэрэгжүүлж байна.</p>
	<p>Засгийн газрын 2016 оны "Үндэсний аян өрнүүлэх тухай" 212 дугаар тогтоолоор "Мах, сүүний анхдугаар аян"-г шинээр, "Атрын III аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p>
	<p>"Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 13 үйлдвэр, аж ахуйн нэгжид Хөгжлийн банк, арилжааны банкнаас олгосон 63.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлсэн. Хэнтий аймгийн Баянхутаг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дорнод аймгийн Баян-Уул, Баян-Дун, Дундговь аймгийн Өлзийт, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Баянхонгор аймгийн Бууцагаан, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын барилгын ажил дууссан.</p>
	<p>Мөн ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран орон нутагт "ээдэмцэр" бүтээгдэхүүнийг лабораторийн түвшинд үйлдвэрлэж, үйлдвэрт нэвтрүүлэх, нутагшуулах, зорилгоор туршилтын ажлыг эхлүүлсэн.</p>
	<p>Үйлдвэрлэх бүтээгдэхүүний дээж "ээдэмцэр" - ийг бэлтгэх туршилтыг 2 удаагийн давтамжтайгаар 3 удаа зэрэгцээ явуулж, бэлэн болсон 11 дээжийг Япон улсад шинжлүүлэхээр хүргүүлсэн. Мөн төслийн хүрээнд хөдөө орон нутаг байгуулах бага оврын, сэргээгдэх эрчим хүчийг ашиглан ажиллуулах хөргөлттэй тасгийг Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд байгуулахаар ажиллаж байна.</p>
	<p>Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар тогтоолоор "Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт"-ыг батлуулсан. Уг тогтоолын хүрээнд мах, сүү боловсруулах салбарын импортоор авсан мах, сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлсөн.</p>
	<p>НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын шугамаар хэрэгжүүлж буй "Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төслийн дэмжлэгээр "Ээдэмцэр" кластер төсөлд хэрэглэх сүүний микро шүүлтүүр, ультра шүүлтүүрийг нийлүүлсэн.</p>
	<p>Орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан байгуулах хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг танилцуулах практик сургалт, хэлэлцүүлгийг "MDM" ХХК-тай хамтран 2017 оны 2-р сард зохион байгуулсан. Тус сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгаас болон Улаанбаатар хотоос сүү үйлдвэрлэгчид, фермерүүд, хоршоологчид, сүүний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл нийт 100 гаруй хүнийг оролцуулсан.</p>
	<p>Төслийн хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дорнод аймгийн Баян-Уул, Баян-Дун, Дундговь аймгийн Өлзийт, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Баянхонгор аймгийн Бууцагаан, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд үйлдвэрийн барилгын ажил дууссан.</p>
	<p>Хуурай сүүний 30 үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 2018 оны 2 дугаар сард импортоор оруулж ирээд байна. Хэнтий аймгийн Баянхутаг суманд үйлдвэрийн тоног төхөөрөмж угсралтын ажлыг гүйцэтгэж бэлэн болгосон. Дараагийн шатанд Өвөрхангай аймгийн Богд, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Булган аймгийн Хутаг-Өндөр, Хөвсгөл аймгийн Галт суманд тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлсэн.</p>
	<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон орон нутгийг хөгжүүлэх сангийн зээлийн дэмжлэгтэйгээр 2016-2017 онд дараах мал төхөөрөх, боловсруулах үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулсан. Үүнд:</p>
	<p>1) Ховд аймгийн "Жаргалант шанд" ХХК нь өөрийн хөрөнгөөр хоногт 500 бог, 100 бод төхөөрөх хүчин чадалтай, 100 тн хөргүүртэй зоорь бүхий мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр.</p>
	<p>2) Орхон аймгийн "Жаргалант мах импекс" ХХК нь өөрийн хөрөнгөөр хоногт 100 бог, 20 бод төхөөрөх хүчин чадалтай, 200 тн хөргүүртэй зоорь бүхий мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр.</p>
	<p>3) Баянхонгор аймгийн "Мах март" ХХК нь өөрийн хөрөнгөөр Баянхонгор суманд хоногт 500 бог, 50 бод төхөөрөх хүчин чадалтай, 250 тн агуулах зоорь бүхий мах бэлтгэх, боловсруулах үйлдвэр.</p>
	<p>4) Говь-Алтай аймагт "Алтайн сүрлэг нуруу" ХХК өөрийн хөрөнгө болон Орон нутгийг хөгжүүлэх сангаас 60 сая төгрөгийн зээл авч хоногт 100 бод, 250 бог төхөөрөх хүчин чадалтай, 100 тн хөргүүртэй зоорь бүхий "Түмэн уул" мах бэлтгэх боловсруулах үйлдвэр.</p>
	<p>5) Төв аймгийн "Баяндэлгэр хүнс" ХХК нь Сингапур Улсын хөрөнгө оруулалтаар хоногт 100 бог, 50 бод төхөөрөх хүчин чадалтай, 20 тн хөргүүртэй зоорь бүхий мах бэлтгэх, ангилж вакуумжуулан савлах, үйлдвэрийг Баяндэлгэр суманд.</p>
	<p>6) Улаанбаатар хотын "Саян уул" ХХК нь өөрийн хөрөнгөөр СХД-гийн Эмээлтэд хоногт 300 бог, 100 бод төхөөрөх хүчин чадалтай, 1000 тн багтаамжтай зоорь бүхий мах бэлтгэх, боловсруулах үйлдвэрийг тус тус ашиглалтад оруулсан байна.</p>
	<p>Мөн Өвөрхангай аймгийн Арвайхээрт хоногт 150 бод, 1000 бог төхөөрөх хүчин чадалтай үйлдвэрийг улсын төсвийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсан.</p>



<p>3.2.5. Малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур, өлөн гэдэс, эвэр, туурай, яс, хялгас зэрэг)-ийг худалдан авах, түүнд чанарын анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх;</p>	<p>Үндэсний үйлдвэрүүд 89.3 тн сарлагийн хөөвөр, 236 тн тэмээний ноос, 1,410 тн хонины ноос, 138.5 тн ноолуур хоршоодоос авах захиалга өгөв. Сарлагийн хөөврийн эрэлт 2017 онд өмнөх онтой харьцуулахад 13 хувиар өссөн бол тэмээний ноосны эрэлт 11 хувиар буурсан үзүүлэлттэй байв.</p>
<p>3.2.6. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт, түүнийг хэрэглэх заавар, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;</p>	<p>Малын гаралтай түүхий эдийн чанарыг хамгаалах, стандартын дагуу бэлтгэх талаар аргачлал, заавар боловсруулж, түүхий эдийн үнийг тогтворжуулахын тулд чанар хамгаалалтыг хийлгэх, түүхий эд бэлтгэлийн стандартыг мөрдүүлэхээр 2017 онд Архангай, Ховд, Завхан, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад малчид, түүхий эд бэлтгэгчид, МЭҮГ-ын мэргэжилтнүүд 126 хүнийг хамруулж, түүхий эд бэлтгэлийн стандарт, арьс ширний урамшууллын талаар сургалтыг зохион байгуулсан.</p>
<p>-</p>	<p>Говь-Алтай аймагт 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 90.0 сая төгрөгөөр 112 газарт хайгуул хийж, 86 устай цэг тогтоосон, Сүхбаатар аймагт 100 сая төгрөгийн хөрөнгөөр 80 цэгт хайгуул хийсэн бөгөөд дээрх 2 аймагт нийт 190,0 сая төгрөгөөр 192 цэгт уст цэгийн хайгуул судалгааны ажил хийсэн байна.</p> <p>2016-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 149, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 427, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 62, малчдын санаачилгаар 673, нийт 1356 инженерийн хийцтэй худгийг шинээр барьж ашиглалтанд оруулснаар 2,0 сая га бэлчээр, 6,7 мянган малчин өрх, 3,7 сая мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлэв.</p> <p>2017 онд Өмнөговь аймагт орон нутгийн хөгжлийн сангийн 365,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 37 худаг / 30 засвар, 7 шинэ/ нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүрийг суурилуулах ажлыг Өмнөговь аймгийн “Ундарга-Өмнөговь”ХХК, “Болор-Ус”ХХК –ууд гүйцэтгэн ашиглалтанд оруулснаар 100 гаруй мянган мал сүрэг усаар хангах боломжийг бүрдүүлэв. Нийт 1393 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, сэргээн засварласан.</p> <p>2016-2017 онд Булган, Архангай, Хөвсгөл, Хэнтий, Говь-Алтай, Дундговь аймгуудад 78 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг орон нутгийн байгаль хамгаалах сан болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, малчдын оролцоотой гүйцэтгэв. 2017 оны Дорнод аймгийн Матад, Халх гол сумдад байгаль хамгаалах сангийн 130 сая төгрөгийн хөрөнгөөр 2 хөв цөөрөм, Дундговь аймгийн Хулд, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумдад нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалсан байна.</p>
<p>-</p>	<p>Улсын төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр шинээр гаргаж байгаа инженерийн хийцтэй худгийн нийт зардлын 5 хувьтай тэнцэх хөрөнгийг ашиглагчдаас нь гаргуулж байна. Ашиглагч малчдын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 2017 онд Улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгийн 5 хувь болох 93.6 сая төгрөгийг оролцооны хөрөнгөнд малчдаас гаргуулах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулав. Тус хөрөнгөөр малчид өөрсдийн хувь нэмрийг оруулснаар худаг эзэмших эрхтэй боллоо.</p>
<p>-</p>	<p>Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоолоор өгсөн үүргийн биелэлт аймгийн аюулгүйн нөөц 88.5 хувь, сумын аюулгүйн нөөц 58.5 хувийн биелүүлсэн бөгөөд аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэхэд зориулж төсвийн тодотголоор 4.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тусган, нөхөн бүрдүүлэлтийг дотоодоос худалдан авах чиглэл өгсний дагуу 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар бүх аймгууд нөөцөө бүрэн бүрдүүлсэн.</p> <p>Малчдын өвс, тэжээлийг нэмэгдүүлэх, үнэ хямд тэжээл хүргэх зорилгоор төсвийн тодотголд 40.0 тэрбум төгрөг тусган аймгуудад борлуулалт хийх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж хүүгүй санхүүгийн эх үүсвэрийг олгох зээлийн гэрээнүүд хийгдсэн.</p>
<p>3.2.10. "Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;</p>	<p>Малчдын орон сууц үйлдвэрлэл төсөл хэрэгжүүлэхээр төслийн баримт бичгийг боловсруулж байна. БНХАУ-аас хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 5000 малчин өрхийг орон сууцжуулах асуудлыг судалж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</p>
<p>-</p>	<p>Хөдөөгийн малчид багийн төвшинд цаг агаарын мэдээ, бэлчээрийн ургацын мэдээ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг шуурхай, өөрийн хүссэн үедээ хүлээн боломжтой болж байна.</p> <p>Цаашид уг үйлчилгээг хөгжүүлэн малын өвчний гаралт, цасны хэмжээ, бэлчээрийн даац, малын түүхий эдийн зах зээлийн үнэ гэх мэт мэдээллийг хүргэх боломжийг бүрдүүлсэн. Хөдөөгийн малчин өрхүүдийг нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангах бодлогын зорилтын хүрээнд Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр нийт 83,338 хөдөөгийн малчин айл өрхийг нарны цахилгаан эх үүсвэрээр хангав.</p> <p>Малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор гар утасны мессэжний үйлчилгээг үүрэн телефоны компаниудтай хамтран нэвтрүүлж тусгай аппликейшн боловсруулсан хэрэгжүүлж байна. 21 аймгийн 1550 багийн 160.600 малчин өрх цаг уурын мэдээллийг шуурхай хэлбэрээр гар утсаараа хүссэн үедээ авах боломж бүрдэж байна.</p>
<p>-</p>	<p>Хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэмтдийн бүтээл болох Нано технологиор бүтээсэн материалаар хийгдсэн хувцас, бусад хэрэгсэл, гэрийн бүрээс, нэхийгээр хийгдсэн хувцас хэрэгсэл борлуулалт сайтай байна. Хүйтэн цасан болон шороон шуурганаас хамгаалах, галд тэсвэртэй хөнгөн дулаан материалаар хийгдсэн хувцсыг нийлүүлэх</p>



	Шороо, хир тогтодоггүй удаан эдэлгээтэй материал, нэхий дотортой дээл хувцас, мотоциклийн бээлий, өндгөвч, гэрийн бүрээс, майхан зэрэг өргөн хэрэглээний барааг нийлүүлж байна.
3.2.13.Бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болгох, техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулж байх;	Өвс хадлан бэлтгэх зориулалтаар 2017 онд ОХУ-ын Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн 642.0 мянган ам. долларын хөрөнгөөр 85 морины хүчтэй дунд оврын трактор, хадлангийн зориулалттай 40 иж бүрдэл техникийг иргэн аж ахуйн нэгжүүдэд 5.6 хүүтэй 4 жилийн хугацаатай зээлээр олгосон.
	Улсын хэмжээнд хорголжин тэжээл үйлдвэрлэдэг 4 аж ахуйн нэгж бий болсон. Хадлан, тэжээлийн жижиг дунд оврын трактор, хадуур, тармуураар Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 141 ширхэг, Мал хамгаалах сангаас 1 ширхэг, нийт 142 иж бүрэн техникээр хангахаар ажилласан. Хадлан бэлтгэлд зориулж ОХУ-аас техникийн зээлийн хүрээнд хаман боогч 40 ширхэг, бага оврын трактор, хадуур тармуур тус бүр 20 ширхэг орж ирснийг 30 хувийн урьдчилгаа аван 5 жилийн хугацаатай лизингийн хэлбэрээр олгож техникийн дэмжлэг үзүүлэв. Малчдад гар тэжээл бэлтгэх боловсруулах, хадгалах чиглэлээр зөвлөмж гаргаж орон нутагт сургалт зохион байгуулав. Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан "Сав, баглаа, боодол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд тэжээл үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулсан.
	Тэжээлийн үйлдвэрүүдийн байршлыг тогтоож, 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтад өвс, тэжээл худалдаалах байнгын цэгийг байгуулсан. Манай улсын хэмжээнд 166 тэжээлийн үйлдвэр, цех байгаагаас 68 нь байнгын болон түр ажиллагаатай, 49 нь ажилладаггүй байна. Тэжээлийн үйлдвэрүүдийн байршлыг бүсчлэн гаргав. 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтад зориулж 22 аймаг, нийслэлийн бүх сум, дүүрэгт тэжээл худалдаалах цэгийг аж ахуйн нэгжүүдтэй хамтран байгуулав. Өвөлжилт хүндэрсэн үед улсын нөөцийн салбар цэгүүдээс малчдад өвс, тэжээл хүргэхэд зам даваа хаагдсан, тээвэрлэлтийн зардал ихээр гарах, цаг алдах зэрэг бэрхшээл үүсдэг тул Баянхонгор аймгийн Баянцагаан, Нөвөрхангай аймгийн Арвайхээр, Завхан аймгийн Түдэвтэй сумдад улсын нөөцийн түр цэгүүдийг МУЗГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 314 дүгээр тогтоолоор байгуулан өвс тэжээл байршуулах ажлыг ОБЕГ-тай хамтран хэрэгжүүлсэн
	Тэжээлийн үр үржүүлэх 2 аж ахуйн нэгжийг бодлогоор болон зээлээр дэмжиж нийт малын тэжээл тариалалтыг 0,05 хувиар нэмэгдүүлсэн. Манай улсад нутагшсан бургалтай сортын царгасны үр үржүүлэх аж ахуйн нэгжийг бий болгож байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад уурагт таримал тэжээл тариалах ажлыг эхлүүлж Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалах, үр үржүүлэх ажилд дэмжлэг үзүүлж тэжээл үйлдвэрлэлийг 2018 онд 1200 тн ногоон тэжээлээр нэмэгдүүлсэн ба царгасны үр үржүүлэх 720 га талбай, хөх тарианы үр үржүүлэх 200 га талбайг нэмэгдүүлж малын тэжээл тариалалтыг 0,03 хувиар өсгөсөн байна. Сайн чанарын тэжээлийн үр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх төслөөр тэжээлийн арвай, хошуу буудай, хөх тариа, царгасны үр үржүүлж нийт 192.2 тн-ыг бэлтгэж нийлүүлэх боломж бүрдсэн байна. “Атаршиж орхигдсон газрыг нөхөн сэргээж, таримал хадлан болгон ашиглах” сэдэвт инновацийн төслийг хэрэгжүүлж нийт 368 га талбайд нэг наст арвай, овъёос, хөх тариа, вандуй, олон наст царгасны нийт 73.6 тн үр цацаж тариалж тэжээлийн олон найрлагат эрдэс тэжээлийн бэлдэц нийт 7500 ширхэг буюу 37.5 тонныг үйлдвэрлэж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлсэн.
3.2.18.Мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;	2017 онд МЭҮ-ийн үйлчилгээнд шаардагдах багаж хэрэгслийн 1 иж бүрдлийг улсын төсвийн 500.0 сая төгрөгөөр худалдан авсан.
	2017 онд: Малын үзлэг, ангилалтын ажлыг орон нутгаас ирүүлсэн саналыг үндэслэн тухайн бүс нутагт үндсэн сайжруулагчаар ашиглах бүрэн боломжтой, цаашид үүлдэр, омгоор баталгаажуулан ашиглахаар судалгаа шинжилгээ хийгдэж байгаа малыг үржүүлж буй 13 аймгийн 45 сумын 286.1 мянган малын анги чанарыг тогтоов. Ангилалтанд хамрагдсан нийт малын 80.1 хувийг бог, 19.9 хувийг бод мал эзэлж байв. Үзлэг ангилалтын дүнгээр нийт малын 19.3 хувь буюу 55.1 мянга нь цөм, 52.2 хувь буюу 149.3 мянга нь үржлийн, 28.5 хувь болох 81.5 мянган мал хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн байна. Үзлэг ангилалтанд хамрагдсан хээлтүүлэгчийн 41.0 хувь /7403 /, хээлтэгчийн 17.8 хувь /47700/ нь цөм сүргийн шаардлага хангасан.

	<p>2016 онд: Малын үржлийн ажил үйлчилгээ явуулж байгаа хувийн хэвшлийн хуулийн этгээдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх төслийн сонгон шалгаруулалтанд 16 аймгийн 27 сумын 30 аж ахуй нэгж шалгарч ХХАА-н сайдын 2016 оны А-93 дугаар тушаалын дагуу 386.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдсан.</p> <p>2017 онд : Орон нутагт мал үржүүлэг, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, 2021 он хүртэлх хугацаанд нэгжид төвлөрүүлэх хээлтүүлэгчийн тооцоо, судалгаа, нэгжүүдийг зээлийн дэмжлэгт хамруулах боломж зэргийг нарийвчлан гаргаж УИХ-ын БОХХААБХороо, холбогдох газарт танилцуулав. Санхүүжилтээс шалтгаалан хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг олгогдоогүй болно.</p> <p>2018 онд: “Малын генетик нөөцийн тухай хууль” батлагдсантай холбогдуулан гарсан хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, шилжилтийн үеийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу 350.0 сая төгрөгийн санхүүжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-179 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтад тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.</p> <p>2017 онд: Малын үржил селекцийн ажлын ололтыг хянан магадлах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг суманд үржүүлж буй сүү-ноосны чиглэлийн “Ламын гэгээний улаан” тэмээ, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн “Эрчим хар” ямаа, Цагаан-Уул суманд үржүүлж буй мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Цагаан-Уул” хонь, Ховд аймгийн Дарви суманд үржүүлж буй мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Сутай” хонины судалгаа, шинжилгээний ажлын дүнг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулав. Үүний үр дүнд 2 омгийн мал үүлдэр болон дэвшиж, 1 үүлдэр, 1 үржлийн хэсэг шинээр бий болж Монгол улсад үржүүлж буй бие дааж баталгаажсан үүлдэр, омгийн мал 47 болов.</p>
	<p>“Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуульд хэрэгжилтийн явцад 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2 удаа шинэчлэн найруулсан.</p> <p>Тус хуулийн хэрэгжилтийн явцад гарч байсан хийдэл, зөрчлийг арилгах, оролцогч байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоох, хуулийн хамрах хүрээг тэлэх практик шаардлагыг харгалзан тус хуулиар зохицуулж байсан харилцааг салгаж, бие даасан хуулиар зохицуулахаар Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг тус тус батлуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар “Малын генетик нөөцийн тухай” хууль батлагдсан.</p> <p>“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль хэрэгжсэнээр мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тандалт, судалгаанд тулгуурлан хэрэгжүүлдэг болох нөхцөл бүрдсэн.</p>
<p>3.2.21.Мал, амьтны шүлхий, мялзан өвчнөөс тайван орны жагсаалтад орж, тодорхой бүс нутгийг малын гоц халдварт болон нэн аюултай зооноз өвчнөөс эрүүлжүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний нэрийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд өрсөлдөх бодлогыг алхам алхмаар хэрэгжүүлэх.</p>	<p>Урьдчилсан гүйцэтгэлээр хонины цэцэг өвчинтэй тэмцэх хүрээнд 2016 оны 12 дугаар сараас 2017 оны 12 дугаар сарын 15-ныг хүртэл давхардсан тоогоор нийт 15 аймгийн 361 суманд 82,731 малчин өрхийн 14,625,467.0 толгой хонь, 8,801,482.0 толгой хурга, нийт 23,303,644.0 толгой хонь тарьж, үйлчилгээний хөлсөнд 3,495,546,600.0 төгрөг зарцуулсан байна.</p>
<p>3.3.2.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид сайн дураараа нэгдэн "Мал зүйч үржүүлэгчдийн холбоо", "Монголын сүүний нэгдсэн холбоо", Монголын эрчимжсэн фермүүдийн нэгдсэн холбоо", Шувуу үржүүлэгчдийн холбоо, Гахайн холбоо, Зөгий нийгэмлэг зэрэг ТББ-уудыг үүсгэн байгуулан өөрсдийн эрх ашгийг хамгаалан ажиллаж байна. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч малчид өөрсдийн сайн дурын үндсэн дээр малчдын хоршоо, бүлэг, нөхөрлөл, гадаад, дотоодоос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн эрх ашгаа хамгаалж байна. 2017 оны байдлаар 228.9 мянган малтай өрхийн 80 хувь нь дээрх зохион байгуулалтанд хамрагдсан байна.</p>
	<p>Швейцарийн Холбооны Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа “Ногоон алт-малын эрүүл мэнд” төсөл нь 2017-2020 онд Бэлчээрийн зохистой ашиглалт, борлуулалтын ашигтай тогтолцоо, эрхзүй, бодлогын таатай орчны нөлөөгөөр малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 21 аймгийн 186 сумын 1362 БАХ-ийн 60 000 гаруй малчин өрхөд хэрэгжүүлж байна.</p> <p>“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд малчдын бүлэг хоршоог бэхжүүлэх ажлууд хийгдсэн.</p> <p>Бэлчээр сайжруулах чиглэлээр тайлант хугацаанд буюу 2017 онд Бэлчээр ашиглалтын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нэг алхам болох “Аймаг дундын отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал”-ыг боловсруулах ажлыг санхүүжүүлсэн байна. Мөн Архангай аймгийн Батцэнгэл сумын бэлчээрийн мониторингийн судалгаа, сургалт хийх, АДОБАЗ, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ-тай хамтран Бэлчээрийн менежментийн сургалтыг АДОБАЗ-ны орон нутгийн ажилтнуудад зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.</p> <p>Төслийн хүрээнд сонгогдсон 15 суманд байгуулахаар төлөвлөсөн 120 малчны бүлэг 100 хувь байгуулагдаж тэдгээрт хамрагдаж буй 2771 орчим малчин өрхийн 10543 ам бүл төслийн үр шимийг хүртэх боломжтой болсон байна. Энэ нь төсөлд хамрагдсан сумдын нийт малчин өрхийн 35 хувь болж байгаа юм</p>



<p>3.3.4. Малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаарх мэдээллийн цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах;</p>	<p>Түүхий эдийн үнийн урамшуулалтай холбоотой мэдээллийн сан бий болж, малчид, мал бүхий этгээдүүдэд лавлагаа, мэдээлэл өгөхөөс гадна дээд шатны төрийн байгууллагыг мэдээллээр хангаж байна. Мөн ХХААХҮЯ-ны дэргэд малчин лавлах 109 дугаарыг ажиллуулж алдсан, олдсон мал болон цаг агаар, гэнтийн аюулт үзэгдэл бусад шаардлагатай мэдээллүүдийг малчдад үнэгүй хүргэж байна. Энэ лавлахтай холбогдоход ямар нэгэн үнэ төлбөргүй.</p>
<p>-</p>	<p>БНСУ-ын Олон улсын эрүүл мэндийн сан, ДЭМБ-ын санхүүжилтээр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь” төслийг хэрэгжүүлэв. Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Увс, Дархан-уул аймгийн нийт 10 суманд амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд сумын эрүүл мэндийн төвд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх зорилгоор нийт 246 сая төгрөгийн мобайл тоног төхөөрөмж, оношлуураар ханган нийт 540,000 иргэнийг явуулын эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрууллаа. Мөн төслийн хүрээнд сумын эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн мэргэжилтэнг туршлага солилцох уулзалт сургалтанд бүрэн хамруулав.</p>
<p>-</p>	<p>“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлуулав. Төслийг 5 аймагт хэрэгжүүлэх жил бүр отроор яваа малчид болон жирэмсэн эмэгтэйчүүд, 5 хүртлэх насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган тэдэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх талаарх арга хэмжээ төлөвлөж хэвшүүлэхээр ажиллаж байна.</p> <p>“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрт Монгол Улсын хүн амын дунд хепатитийн вирус халдварын тархалтыг хязгаарлан, хепатитийн С вирус халдварын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоохоор төлөвлөсөн.</p>
<p>-</p>	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр жилд 2 удаа тогтмол зохион байгуулдаг бөгөөд 2017 онд давхардсан тоогоор 275 сумын 323804 иргэнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн явуулын үзлэгийг зохион байгуулж, 14291 өвчлөлийг илрүүлж, хяналтанд авсан байна.</p> <p>Сүрьеэгийн өвчлөл өндөртэй Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорноговь, Завхан зэрэг 5 аймагт сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах, илэрсэн тохиолдлыг эмчилгээнд хамруулахаар төлөвлөсөн бөгөөд ДЭМБ-аас 26.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн нэмэлтээр 6 аймаг (Дорнод, Хэнтий, Орхон, Төв, Хөвсгөл, Сүхбаатар), 3 дүүрэг (Хан-Уул, Баянгол, Сүхбаатар)-т идэвхтэй илрүүлгийн үзлэгийг эрсдэлт бүлгийн хүн амд “Эрүүл мэндийг дэмжих сан”-ийн хөрөнгөөр хийжээр төлөвлөн зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Хөвсгөл аймгийн 3 сум (Ренчинлхүмбэ, Цагааннуур, Улаан-Уул), Сэлэнгэ аймгийн 4 сум (Мандал, Цагааннуур, Ерөө, Алтанбулаг), Баянхонгор, Төв зэрэг 4 аймгийн 3,448 хүнийг сүрьеэгийн илрүүлгийн үзлэгт хамруулжээ.</p>
<p>-</p>	<p>Сум, сум дундын эмч нарт “Гепатитын вирусийн эсрэг эмчилгээ хийх, оношлох, хянах, эмчилгээний чанарыг сайжруулах сургалт”-д 15 аймгийн нийт 60 эмчийг хамруулав.</p> <p>“Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд 10 аймгийн 65 эмч, эмнэлгийн мэргэжилтний сургав.</p>
<p>-</p>	<p>Эхийн эндэгдлийг бууруулах талаар 21 аймаг, ЭХЭМҮТ, нийслэлийн амаржих газруудтай “Эх барихын тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал” шуурхай цахим хурлыг 21 хоног тутам зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн эхийн эндэгдэл өндөртэй Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор аймгуудын эмч нарыг ЭХЭМҮТ-тэй хамтран эмч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж 3 эмч ЭХЭМҮТ-д ажилласан нь мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын байранд суралцах боломжийг бүрдүүлэв. - 2017 онд зүрх судасны өвчнөөр нийт 8178, хоол боловсруулах эрхтний өвчнөөр 5578, бөөр шээсний замын эмгэгээр 9606, мэдрэлийн эмгэгээр 3616, осол гэмтлээр нийт 2857 малчин хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг авсан байна.</p>
<p>-</p>	<p>“Олон нийтийн сүлжээг ашиглан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зан үйлийг төлөвшүүлэх” ажлын удирдамж ЭМС-аар батлуулан 2017 оны 10 дугаар сараас эхлүүлэн Эрүүл мэндийн яам “Эрүүл мэнд-Эрхэм баян”, нэртэйгээр нээн ажиллуулж байна.</p>
<p>-</p>	<p>Тус сүлжээ маань 15000 дагагчтай болсон бөгөөд тэмдэглэлт өдрүүдийн болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол байршуулан, иргэдээс ирсэн санал, хүсэлт, асуултад /7 хоногт дунджаар 5-10 хүн/ тухай бүр чиглэл өгч ажиллаж байна. Хүн амд уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах мэдлэг, арга барил эзэмшүүлэх зорилгоор Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-алтай аймгуудад “Уламжлалт анагаах ухааны өвчнөөс сэргийлэх ёс” сэдвээр эмч эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд чиглэсэн бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан.</p>
<p>-</p>	<p>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх цэгэн иллэг хийх аргачлалыг боловсруулж, ЭМЯ-ны цахим хуудсанд байршуулсан. Зуд, шувууны томуугийн Н7N9 вирус халдвар, хачгаар дамжих халдварт өвчин зэрэг НЭМ-ийн онцгой байдлын үед 8 удаа эрсдэлийн үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулан ажиллалаа. Эрсдэлийн үеийн харилцаа, холбооны арга хэмжээг зохион байгуулж, 10 гаруй видео сэрэмжлүүлэг, 30 гаруй инфографик, зөвлөмж боловсруулан, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа.</p>



	<p>Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг Дорноговь аймаг (79.2 хувь), хамгийн бага үнэлгээг Төв аймаг (4.2хувь) авсан байна. Дорноговь аймаг (79.2хувь), хамгийн бага үнэлгээг Төв аймаг (4.2хувь) авсан байна. тогтмол хийлгэх, эрсдэлийн үнэлгээ хийх заавар боловсруулах ажлын хүрээнд ЭМ, БХБ-ын сайдын 2017.04.17-ны өдрийн А/149-78 дугаар хамтарсан тушаалаар “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг батлуулсан. ЭМС-ын 2017 оны 4-р сарын 17-ны өдрийн А/150 дугаар тушаалаар Жижиг суурин газрын ус хангамжид нэвтрүүлэх “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан заавар”-ыг батлуулан үнэлгээг нийт 21 аймагт хийж гүйцэтгэсэн. Аймгуудын УАБТ-ний хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээний дүнгээс харахад хэрэгжилтийн явц аймгийн түвшинд дунджаар 44.2 хувьтай байна. Үнэлгээг нийт 24 үзүүлэлтийн авбал зохих нийт 96 онооноос авсан оноог хувиар илэрхийлж харуулсан. Хамгийн өндөр үнэлгээг Дорноговь аймаг (79.2%), хамгийн бага үнэлгээг Төв аймаг (4.2%) авсан байна. Усын аюулгүй байдлын төлөвлөгөө (УАБТ) боловсруулах ажил 2012 оноос эхлэн Монгол улсад ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжиж эхэлсэн бөгөөд ЭМЯ санаачлан хэрэгжүүлж байна.</p> <p>“Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан заавар”-ыг батлуулан үнэлгээг нийт 21 аймагт хийж гүйцэтгэсэн. Аймгуудын УАБТ-ний хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээний дүнгээс харахад хэрэгжилтийн явц аймгийн түвшинд дунджаар 44.2 хувьтай байна. Үнэлгээг нийт 24 үзүүлэлтийн авбал зохих нийт 96 онооноос авсан оноог хувиар илэрхийлж харуулсан. Хамгийн өндөр үнэлгээг Дорноговь аймаг (79.2 хувь), хамгийн бага үнэлгээг Төв аймаг (4.2хувь) авсан байна.</p> <p>“Олон нийтийн сүлжээг ашиглан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зан үйлийг төлөвшүүлэх” ажлын удирдамж ЭМС-аар батлуулан 2017 оны 10 дугаар сараас эхлүүлэн Эрүүл мэндийн яам “Эрүүл мэнд-Эрхэм баян”, нэртэйгээр нээн ажиллуулж байна.</p>
<p>3.3.8.Малчин өрхийн эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх, сургагч багш нарыг сум бүрт бэлтгэж мэргэшүүлэх;</p>	<p>Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр-ийн Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагааны сургалт явуулах, туршлага солилцох уулзалт зохион байгуулж ажиллаж байна. Уг арга хэмжээнд 2017 оны 12 сарын байдлаар 2167 өрхийн 2875 малчин иргэн хамрагдаж 194,364.52 мянган төгрөгийг зарцуулсан байна.</p>
	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар 2016 онд Монгол малчин агентлаг Дорноговь, Говьсүмбэр, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймагт, НҮБ-ын санхүүжилтээр Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн залуу малчдад мал бүхий иргэдийг чадавжуулах зорилгоор малын чанар сайжруулах, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, бэлчээрийн менежмент өвс, тэжээл бэлтгэл, мах, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, махны үхрийн аж ахуйг эрхлэх, өсвөр үхрийг өсгөн бойжуулах чиглэлээр 25 удаагийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж 1200 орчим иргэн хамрагдсан байна.</p> <p>2017 онд Завхан, Төв, Дархан-Уул, Говь-Алтай, Сэлэнгэ, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Архангай, аймгийн малчид, мал бүхий иргэдэд бэлчээрийн даац, тэжээллэг чанар, сүргийн бүтэц, Сүргийн эргэлтийг экологийн чадавхад тохируулах, малчдын цахим бүртгэл, хээлтүүлэгчийн ялган төвлөрүүлэх, орон нутгийн түүхий эдээр дарш, гар тэжээл бэлтгэх чиглэлээр 36 удаагийн сургалт зөвлөгөөн зохион байгуулж, 2500 орчим иргэдийг хамруулсан.</p>
<p>3.3.10.залуу болон ирээдүйн малчдыг мэргэжлийн, түр болон албан бус сургалтаар хэтийн төлөвлөгөөтэй бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;</p>	<p>Албан боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй малчин залуучуудад боловсрол нөхөн олгох, бичиг үсэг тайлах, амьдрах ухааны чадвар суулгах, боловсролоор нь дамжуулан амьдралын чанараа дээшлүүлэхэд чиглэсэн бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг аймаг, нийслэл, сум дүүргийн Насан туршийн боловсролын төв нэгж жил бүр зохион байгуулж байна. Тухайлбал, өрхийн төсвийг зохистой зарцуулах, малын ашиг шимийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг өдөр тутмын амьдралд хэвшүүлэх, хэрэглэх чадварт сургах зэрэг тэдний хэрэгцээ амьдралын хэвшилд нийцсэн агуулгаар баяжуулан зайны, явуулын, бие даан суралцахад зориулсан сургалтын модулийг цахим хичээлийн хамт бэлтгэн ашиглаж байна. Иргэд, малчдад зориулсан дээр дурдсан цахим хичээлийг аймаг, нийслэлд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа Насан туршийн боловсролын төв, нэгжүүд орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ТВ, радиогоор зааж байна.</p>
<p>3.3.11.Малчдад зориулсан сонин, сэтгүүл тогтмол гаргахыг дэмжих, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, тусгай хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;</p>	<p>Малчдад зориулсан монгол малчин сэтгүүлийг сард 1 удаа гаргаж байна. Энэ сэтгүүлд Төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, яамнаас хэрэгжүүлж байгаа ажил, тэргүүний малчдын арга, туршлага, малчдад өгөх зөвлөгөө зэргийг нийтэлдэг. Жил бүр улсын тэргүүний малчдын зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөнд төлөөлөгчөөр ирсэн малчдын ажлын туршлагыг эмхтгэн "Малчин түмний алдар" нэртэй номыг Соёмбо принтинг хэвлэлийн газартай хамтран хэвлэж сум орон нутагт хүргүүлдэг. 2016 онд Хүнс, хөдөө аж ахуйн салбарт сүүлийн жилүүдэд бий болсон 510 бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан "ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭМХЭТГЭЛ" номыг, 2017 онд "ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭМХЭТГЭЛ" номыг хэвлэн нийтлүүлж олны хүртээл болгосон байна.</p>



-	Холбогдох мэргэжлийн байгууллага, гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд малчдад мал маллагааны арга туршлага эзэмшүүлэх, аж ахуй эрхлэх арга ажиллагаанд сургах, бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулах, ургамал хамгаалах, тэжээл бэлтгэх, эрчимжсэн аж ахуй болон жижиг, өрхийн үйлдвэрлэл эрхлэх, мал үржүүлэх, мал эмчлэн сэргийлэх чиглэлээр 2017 оны байдлаар 329 сум, дүүргэт давхардсан тоогоор 2820 гаруй сургалт зохион байгуулж 70.5 мянган малчныг хамруулав.
-	“Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд нийт 329 суманд “Малчин сургагч багш” бэлтгэх сургалтыг холбогдох сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, Төрийн бус байгууллагуудаар гэрээ хийж гүйцэтгүүлэн бүх суманд Зөвлөх малчныг бэлтгэв.
-	“Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулан БСШУ-ны сайдаар батлуулан мөрдөж эхлэв. Малчдын хүүхдийн сурч, хүмүүжих, сургалтын орчинг сайжруулах зорилгоор “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын төсөл” хэрэгжүүлж 459.1 мянган ам.долларын хөрөнгөөр 100 гэр, ширээ сандал, тоглоом, заах аргын материалын хамт төвөөс алслагдсан сумдад олгосноор улсын хэмжээнд 539 гэр цэцэрлэгийг бий болгон ажиллуулав. Ерөнхий боловсролын сургуульд сурч буй малчдын хүүхдийг 100 хувь дотуур байраар хангаад байгаа төдийгүй Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 56 дотуур байранд 3000 гаруй малчны хүүхдийг хамруулж байна.
-	Малчин өрхийн бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох талаар: Малчин өрхийн бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг хувилбарт сургалтын ээлжийн болон нүүдлийн бүлэг, явуулын багшийн сургалтаар олгож байгаа бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллээр малчин өрхийн 29.4 мянган хүүхэд сургуулийн өмнөх боловсролд үнэ төлбөргүй хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн 23.7 мянга нь хувилбарт сургалтад 5.7 мянга нь үндсэн сургалтад тус тус хамрагдаж байна. Ерөнхий боловсрол эзэмшиж буй малчин өрхийн хүүхдийг суралцах хугацаанд нь дотуур байраар хангах талаар: 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 517 дотуур байранд 35.1 мянган хүүхэд амьдарч байх бөгөөд тэдгээрийн 73.0 хувь (25.7 мянга) нь малчин өрхийн хүүхэд байна. Дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцлийг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 620 ор бүхий 6, 2017 онд 500 ор бүхий 4 дотуур байрны барилга тус тус ашиглалтад орсон. Энэхүү арга хэмжээний үр дүнд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан нийт хүүхдийн 91.6 хувь дотуур байраар үйлчлүүлж байна.
-	Хөдөө аж ахуйн маркетинг төслийн багтай хамтран байгаль цаг уурын нөхцөл ойролцоо ӨМӨЗО-ны Мал аж ахуйн салбарын байдалтай танилцаж туршлага судлах, цаашид бололцоотой арга, туршлагыг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор төслийн оролцогч сумдаас 21 малчин оролцуулсан аяллыг зохион байгууллаа. Аяллын үр дүнд малын сайн чанарын тэжээл тариалах, малчдын бүлэг хоршоодын түвшинд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, хонь, ямааны цөм сүрэг бий болгох, шилмэл хуц, ухна тусгайлан бойжуулж, бусад малчдад түрээсээр ашиглуулах, малчдын хоршоо байгуулах арга, туршлагатай танилцаж суралцлаа. Мөн НҮБ-ын ХХААБ-ын Техник тусалцааны баг, “Хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи нэвтрүүлэх институт” ТББ-ын мэргэжилтнүүдтэй хамтран “Бог малын тарга хүч тодорхойлох хялбаршуулсан арга”-ыг боловсруулж, нугалбар гарын авлага хэлбэрээр хэвлүүлэн, төслийн оролцогч аймаг, сумын малчдад мэдээлэл түгээх чиглэлээр ажиллав.
-	Малчдын өвөлжилт, хаваржилтад шаардагдах тэжээлийг бэлтгэхэд өөрсдийнх нь оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гар тэжээл бэлтгэх, хашаа хороогоо дулаалах, хужир, шүү бэлтгэх чиглэлээр зөвлөмж гаргаж орон нутагт сургалт зохион байгуулав.
-	2017-2018 оны өвөл, хавар шаардагдах өвс, тэжээлийн дутагдлыг нөхөх зорилгоор өвс, тэжээлийг импортлох дотоодын хэрэгцээг хангах ажлын хүрээнд 22 аймаг, нийслэлд хивэг, хорголжин, багсармал, овъёос, хүчит тэжээл зэрэг тэжээлийг ХХААХҮЯ, аж ахуйн нэгжүүдтэй бодлогын гэрээ байгуулан гэрээнд тусгасан үнийн дагуу борлуулах ажлыг зохион байгуулав. Дээрх аж ахуйн нэгжүүд борлуулах аймгаас хамааран тухайн аймгийн бүх суманд дунджаар нэг тонн хивгийг 334,000-480,000, хорголжин тэжээлийг 344,000-517,700, овъёосыг 400000-537700, арвайг 410,000-440,000 төгрөгөөр тус тус худалдаалж байна. Мөн дээрх ажлын хүрээнд импортлоор авах малын тэжээлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд ингэснээр малчдад худалдах үнийг тэжээлийн нэр төрлөөс хамааруулан дунджаар 12-16 хувиар бууруулж харьцангуй хямд үнээр борлуулах боломжийг бүрдүүлж ажиллаа.
-	“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулснаас гадна үндэсний үйлдвэрт тушаасан ноосонд урамшуулал үзүүлэх тухай УИХ-ын 30 дугаар тогтоол, Засгийн газрын 211 дүгээр тогтоолоор “Ноосонд урамшуулал олгох журам”, малчдын үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлэх тухай Засгийн газрын 2011 оны 100 дугаар тогтоол, “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол, “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам” боловсруулан Засгийн газрын 114 дүгээр тогтоол, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” батлах тухай Засгийн газрын 134 дүгээр тогтоол зэргийг батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авав.



-	Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулах зорилт тусгагдсан. Энэ хүрээнд УИХ-аас 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол, нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол” тус тус өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байх зохицуулалтыг хуульчлан баталж 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж байна.
-	Мөн дээрх хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ыг боловсруулан 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Малчинд тэтгэвэр тогтоохтой холбоотой асуудлаар энэ оны эхний 2 сард нийт 9084 малчин зөвлөгөө, мэдээлэл авснаас 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 857 малчин хуульд заасан болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр тогтоолгожээ.
-	Түүнчлэн УИХ-аас 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд “малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил зургаан сараар шимтгэл төлж ажилласан хугацаанд тооцно” гэсэн зохицуулалт, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль тус тус 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлт нь 1995-2016 онд тасарсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 хувиар тооцуулж нэг удаа нөхөн төлөх боломжтой болж нийгмийн баталгаа нь хангагдах нөхцөл бүрдэх юм.
-	Хөдөө аж ахуйн маркетинг төслийн хүрээнд уг төсөл хэрэгжсэн Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн 15 сумын малчдад 15 үүлдэр, омгийн тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бүхий 4,714 толгой мал, нийт 32 дэд төслийн ашиг хүртэгчдэд хүлээлгэн өгсөн.
-	Хөдөө аж ахуйн маркетинг төслийн хүрээнд уг төсөл хэрэгжсэн Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн 15 сумын малчдад 378 тонн өвс, 31.6 тонн хүчит тэжээл, 8.9 тонн хужир давс нийлүүлж, хүлээлгэн өгсөн.
6.1.2.Малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно;	Хоршооны бүтэц, бизнесийн менежмент, Мах сүүний анхдугаар аяны хүрээнд түүхий эд бэлтгэлийг хоршоодоор дамжуулж хэрхэн бэлтгэх, сүү цагаан идээ боловсруулах талаар туршлага судлах аялал, үзүүлэх сургалтыг зохион байгуулав. 21 аймаг тус бүрээс 3, нийслэлийн 5 хоршооны төлөөлөл, 21 аймгийн ХХААГ-ын ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулав.
6.1.3.Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ;	2017 онд 888.0 мянган толгой мал хорогдсон нь 1.4 хувийг эзэлж байна.
6.1.4.мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна;	2017 онд Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц 57.0 хувьтай байсантай холбогдуулан Төсвийн тодотгол 4.5 тэрбум төгрөгийг батлуулан олгосноор 100 хувь болсон.
6.1.6.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ;	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын хэмжээнд нийт 84 тэрбум төгрөгийг орон нутгийн хоршоо, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, орлого ашгийг нэмэгдүүлэх хүрээнд олгож байна. Үүнээс 16 хувь буюу 13.4 тэрбум төгрөгийг нь малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон байна.
-	2017 оны дүнгээр нийт малчдын 23.9 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Нийгмийн даатгалд хамрагдсан малчдын 30 хувь нь 35-44 насны, 27 хувь нь 45-54 насныхан байна.
-	2017 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалд 110.0 мянган малчин, нийгмийн даатгалд 37.6 мянган малчин сайн дураар даатгуулсан нь 2016 онтой харьцуулахад 14 пунктээр буурсан байна.
-	Малчдын нийгмийн даатгалын хамралт буурахад дараах хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд: - Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай” тогтоолоор баталсан “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг малчдад олгохоор заасан. Уг зээлийг олгохдоо малчдыг эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ерөнхий шаардлагыг тавьсан. Уг арга хэмжээний хүрээнд 2016 онд нийгмийн даатгалд даатгуулсан малчны хамралт нэмэгдсэн боловч 2017 онд “Сайн малчин” хөтөлбөр зогссон;



	- Монгол Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хууль батлагдсантай холбогдуулан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2018 оны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан хүлээлт үүссэн зэрэг болно
6.2.2. Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;	15-24 насны малчдын 11 хувь нь, 25-34 насны малчдын 16 хувь нь, 35-44 насны малчдын 25 хувь нь, 45-54 насны малчдын 32 хувь нь, 55-64 насны малчдын 33 хувь нь нийгмийн даатгалд хамрагддаг байна.

Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)

Орон нутгийн хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

1. Малын эрүүл мэндийн үйлчилгээ

Нийслэл, орон нутгийн хувьд малын эрүүл мэндийн үйлчилгээний талаар нийслэлээс болон 2 аймгаас ирсэн мэдээллээс үзэхэд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, лабораторийн оношлогооны чадавхыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулж, малчдад гарын авлага, тараах материал тараан хамтран ажиллаж, ЭМГ-тай хамтран эрсдэлт бүлгийн (малчид, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид) иргэдийг бруцеллёзын шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн даатгалд хамруулж хэвшүүлснээр малын халдварт өвчний гаралтыг тус 3 бүсэд 20-100 хувь бууруулсан байна. Давхардсан тоогоор 2018 онд 4 сая орчим малыг үзлэгт хамруулсан байна.

2. Малын генетик нөөц, үржил селекц

Арга хэмжээ:

Дархан-Уул аймгийн хувьд Хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан шинээр “Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/68 дугаар тушаалаар баталсан “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд баримтлах жишиг үнийн үзүүлэлт”-үүд батлагдаж мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Хүн амын хүнсний хангамжид онцгой ач холбогдол бүхий гахай, шувуу, зөгийн аж ахуйн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлийг баримтлан “Туслах аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг аж ахуй эрхлэгчдийн санал хүсэлтийг тусган боловсруулж аймгийн ИТХТ-ийн 2017 оны 52 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017-2020 он хүртэл боловсруулан ажиллаж байна.

Дундговь аймгийн хувьд орон нутгийн онцлогт тохирсон баталгаажсан бренд малтай болох боломж бүрдээд ажиллаж байна. Өндөршил сумын Өндөршил адуу, Сайнцагаан сумын Сайнцагаан хонь, Хулд сумын Олдохын хүрэн тэмээ омог болгох судалгааны ажлуудыг үр дүнтэй зохион байгуулаад ХХААХҮЯамны сайдын хянан магадалгааны ажлын хэсгийг томилуулаад ажиллаж байна.

Гарсан үр дүн:

Дархан-Уул аймагт Хөдөө аж ахуйн сургалт мэдээллийн “Хөгжлийн оньсон түлхүүр” төвөөс зохион байгуулсан “Байгаль, цаг уурын эрсдэл даах чадавхтай мал аж ахуй эрхлэх нь” сургалт, Төвийн бүсийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдэд зориулсан үзүүлэх сургалт, спортын арга хэмжээнд 4 сумын МЭҮТ-ийг оролцуулан 4 ширхэг “Yamaha” мотоцикл олгосон нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажлууд болсон байна.

Улсын хэмжээнд үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журмыг Засгийн газраар батлуулахаар ажиллаж байгаа тул тус аймгийн 4 суманд одоогийн байдлаар 0.04 мянган толгой тэмээ, 4.3 мянган толгой адуу, 14.5 мянган толгой үхэр, 130.7 мянган толгой хонь, 46.4 мянган толгой ямааг баталгаажсан үүлдэр омгийн малд бүртгүүлэхээр судалгааг гаргаж ХХААХҮЯ-ны МҮББХЗГазарт хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн нутгийн шилмэл үүлдэр омгийн хээлтэгч хээлтүүлэгч худалдан авалт нэмэгдэж мал сүргийн үүлдэрлэг байдал нэмэгдсэн.

Дорнод аймгийн хувьд үүлдэр, омгийн мал бий болж малын чанар сайжирч, ашиг шимийн түвшин дээшилсэн.

Хэнтий аймгийн хувьд 2017 онд малын ашиг шим, үр төлийн чанарыг сайжруулах зорилгоор ОНТХөрөнгө оруулалт 5 сая төгрөгөөр үржлийн мал худалдан авсан. Үүнд: Орхон үүлдрийн 10 эм хонь, 5 хуц аваад байна. 2019 онд 1.7 сая төгрөгийн ОНТХөрөнгө оруулалтаар 1.7 мянган толгой малд үзлэг ангилалтыг хийсэн (Цөм сүргийн үржлийн төв).

3. Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт

Дархан-Уул аймгийн хувьд ХХААХҮЯ, Ногоон алт-Эрүүл мэнд төсөл, Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо хамтран зохион байгуулсан Монгол оны бэлчээрийн II форум “Бэлчээрийн хариуцлагатай менежмент” мөн Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандартууд сэдэвт сургалт зохион байгуулж малчдыг мэдлэг мэдээллээр хангах ажлын хүрээнд 150 малчинд гарын авлага тараасан байна.

4. Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлах

Мэдээ ирүүлсэн Сэлэнгэ, Дархан-Уул, Увс аймгуудын хувь малчдын өөрсдийн хөрөнгө болон орон нутгийн санхүүжилтээр 6 шинэ худаг гаргаж, 1 хуучин худаг сэргээн засварлаж ашигласнаар бэлчээрийн даац буурах, нөхөн сэлгэж ашиглах боломж нөхцөл бүрдсэн байна.

5. Хадлан бэлтгэл

Дархан-Уул аймгийн хувьд Мал аж ахуйн салбарт өвөлжиж хаваржих малын тоог Аймгийн статистик тоо баримтыг үндэслэн малчдын түвшинд бэлтгэх байгалын хадлан, тэжээлийн тооцоог сум тус бүрээр зааврын дагуу гаргаж хүргүүлэн ажилладаг.

2016 онд тус аймагт нийт нутгаар цасан бүрхүүл тогтож, хөдөө аж ахуйн цаг агаарын байдал сөргөөр нөлөөлж, өвөлжилт хүндрэх төлөвтэй болж байгаатай холбогдуулан



Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Дархан сумын засаг даргаар ахлуулсан 45 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хонгор, Орхон, Шарын гол, Дархан сумдын 146 малчин өрхийн өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, Эрүүл мэндийн газраас 71 ширхэг эмийн багц, Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс малын бэлчээрийн 21 цэгт цасан бүрхүүлийн зузаан, нягтыг хэмжиж, малчдын санал хүсэлтийг сонсож тухайн жил бүр арга хэмжээ авч ажиллаж байдаг болно.

Аймгийн ИТХурлаас 2017 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан “Малчдад туслах аян”-ы хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хандив, тусламжаас 97 малчин өрхөд 9 сая гаруй төгрөг мөн 70 шуудай хивэг, 750 ширхэг элгэвч, нэмнээ, 552 ширхэг бээлий, 38 багц хүнсний бүтээгдэхүүн, 103 багц ахуйн хэрэглээний бараа, 646 толгой лаа, шүдэнз, 66 багц хувцас, 452 багц эмийн бүтээгдэхүүн, болон бусад 90 гаруй нэр төрлийн эд зүйлсийг 4 суманд хуваарилан олголоо.

6. Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл

2018 онд Дархан-Уул аймагт Торгон үр ХХК 532 га-д, Бестөмөрт ХХК 20 га-д, УГТХүрээлэн 2 га-д тэжээлийн ургамал тариалж нийт 554 га тариалалт хийсэн байна.

7. Малчдын эрүүл мэнд

Дархан-Уул аймгийн Хонгор сум, Дархан сумын 63 малчин өрхөөр НДХ, ЦГ-ЫН Малын хулгай гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг, Хонгор сумын МЭҮТ, Хүн эмнэлэг, Дархан сумын МЭҮТ, 3 дугаар багийн Хүн эмнэлэг, Малчин багийн төлөөлөлтэй хамтран ажиллаж малчдын гэр бүлийг эрүүл мэндийн даатгалд 93 иргэн хамруулсан байна. Мөн Шарын гол сумын 114 малчинд “Ачит тун”, “Ид шид” эмийн сангийн явуулын үйлчилгээг үзүүллээ.

Хонгор сумын Зулзага багийн малчдын хөрөнгөөр сумын эрүүл мэндийн төвийн нэг өрөөг 1,300,000 төгрөгийн тохижуулсны үр дүнд 30 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна.

8. Малчдын боловсрол

“Малчинд мэргэжлийн үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох” журмын дагуу Улсын Малчин мэргэжлийн үнэмлэх, энгэрийн тэмдэг сумдын нийт 2699 малчин өрхийн тэргүүн, түүний гэр бүл, 18-аас дээш насны хүүхдэд олгосон.

“Малын генетик нөөцийн тухай хууль”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулиуд шинээр батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сургалт зохион байгуулагдаж мал зүйч, малын эмч, малчдын төлөөлөл 150 хүнийг хамруулсан.

Аймгийн “Малчдын зөвлөгөөн 2018”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Залуу малчдад ур чадвар олгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малжуулах төслийн сонгон шалгаруулалтад хамрагдсан сумдын малчдад сургалт зохион байгуулагдаж нийт 420 гаруй малчин хамрагдлаа.

9. Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ

Дархан-Уул аймгийн малчдаас гарсан хүсэлтийн дагуу “Малчид, үйлдвэрлэгчдээс хэрэглэгчдэд” худалдаа зохион байгуулж Хонгор, Орхон, Дархан сумдын 28 малчин өрх оролцож, 25,6 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Дархан-Уул аймагт Дэлхийн зөн ОУБ-тай хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн төлөөх орон нутаг” төслийн хүрээнд “Гэр бэлэглэе” аяны шалгаруулалтаар Хонгор, Дархан сумдын 2 туслах малчинд гэр олгосон байна.

10. Дэд бүтэц (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)

Баян-Өлгийн аймагт 1 махны үйлдвэр, Дархан-Уул аймагт хоногт 100 бод, 500 бог мал нядлах хүчин чадалтай махны үйлдвэр ашиглалтанд орсон байна.

Архангай аймгийн нийт малчдын 80 гаруй хувь нь үндэсний үйлдвэрт түүхий эдээ нийлүүлж урамшуулалд хамрагдаж байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Нийслэлийн баруун, зүүн хэсэгт мал, мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж байна. МБҮ трейд ХХК хариуцан гүйцэтгэж байгаа.

11. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид

Дархан-Уул аймгийн фермерүүдийг эрчимжсэн аж ахуйн сайн туршлагыг танилцуулах, нэвтрүүлэх чиглэлээр танилцах аяллыг Сэлэнгэ аймгийн Хушаат, Булган аймгийн Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Төв аймгийн Баяндэлгэр сумдад төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан. Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор Хонгор сумын Цайдмын худаг, Зулзагын голын худаг орчимд сүүний 2 хөргөлтийн төвийг байгуулахаар дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Булган аймгийн Хутаг-Өндөр суманд байрлах Hanadu gazog back компанийн бяруу бордох аж ахуй, Төв аймгийн Эрдэнэ сумын “МАШ” эрчимжсэн аж ахуйг түшиглэн малын махан ашиг шимийг нэмэгдүүлэх дэвшилтэт технологийн үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Монгол Улсын Засгийн газар-Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийн дэмжих (SECIM) С2 төсөл Глобал Коммунитс ОУБ, Витафит групптэй хамтран “Та сүүгээ уусан уу?” индэр-уулзалт тус аймагт зохион байгуулагдаж 36 малчин, фермер оролцуулан гарын авлага, мэдээллээр хангасан.

3.2.2 Хүлээгдэж байсан үр дүнд хүрсэн эсэх (Шалгуур үзүүлэлтээр)

ХХААХҮЯ-наас ирүүлсэн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын 2017, 2018 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайланд үндэслэн тус бодлогын хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлов.

Хүснэгт 8. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хүлээгдэж буй үр дүн буюу шалгуур үзүүлэлтийн хангасан талаарх үнэлгээ



№	Шалгуур үзүүлэлт	2017 оны хэрэгжилт ба үнэлгээ		2018 оны хэрэгжилт ба үнэлгээ	
		Хэрэгжилт	Үнэлгээ*	Хэрэгжилт	Үнэлгээ*
1-р үе шат	6.1.1. Малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ;	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг гаргасан. Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиудыг тус тус батлуулан ажиллаж байна.	70	- Сайдын А-132 дугаар тушаалаар “Бэлчээр хамгаалах тухай” хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. - "Малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх тухай" журам ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А-01 тушаалаар батлагдсан боловч ХЗДХ-ийн яамнаас буцаагдсан. - “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос ноолуур бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн - ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-135 дугаар тушаалаар хуваарилав. “Гацуурт” ХХК - иас эргэн төлөлтөөр авах 100 толгой хээлтүүлэгчээс аймгуудын ХХААГазарт олгов. 52 аж ахуйн нэгжид үйл ажиллагаанаас нь хамааруулан 10-20 сая төгрөгийн хөнгөлөлттэй 5 жилийн хугацаатай зээл олгов. Нийт 39 төсөл ирүүлснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3,6 хувийн хүүтэй олгохоор тушаал гаргуулан хэрэгжилтийг хангасан. - "Шинэ хөдөө шинэ амьдрал" аяны баримт бичгийг ХХААХҮ-ийн сайдын А-106 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж бүх яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх талаар Монгол улсын Засгийн газрын хуралдаанд мэдээлэл, танилцуулга хийж, 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэл гарсан. Энэхүү тэмдэглэлээр: 1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор иргэдийг байнгын ажлын байртай, тогтмол орлоготой болгох Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийг батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгав. 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт үүрэг болгов.	60
	6.1.2. Малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Орон нутгийн хоршоод болон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор Олон улсын хоршооллын өдрийг тэмдэглэх, хоршооны бүтэц, бизнесийн менежмент, Мах сүүний анхдугаар аяны хүрээнд түүхий эд бэлтгэлийг	40	- 2018 онд сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа нийслэлийн ойролцоох аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг хэлэлцэн Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан нийт 39 төсөл ирүүлснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн малын чанарыг сайжруулах, фермийн байр засах, тэжээлийн нөөц бүрдүүлэх болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нь	70

		<p>хоршоодоор дамжуулж хэрхэн бэлтгэх, сүү цагаан идээ боловсруулах талаар туршлага судлах аялал, үзүүлэх сургалтыг 2017 оны 06 дугаар сарын 28-30 өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган, Их Тамир, Тариат сумдад 21 аймаг тус бүрээс 3, нийслэлийн 5 хоршооны төлөөлөл, 21 аймгийн ХХААГ-ын ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгууллаа. Үзүүлэх сургалтын хүрээнд Ар арвижин дэлгэрэх хоршоо, Баялаг хангайн сор дундын хоршоо, Од кр хоршоодын үйл ажиллагаатай танилцаж туршлага судлан хоршооны талаар төрөөс баримтлах бодлого, Мах сүүний анхдугаар аяны хүрээнд түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд хоршоодыг хэрхэн оролцуулах талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.</p>	<p>зориулж сүү-махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3,6 хувийн хүүтэй олгохоор ХХААХҮС-ын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-163 дугаар тушаал гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулав. ЖДҮХС-аас төслийн шаардлага хангасан мах, сүүний үхрийн фермерийн 30 аж ахуйн нэгжид 14.1 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.</p> <p>- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 389 малчдын бүлэг 3890 га бэлчээрийг бэлчээр ашиглах гэрээ байгуулан 15 жилийн хугацаатай бэлчээрийг гэрээгээр ашиглаж байна.</p> <p>- Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, байнгын ажилтай, тогтмол орлоготой болгох, малчин ажил олгогч болон туслах малчдын хөдөлмөрийн харилцааг сайжруулах зорилгоор хот суурин газраас хөдөө, орон нутагт шилжин суурьшиж, олон малтай малчны малыг гэрээгээр маллах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Гэрээт малчин – өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-ийг 2018 оны 8 дугаар сараас хэрэгжүүлээ. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрт 2018 оны эцсийн байдлаар нийт 225 ажил олгогч малчин, 223 гэрээт малчин өрхийн 406 иргэн ажлын байраар хангагдаж 51,0 сая төгрөг зарцуулсан байна. Энэхүү төслийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээ болгон боловсруулж, ХЭҮЗ-ийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор шинэчлэн батлан хэрэгжүүлж байна.</p> <p>- “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.2.2, 3.2.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.27.1 дэх заалт, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-57 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын XII.1.5.1 дэх заалтыг хэрэгжүүлж, Махны чиглэлийн өндөр ашиг шимт хонины үржлийн аж ахуй байгуулах зорилгоор төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, махны чиглэлийн нийт 651 толгой үржлийн эм хонь, 36 толгой хуц, бүгд 687 толгой хонь импортлохоос нийт 621 толгой үржлийн эм, 36 толгой хуц бүгд 657 хонийг 2017 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Франц улсаас импортлон оруулж ирсэн. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-216 дугаар тушаалын 2 дахь заалтын дагуу хоёрдугаар үе шатны гэрээ буюу хонины үржлийн аж ахуй байгуулж, өсгөн үржүүлэх гэрээг “Тайшир-Өргөө” ХХК-тай байгуулав. 2018 онд дээрх хониноос 200 гаруй төл бойжуулаад байна. 2011 онд “Гацуурт” ХХК-тай байгуулсан “Махны цэвэр үүлдрийн үхэр импортлож үржлийн аж ахуй эрхлэх төсөлд дэмжлэг үзүүлэх” зээлийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулж, эргэн төлөлтийн 200 толгой өсвөр үхрийг хүлээн авч ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-135 дугаар тушаалаар хуваарилав. 2018 онд Улсын төсвийн санхүүжилтээр Булган аймагт “Цэвэр үүлдрийн өндөр</p>
--	--	--	---



			ашиг шимт бух, хуц, ухна, гүн хөлдөөсөн үр, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерт зарлаж “Герефорд” үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100-н толгой, Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160 толгой, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200 толгой, Эрчмийн хар үүлдрийн үржлийн өсвөр ухна 180 толгой, Герефорд үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үр 6000 ширхэг, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлүүлэх ажлыг Булган аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/446 тоот захирамжаар байгуулагдсан бараа хүлээж авах ажлын хэсгийн хүлээн авсан тухай актыг үндэслэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А\181 дугаар тушаалаар Мал аж ахуйн чиглэлээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэг малыг хүлээн авч Булган аймгийн ХХААГазарт хүлээлгэн өгөв. Энэ ажил бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 665 малчин болон аж ахуйн нэгжийн малд сайжруулагчаар ашиглах болсон.	
6.1.3. Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ;	2017 онд 888.0 мянган толгой мал хорогдсон нь 1.4 хувийг эзэлж байна. Малчдын түвшинд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг эртнээс хангуулах, малчдад чиглэсэн хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах	70	-	-
6.1.4. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна;	2017 онд Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц 57.0 хувьтай байсантай холбогдуулан Төсвийн тодотгол 4.5 тэрбум төгрөгийг батлуулан олгосноор 100 хувь болсон. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн байх	70	2018 оны 4-р сарын 26-28-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Монгол улсын Шадар сайдын 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журмыг хэрэгжүүлэх, үйл явдалд суурилсан тандалтын програмыг турших сургалт, дадлага сургуулилтыг амжилттай зохион байгуулагдлаа. Гамшигийн эрсдэлийг бууруулах, салбар хоорондын байгууллагуудын мэдээлэл солилцох механизмыг бүрдүүлэх, хамтын ажиллагаа, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг авах харилцааг зохицуулсан журмыг хэрэгжүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулахад дадлага сургуулилтын ач холбогдол оршино. Уг үйл ажиллагаанд Шадар сайдын ажлын алба, ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймгийн салбар	70

			хоорондын байгууллагуудын төлөөлөл 50 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан байна. Эрүүл мэндийн /Health Cluster/-ийн олон улсын хамтын ажиллагааны бүлгэмийн анхдугаар хурлыг зохион байгуулж, яаралтай тусламжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ОУ-ын байгууллагуудад танилцуулж, хэлэлцүүлэг хийлээ.	
6.1.5. Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ;	2013 оны Засгийн газрын 30 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн бирж ХХК байгуулагдан амжилттай ажиллаж байна. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 163 удаагийн сфот арилжаа зохион байгуулж 6955.7 тн ноолуур, 10887.6 тн хонины ноос, 355.5 тн тэмээний ноос, 1674.1 тн ямааны завод ноос, 1206.7 тн хонины завод ноос арилжиж нийт 572.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн. 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр форвард арилжааг амжилттай зохион байгуулж, Малчид, хоршоод малын гаралтай түүхий эдийн зах зээлийн үнэ бодитоор тогтоход оролцох, зах зээлийн үнэ хэт унах эрсдэлээс сэргийлэх, түүхий эд боловсруулах үйлдвэрүүд түүхий эд нийлүүлэлтийн эрсдэл болон зах зээлийн үнэ хэт хөөрөгдөх эрсдэлээс тус тус сэргийлэх боломжуудыг бүрдүүлсэн.	40	- НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “Монгол улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (Бүрэлдэхүүн хэсэг 2): Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төслийн санхүүжилтээр сүүний цехийн тоног төхөөрөмжийг Дорнод, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн 6 сумын эмэгтэйчүүдийн сүү үйлдвэрлэгчдийн бүлгүүдэд хоногт 500 л сүү боловсруулах хүчин чадалтай нийт 63 гаруй сая төгрөгийн гэр цехийн тоног төхөөрөмжийг 2018 оны 6 дугаар сард хүлээлгэн өгсөн. Сүүний боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор “Сүүний хөргөлтийн танк, цахилгаан хөдөлгөөнт саалтуур” нийлүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нийлүүлсэн тоног төхөөрөмжийг 2018 оны 11-р сарын 23-нд хүлээн авч Мал хамгаалах санд шилжүүлсэн. Энэ арга хэмжээний дүнд 10 ширхэг сүүний хөргөлтийн танк, 144 ширхэг цахилгаан хөдөлгөөнт саалтуурыг сүүний чиглэлийн эрчимжсэн үхрийн фермер, аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон. “Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, малын гаралтай нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ”-г сургалт зохион байгуулав. - Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9 заасны дагуу ХХААХҮСайдаар батлуулахаар Малын бүртгэлийн журмын төслийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтээс санал авч эцэслэн боловсруулж байна. Тус журманд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн бүртгэлээр дамжуулан мал болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох заалтууд тусган бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг сайжруулах боломж бүрдсэн. Малын гаралтай түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал, орон нутагт түүхий эдийн тордолтын цэг байгуулах шаардлага, сайжруулах арга замын талаарх судалгааг хийсэн.	55
6.1.6. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын хэмжээнд нийт 84 тэрбум төгрөгийг орон нутгийн хоршоо, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, орлого ашгийг нэмэгдүүлэх хүрээнд олгож байна. Үүнээс 16 хувь буюу 13.4 тэрбум төгрөгийг нь малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах	40	-	-

	далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ;	жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон байна.			
	6.1.7. Эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50 хувиар өснө;	2017 оны урьдчилсан дүнгээр 228.9 мянган малтай өрх тооллогод хамрагдсан бөгөөд өмнөх оныхоос 5.2 мянга буюу 2.3 хувиар өссөн байна. Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэн үзвэл, 200 хүртэл малтай өрх өмнөх оныхоос 1.8 пунктээр буурсан бол, 201-ээс дээш малтай өрх 0.04-1.0 пунктээр өсжээ. Эндээс харахад олон малтай өрхийн тоо нэмэгдэж байна. Шинээр малтай болсон буюу анх удаа мал тооллогод хамрагдаж байгаа өрхийн тоог бүсээр харуулбал, Баруун бүсээс бусад бүх бүсэд шинээр малтай болсон өрхийн тоо 2016 оныхоос өссөн байна. Шинээр малтай болсон өрхийн 33.4 хувь нь Хангайн бүсэд байна. Эндээс дүгнэлт хийхэд эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50-с доошгүй хувиар өссөн байна.	40	-	-
	6.1.8. Эхний үе шатанд эрүүл мэндийн даатгалд малчдын 70-аас доошгүй хувийг, нийгмийн даатгалд малчдын 50-аас доошгүй хувийг хамруулсан байна.	2017 оны дүнгээр нийт малчдын 23.9 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Энэхүү мэдээллийг бид Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан”-гийн мэдээлэлтэй регистрийн дугаараар нь тулгаж, нарийвчлан шалгана.	40	-	-
2-р үе шат	6.2.1. Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно;	Нийгмийн даатгалд хамрагдсан малчдын 30 хувь нь 35-44 насны, 27 хувь нь 45-54 насныхан байна. Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэхээр заасан. Энэхүү арга хэмжээний хүрээнд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын төв, орон нутгийн газар, хэлтсийн дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж байна. 2012 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдвал зохих 261.8 мянган малчин, үүнээс эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгалд сайн дураар 127.1 мянган малчин хамрагдсан бол 2016 оны байдлаар хамрагдвал зохих 280.5 мянган малчнаас нийгмийн даатгалд сайн дураар болон эрүүл мэндийн даатгалд 191.5 мянган малчин	70	- "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль" баталсан. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг Засгийн газар батална гэж заасан. Мөн хуулийн 8 дугаар зүйлд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж тус тус заасан тул ХНХЯам энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрөөр малгүй болон цөөн малтай 18-45 насны өрхийг хамруулах, аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамруулах, туршлага солилцох уулзалт, нэгдсэн өдөрлөг яармаг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд 2018 оны эцсийн байдлаар 3663 өрхийг хамруулж, 5,828,6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна. - Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль"-ийг баталж, нийгмийн даатгалын байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 4 жил гаруй хугацаанд уг хуулийг хэрэгжүүлснээр нийт 607,7 үүнээс 112.0 мянган малчин хамрагдаж 11 хүртэл жил ажилласнаар нөхөн тооцуулсан. Энэ хуулийн зорилт өөрөөс нь үл хаммаарах	70

	<p>хамрагдсан нь 2012 оноос 19.8 пунктээр өссөн байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалд 110.0 мянган малчин, нийгмийн даатгалд 37.6 мянган малчин сайн дураар даатгуулсан нь 2016 онтой харьцуулахад 14 пунктээр буурсан байна. Малчдын нийгмийн даатгалын хамралт буурахад дараах хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай” тогтоолоор баталсан “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг малчдад олгохоор заасан. Уг зээлийг олгохдоо малчдыг эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ерөнхий шаардлагыг тавьсан. Уг арга хэмжээний хүрээнд 2016 онд нийгмийн даатгалд даатгуулсан малчны хамралт нэмэгдсэн боловч 2017 онд “Сайн малчин” хөтөлбөр зогссон; - Монгол Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хууль батлагдсантай холбогдуулан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2018 оны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан хүлээлт үүссэн зэрэг болно 		<p>шалтгаанаар 1990-2000 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох боломж олгосон болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль” баталсан. Энэ хуулиар 1995 оноос энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь тасарсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нар тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 хувиар тооцон нэг удаа нөхөн төлөх харилцааг зохицуулсан болно.</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын хэмжээнд нийт 52,419 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагджээ. <p>Нийт үзүүлсэн хүмүүсийн 66% (20,847) нь цалин хөлстэй ажиллагсад байсан бол үүний дараа хувиараа хөдөлмөр эрхлэгчид 27% (8,481)-ийг эзэлж байна. Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан, товллол, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцыг баталж, тогтвортой тогтолцоо бий болголоо. Энэхүү товллол, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцын хүрээнд 30 наснаас эхлэн нас, хүйсийн онцлогт нийцүүлж, элэг, бүдүүн шулуун гэдэс, ходоод, хөх, умайн хүзүү, түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгт Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хамрагдах боломж бүрдсэн. Энэхүү үйл ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойших 2 сарын хугацаанд 52 000 гаруй иргэн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна. Нийт үзлэгийн 67% (35,135) эмэгтэйчүүд давамгайлж, эрэгтэйчүүд 33% (178351)-тай байна. Үүнээс насны бүлгээр ангилахад 46-64 насны эмэгтэйчүүдийн хамрагдалт хамгийн өндөр 29%-тай байна.</p> <p>2018 онд 158,065 малчныг даатгалд хамруулахаас 112,145 малчин иргэнийг хамруулж хамралт 71%-тай байна.</p>	
<p>6.2.2. Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;</p>	<p>15-24 насны малчдын 11 хувь нь, 25-34 насны малчдын 16 хувь нь, 35-44 насны малчдын 25 хувь нь, 45-54 насны малчдын 32 хувь нь, 55-64 насны малчдын 33 хувь нь нийгмийн даатгалд хамрагддаг байна.</p>	<p>40</p>	<p>“Мал аж ахуйн тогтвортой хөгжил” малчдын улсын зөвлөгөөнийг 2018,05,17-ны өдөр Улаанбаатар хотод 800 гаруй төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулав. Малчдын зөвлөгөөнөөр мал аж ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулав. УИХ-аар шинээр батлагдсан “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Малын генетик нөөцийн тухай” хуулийг танилцууллаа. “Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулж, 21 аймаг 330 сумын 12600 малчдаас “Бэлчээр ашигласны төлбөр авах тухай санал асуулгын дүнг танилцуулж хэлэлцүүлэв. Мөн малчдын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгааллын талаар мэдээлэл хийв. Малчдын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг сайдад өргөн барив. 2018 оны 4-р сард Дундговь, Өмнөговь аймгуудад томилолтоор явж “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд Дундговь аймгийн 14 сумын 120 хүн оролцсон. Үүнд сумдын засаг дарга, мал зүйч, малын эмч, аймгийн</p>	<p>100</p>

			<p>удирдлагууд, малчид оролцуулан “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулсан.</p> <p>2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Төв аймгийн Борнуур суманд “Сүү үйлдвэрлэгч фермерүүдийн зөвлөлдөх уулзалт, зөвлөгөөнд оролцож ЭМАА-өнөөгийн байдал цаашдын зорилтын талаар болон “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулав. Малын генетик нөөцийн тухай болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиудыг орон нутагт сурталчлах, сургалт зохион байгуулах ажил батлагдсан хуваарийн дагуу нийт нийслэл, аймгуудад 100 хувь хийлээ. Уг сургалтыг нэг аймагт 2-3 бүс болгон Тойргийн сумдын малчид мал аж ахуйн мэргэжилтнүүдийг оролцуулав. Нийт 21 аймаг, нийслэлд нийт 8000 гаруй хүн хамрагдсан болно.</p>	
6.2.3. Хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 80 хувиар өснө.	Хугацаа болоогүй байна.	-	<p>Хөдөлмөр халамж үйлчилгээний Ерөнхий газраас Зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй гэр бүлийг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгоход чиглэгдсэн юм. Улмаар энэ оны эхний 10 сарын байдлаар нийт 511 иргэн хамрагдаж 90,991.9 мянган төгрөг зарцуулж 511 ажлын байр бий болсон байна. Тодруулбал, Сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 6 аймгийн 30 бүлгийн 176 иргэд хамрагдаж 49,767.3 мянган төгрөгийг; Хорооны ажилгүй иргэдийг багийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 9 дүүргийн 56 багийн 335 иргэд хамрагдаж 41,224.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p>	70

Тайлбар: *0=Хэрэгжээгүй, 40=Хэрэгжилт сул, 70=Хэрэгжилт сайн,

100=Хэрэгжилт маш сайн

Эх сурвалж: ХХААХҮЯ (2018, 2019)

Дээрх хүснэгтэд 2017 оны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон үнэлгээг ХХААХҮЯ-ны тус бодлогын ХШҮ-ний тайлангаас шууд авав, харин 2018 оны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тус бодлогыг хэрэгжүүлэх 2 дахь үе шатны төлөвлөгөөнд туссан зорилт тус бүрийн биелэлтээс түүж, оноо тус бүрийг дундаж оноог хүснэгтэд оруулав.

Дараах хэсэгт шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний талаар дэлгэрэнгүй авч үзлээ.

1-р үе шатны шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт 6.1.1. Малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ. Тус шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 2017 онд 70 байснаа 2018 онд 60 болж буурчээ. Гэвч энэ шалгуур үзүүлэлтийг бодитой үнэлэхэд төвөгтэй.

Шалгуур үзүүлэлт 6.1.2. Малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно. Малчдын бүлэг, фермер, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжиж байгаа бөгөөд тус үзүүлэлтийн хэрэгжилт 70%-тай байна.

Шалгуур үзүүлэлт 6.1.3. Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ. Тус шалгуур үзүүлэлтийг хангах ажил 2017 онд хийгдсэн бөгөөд үнэлгээ нь 70% байна, гэвч 2018 онд энэ шалгуур үзүүлэлтийг хангах ажил хийгдээгүй байна.

Шалгуур үзүүлэлт 6.1.4. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна. 2017, 2018 онд мал аж ахуйн салбарын эрсдлийг бууруулах тал дээр нэлээд ажил хийгдсэн тул түүний үр дүнд үнэлгээ өндөр буюу 70% байна.

Шалгуур үзүүлэлт 6.1.5. Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ. Мал аж ахуйн зах зээлийг өргөтгөх, худалдаа арилжаа явуулах боломжийг бүрдүүлэх ажил хийгдэж байгаа тус шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт хангалттай өндөр биш буюу 40-55%-тай байна.

Шалгуур үзүүлэлт 6.1. Шалгуур үзүүлэлт 6. Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ. 2017 онд сум хөгжүүлэх сангаас ЖДҮ-т малын гаралтай түүхий эд боловсруулах төслүүдэд олгосон нь тус шалгуурын 40%-ийг хангахад хүргэсэн байна. Гэвч 2018 онд энэ шалгуурыг хангах ажил хийгдээгүй байна.

Шалгуур үзүүлэлт 6.1.7. Эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50 хувиар өснө. Тус үзүүлэлт дээр 40%-ийг хэрэгжилттэй гэж ХХААХҮЯ дүгнэсэн байна. Гэвч энэ үзүүлэлтийг хангасан эсэхийг судалгааны үндсэн дээр гаргах нь зүйтэй, мөн тус үзүүлэлтийн хэрэгжилтийг 2015 оноор тасалбар болгон үнэлэх ёстой байсан.

Шалгуур үзүүлэлт 6.1.8. Эхний үе шатанд эрүүл мэндийн даатгалд малчдын 70-аас доошгүй хувийг, нийгмийн даатгалд малчдын 50-аас доошгүй хувийг хамруулсан байна. 2017 оны байдлаар нийт малчдын 23.9% нь нийгмийн даатгалд хамрагдсан байгаа тул тус үзүүлэлтийн үнэлгээ нь 40% байна. Гэвч энэ үзүүлэлтийг хангасан эсэхийг судалгааны үндсэн дээр гаргах нь зүйтэй, мөн тус үзүүлэлтийн хэрэгжилтийг 2015 оноор тасалбар болгон үнэлэх ёстой байсан.

2-р үе шатны шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт 6.2.1. Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно. 2018 онд 158,065 малчныг даатгалд хамруулахаас 112,145 малчин иргэнийг хамруулж хамралт 71%-тай байгаа тул энэ үзүүлэлтийн хэрэгжилтийг 70%-иар үнэлжээ.

Шалгуур үзүүлэлт 6.2.2. Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна. Энэ үзүүлэлтийг биелэлт 2018 онд 100% байна гэж ХХААХҮЯ дүгнэжээ. Гэтэл тус шалгуур үзүүлэлт биелсэн эсэхийг шалгах арга зүй дутмаг, тиймээс энэ үнэлгээ нь бодитой гэдэг нь эргэлзээтэй юм.

Шалгуур үзүүлэлт 6.2.3. Хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 80 хувиар өснө. Малчдын орлогыг нэмэгдүүлэх хэд хэдэн арга хэмжээг төр засаг, олон улсын байгууллага, хувийн хэвшил хийж эерэг үр дүнгүүд гарч байгаатай санал нэг байна. Гэвч түүвэр судалгаа нь нийт малчдыг төлөөлж чадах эсэх нь эргэлзээтэй.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017, 2018 оны хэрэгжилтээр үнэлэн дараах зурагт харуулав.

Зураг 6. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” шалгуур үзүүлэлтийн биелэлт (2017, 2018 он)



Тайлбар: *Тухайн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2017 оны биелэлтээр, бусад үзүүлэлтийг 2018 оны биелэлтээр тооцов.

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны ХШҮ-ний тайланд үндэслэсэн зохиогчдын тооцоолол

Дээрх зургаас харахад “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт дунджаар 2017-2018 онд хүрсэн үр дүнгээр тооцоход 62%-тай байна. Харин 1-р үе шат буюу 2009-2015 оны шалгуур үзүүлэлт (6.1)-ээр үзэхэд тус бодлогын шалгуур үзүүлэлтүүд дунджаар 56%-ийн биелэлттэй, харин 2-р үе шат буюу 2016-2020 оны


шалгуур үзүүлэлтүүд (6.2) дунджаар 80%-ийн биелэлттэй байна¹. 1-р үе шатны хэрэгжилтийн шалгуур хангах түвшин 2-р үе шатныхаас бага байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд:

2018 оноос өмнө тус бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө байгаагүй, улмаар санхүүжилт олгох арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эзэн нь тодорхойгүй байсан. Харин 2018-2020 онд тус бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаар эдгээр тодорхойгүй байдал бага зэрэг буурсан.

2017-2018 онд хийгдсэн нийт ажлын тоо 169 бөгөөд үүний 123-ыг буюу 73%-ийг 2017 онд, үлдсэн 46-г буюу 27%-ийг 2018 онд хэрэгжүүлсэн. 2017 хийгдсэн ажлуудаас 1 ажлын үнэлгээг “Хугацаа нь болоогүй” шалтгаанаар үнэлээгүй байхад 2018 онд энэ үзүүлэлт 14 болж өссөн. Эндээс харахад хэдийгээр 2018 онд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан ч шалгуур үзүүлэлт тус бүрийн хэдэн онд ямар түвшинд хүрсэн байхыг тусгаагүй тул шалгуур үзүүлэлтийг хянаж, үнэлэхээс өмнө “хугацаа нь болоогүй” гэж хойшлуулах боломж бүрдэж байна. Нөгөөтэйгүүр хугацаа нь болоогүй ажлын тоо их байх тусам, гүйцэтгэлийн хувь өндөр гарч байна.

2018 онд хийгдсэн 40 хүртэлх хувийн хэрэгжилттэй ажлын тоо огцом буурсан байна.

Зураг 7. 2017-2018 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн ажлын өөрчлөлт



Эх сурвалж: ХХААХҮЯ-ны ХШҮ-ний тайланд үндэслэсэн зохиогчдын тооцоолол

3.2.3 Орон нутгаас ТМТББ-ын хэрэгжилтэд өгсөн санал, шүүмж

1. Малын эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд хийгдсэн ажил

Алдаа дутагдал:

Зарим аймагт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний хөлс нийт малын 20%-д ногдож байгаа нь хэт бага.

¹ 6.1.1-6.1.8-д заасан шалгуур үзүүлэлтүүд нь 1-р үе шатны бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хариун 2.1.1-2.1.3-д заасан шалгуур үзүүлэлтүүд нь 2-р үе шатны бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт болно.



Хоршиж нэгдэх гарааны бизнес эрхлэх нөхцөл бололцоо муу байна. (Малчны зээл хүү жилийн 24%)

Тендерээр нийлүүлэгдсэн мал эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт дутмаг, малын эмч нарыг чадавжуулах сургалт хангалтгүй

Зарим аймгуудад бруцеллез өвчний жил бүр, адууны ям, онд хонь, ямааны цэцэг, шүлхий өвчин тус тус оношлогдсон байна.

Санал шүүмж:

Малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад зарим аймаг, орон нутагт төсөв хүрэлцдэггүй тул санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Түүхий эдийн үнийг өсгөх, өрхийн үйлдвэрлэл буюу бичил бизнес эрхлэх нөхцөлөөр хангах. Түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг бодитоор дэмжих.

Дорноговь аймгийн хувьд “ТМТББ”-ыг хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг гүйцэтгэх зардлыг орон нутгийн төсөвт заалт тус бүрээр тусгах.

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

Вакцины нийлүүлэлт оройтох, вакцин хангалттай хэмжээнд ирэхгүй байх, мал эмнэлгийн үйлчилгээний хөлс олгогдохгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байна.

Халдварт өвчний хорио цээрийн бүсэд ажилласан ажилтан албан хаагчдын томилолт, ажлын хөлс бусад зардал бүрэн олгогдохгүй байна.

Малын чанарыг сайжруулах сайн чанарын хээлтүүлэгч авахад малын эрүүл мэндийн баталгаатай өсвөр хээлтүүлэгч бойжуулан борлуулдаг найдвартай аж ахуй нэгж ховор байна.

2. Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил

Алдаа дутагдал:

Малын үржил селекцийн багаж, тоног төхөөрөмж дутагдалтай байна.

Малчид дур мэдэн дур зоргын хээлтүүлгийг ихээр хийж байна

Санал шүүмж:

Дорноговь аймгийн хувьд “ТМТББ”-ыг хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг гүйцэтгэх зардлыг орон нутгийн төсөвт заалт тус бүрээр тусгах.

Нэгдсэн ангилалт хийх зардал байхгүй. Зөвхөн бензиний зардлыг гаргадаг

Бог малын хээлтүүлэгчийг үржлийн нэгжид шилжүүлэх суурь зардал байхгүй

3. Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй.

Бэлчээрийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа учир зарим заалтуудыг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна.

Орхон аймгийн хувьд аймаг, сумдын хилийн цэсийг дахин шинэчлэх, газар нутаг бага байна.

4. Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлах

Алдаа дутагдал:

Худаг ус сэргээн засварлаад захиран зарцуулах эрх байдаггүй.

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

Худаг ус сэргээн засварлаад захиран зарцуулах эрх малчдад байдаггүй.

Бэлчээрт худаг гаргахад уст цэгийн хайгуул хийлгэх хэрэгтэй байна.

5. Хадлан бэлтгэл

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

6. Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл

Санал шүүмж:

Дархан-Уул аймагт иргэд, фермер эрхлэгчдэд 100 га талбайг ашиглалтын гэрээгээр ашиглуулж, ногоон тэжээл тариалж маллын тэжээл бэлтгэж байна..

7. Малчдын эрүүл мэнд

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

Дорноговь аймагт ТМТББ-ыг хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.

8. Малчдын боловсрол

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

9. Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

10. Дэд бүтэц (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт/



Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

Төрөөс нэгдсэн дэд бүтцийн талаар бодлого хэрэгжүүлж, дэмжих Төрөөс нэгдсэн бодлого хэрэгжүүлж, дэмжих

Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид

Санал шүүмж:

Говь-Алтай аймгийн хувьд төсөв байхгүй тул уг хөтөлбөрийн хүрээн дэх аливаа ажлуудыг гүйцэтгэх боломжгүй байна.

3.3 МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН

3.3.1 Ерөнхий мэдээлэл


2019 оны 8-р сард “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ өгөх ажлын хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хэрлэн багийн санамсаргүй сонгогдсон 22 малчин өрхөөс санал асуулга авлаа. Тэдгээр өрхийн 59%-ийг 26-40 насны малчид, өрхийн тэргүүнүүдийн 55% нь бүрэн бус дунд боловсролтой байв.

Судалгаанд хамрагдсан нэг малчин өрхөд ногдох малын тоог авч үзвэл 41-55 насны малчин өрхөд хамгийн өндөр буюу нэг малчин өрх дунджаар 1491 толгой малтай, 56-70 насны нэг малчин өрх дунджаар 680 толгой малтай, 26-40 насны нэг малчин өрх дунджаар 471 толгой малтай байна.

3.3.2 Бодлогын баримт бичгийн талаарх малчдын ойлголт, үнэлгээ

Нийт судалгаанд хамрагдсан малчдын 50 хувь нь “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн талаар мэддэг, үлдсэн 50 нь мэддэггүй, бодлогын баримт бичгийн талаар мэддэг малчдын 72.7% нь 26-40 насны малчид байна. Тус бодлогын баримт бичгийн мэддэггүй малчдыг насны хувьд авч үзэхэд 26-40 насны малчид мөн л ихэнх хувийг буюу 45.5 хувийг эзлэж байна.


Зураг 8. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын талаарх малчдын ойлголт, насны бүлгээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн бодлогын баримт бичгийн малчин өрхөд үзүүлж буй нөлөөллийг авч үзэхэд бодлогын баримт бичиг мэддэг малчдын 50 хувь нь өрхөд эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан ба ямар өөрчлөлт гаргасныг дараах зургаар харуулав.

Зураг 9. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын малчдад үзүүлж буй нөлөө



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт малчдын тал хувь нь тус бодлогын талаар мэддэг, тэдний ихэнх нь 26-40 настай байв. Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар тус бодлогын нөлөөгөөр, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт нэмэгдсэн, мөн малжуулах төсөлд хамрагдсан байна.

Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан малчдын 40.9% нь тус бодлогыг “Маш муу, муу” гэж үнэлж байна. Учир нь төр засгаас тус бодлогыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт хангалттай зохион байгуулдаггүй, мөнгө санхүү дутмаг зэрэг болно. Гэхдээ малчдын дунд тус бодлогын талаарх мэдлэг тааруу байгаа учраас тухайн бодлогын хэрэгжилт хэр түвшинд байгааг төдийлөн бодитой үнэлэх боломжгүй байсан.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээг насны бүлгээр авч үзвэл 26-40 насны малчид дунджаар 1.9 оноо (буюу “муу”), 41-55 насны малчид 2.0 оноо (буюу “муу”), 56-70 насны малчид 2.8 оноо (буюу “Дунд”)-ны үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 9. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээ

Насны Ангилал	Малчдын тоо	Маш муу 1	Муу 2	Дунд 3	Сайн 4	Маш сайн 5	Үнэлгээ өгөөгүй
26-40	13	2	4	4	1		2
41-55	4	1	2	1			
56-70	5			2	2		1
Нийт	22	3	6	7	3		3

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.3.3 Малчдын санал

Судалгаанд хамрагдсан малчид тус бодлогын хэрэгжилттэй холбоотой цаашид анхаарах зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сумын зааг тогтоох, бэлчээрийн даацыг зохицуулах, ашиглалтад хяналт тавих, малын тоо бус чанарт анхаарах, бэлчээрийн даац хэтэрч нүүх газаргүй болсон,
- Малын гаралтай түүхий эдийн үнэд анхаарах, тогтворжуулах, ченжүүд дээр арга хэмжээ авах (түүхий эдийг хямд үнээр авдаг тохиолдлыг багасгах),
- Бэлчээр, худаг усны маргааныг шийдвэрлэх,
- Хэт олон мал байснаар (мянгат малчдын) бэлчээр муутгаж байгаа учир малын хөлийн татвар тогтоох хэрэгтэй,
- Даатгал үр ашиггүй байгааг анхаарах,
- Эрчимжсэн МАА (фермер)-д шилжихэд дэмжлэг өгөх хэрэгтэй,
- Бэлчээрийн газар эзэнтэй болсноор нөөц газаргүй болсон бөгөөд малчдын дунд маргаан үүсч байна,
- Махны экспортыг нэмэгдүүлэх,
- Худгийн хүртээмж, бэлчээр талхлалттай холбоотой малын тоо толгойг бууруулах буюу чанаржуулах зэрэг саналуудыг малчид өгсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдарч буй хөдөө, орон нутгийн малчдын боловсрол, нийгэм, эрүүл мэнд, хувь хүний хөгжлийг хангахад чиглэсэн төрийн бодлого юм.

Тус бодлогын хэрэгжилт дунджаар 2017-2018 онд хүрсэн үр дүнгээр тооцоход 62%-тай байна. Харин 1-р үе шат буюу 2009-2015 оны шалгуур үзүүлэлт (6.1)-үүд дунджаар 56% хангагдсан, харин 2-р үе шат буюу 2016-2020 оны шалгуур үзүүлэлт (6.2)-үүд дунджаар 80%-ийн биелэлттэй байна. Хэрэгжилтийн түвшин өссөн нь нийт хийгдсэн ажлын тоо цөөрсөн, хугацаа нь болоогүй ажлын тоо нэмэгдсэн (зорилтот түвшинг оноор гаргаагүй), хугацаа хоцрогдолтой ажлын тоо мөн багассантай холбоотой.

Тус бодлогод малчдад тулгамдаж буй нийгмийн олон асуудлыг шийдвэрлэх бодлогын чиглэлүүд тусгагдсан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний дараа хянах, үнэлэхэд хэд хэдэн бэрхшээл тулгарч байна.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 6-р зүйлд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, шалгуур үзүүлэлт”-ийг 1, 2-р үе шат тус бүрээр оруулсан. Гэтэл 6-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтүүд нь бодлогын үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хангаж чадахгүй байна. Учир нь:

Нэг шалгуур үзүүлэлтэд хоорондоо ялгаатай хэд хэдэн үзүүлэлтийг нэгтгэсэн. Тухайлбал 6.1.1 шалгуур үзүүлэлтэд “Малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ” гэж заасан. Гэтэл энэ шалгуурт малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн гэсэн 3 төрлийн орчин бүрдсэн эсэхийг хэрхэн үнэлэх нь ойлгомжгүй байна.

Шалгуур үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийг хэмжих арга, аргачлалыг боловсруулаагүй тул ХШҮ хийж байгаа этгээд өөрийн дураар аль ч талаас нь тайлбарлах боломжтой байна. Тухайлбал, 6.1.3-т “Малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг туслалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ” гэж заасан. Гэвч малчдын байгууллагын тогтолцоо бүрэлдэн бий болсон эсэхийг хэрхэн тогтоох вэ? Ямар арга аргачлалаар тус шалгуурыг хангасан эсэхийг хэмжих нь эргэлзээтэй.

Тоон үзүүлэлтээр хэмжигдэх боломжтой шалгуур үзүүлэлт дээр зорилтот түвшинг тоон үзүүлэлтээр тогтоогоогүйгээс болж тухайн шалгуурыг өчүүхэн бага тоон үзүүлэлтийн өсөлтөөр хангасан мэт харагдах боломжтой байна. Тухайлбал, 6.1.5-д “мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ” гэж заажээ. Гэтэл малчдын орлого хэдэн хувиар өссөн байх ёстойг тодорхой зааж өгөөгүй, тиймээс малчдын жилийн бодит орлого 1 төгрөгөөр нэмэгдсэн л бол энэ заалт хангагдлаа гэж үзэх



болно, гэвч энэ 1 төгрөгний өсөлт эсвэл 1 сая төгрөгний өсөлт хоёрын зөрүү асар их байна.

“Төрөөс малчдын талаарх баримтлах бодлого” болон “Монгол мал” үндэсний хөтөлбөр хооронд давхцал ихтэй. Тиймээс орон нутгийн түвшинд Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол мал хөтөлбөрийн хэрэгжилтэд оруулсан ажлаа давхардуулж оруулах хандлагатай. Үүнийг ХШҮ-ний жил жилийн тайланд бас дурдаж байсан.

Нөгөө талаас хөдөө орон нутгаас ирсэн тоо мэдээг харахад “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын зорилт тус бүрээр хийгдсэн ажлаа бичихийн оронд ерөнхийд нь бичиж бидэнд ирүүлсэн байна. Эндээс үзэхэд тус бодлогын баримт бичгийн аль зүйл, заалт нь ямар утга учиртай талаар орон нутгийн мэргэжилтнүүдийн дунд ойлголт сул байна.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д тус бодлогын санхүүжилтийн хэмжээ нь улсын төсвийн 1-ээс доошгүй хувь байна гэж баталсан боловч энэ бодлого огт хэрэгжээгүй. Учир нь нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй, 2018-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан боловч санхүүжилтийн хэмжээ тавигдаагүй. Тиймээс төсвийн зарцуулалтын судалгаа хийх боломжгүй. Орон нутгийн ХХААГ-аас Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын төсвийг мэдээллийг лавлахад 12 аймагт тус бодлого мөнгө төсөвлөн зарцуулж байна. Энэ нь Монгол мал үндэсний хөтөлбөртэй харьцуулахад бага үзүүлэлт юм.

Судалгаанд хамрагдсан нийт малчдын тал хувь нь тус бодлогын талаар мэддэг, тэдний ихэнх нь 26-40 настай байв. Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар тус бодлогын нөлөөгөөр, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт нэмэгдсэн, мөн малжуулах төсөлд хамрагдсан байна. Гэхдээ ерөнхий үнэлгээгээр тус бодлогын хэрэгжилтийг “муу” гэж үнэлэв.

Бодлогын 3 чиглэлийн хэрэгжилтийг харьцуулан үзвэл малчдыг тав, тухтай амьдрах орчныг бүрдүүлэх ажлууд хамгийн өндөр буюу 68%-ийг хэрэгжилттэй байгаа бол үр ашигтай МАА эрхлэх ажлуудын гүйцэтгэл 54% байна.

Аймгийн ХХААГ-ын удирдлагын бүтэц оновчгүй, ХХААГ-аас Мал эмнэлгийн алба тусгаарлаж, Мал эмнэлгийн газар (МЭГ) байгуулагдсанаар хоорондын ажил үүргийн уялдаа, харилцаа алдагдсан.



ТАВ. ЗӨВЛӨМЖ

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хөндлөнгийн үнэлгээний судалгаа хийсний эцэст дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын цаашдын хэрэгжилтэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

Хоёрдугаар бодлогын чиглэл болох мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох үйл ажиллагаануудын хэрэгжилтийг хангах, мөн удаашралтай явагдаж байгаа ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь хэрэгжүүлэх хэрэгтэй.

Мөн хэрэгжиж эхлээгүй үйл ажиллагаануудыг яаралтай хэрэгжүүлж эхлүүлэх шаардлагатай. Тухайлбал бэлчээр ашигласны төлбөрийг эдийн засаг, экологийн үнэлгээнд үндэслэн ялгавартай тогтоох, орон нутагт бэлчээрийн төлбөрийн орлогоос бүрдсэн бэлчээр хамгаалах сан (Эрсдлийн сан гэх мэт)-г байгуулж төлбөр төлж буй малчид өөрсдөө тухайн сангийн үйл ажиллагааг удирдан явуулахад дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, орон нутаг, төв суурин газар, төвлөрсөн зах, дэлгүүрүүдэд малчдын бүтээгдэхүүнийг худалдан авах цэгүүдийг нээх, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах бага оврын техник, технологи нэвтрүүлэх, зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах маркетингийн сургалт явуулах шаардлагатай.

2020 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” хэрэгжиж дуусна, тиймээс энэ бодлогын залгамж бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг одооноос эхэлж ХХААХҮЯ бэлтгэх шаардлагатай. Учир нь малчдын нийгэм, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, хувь хүний хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд тус бодлого нэн тэргүүний ач холбогдолтой байна. Тус бодлогын үргэлжлэл болох бодлогын баримт бичиг боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

Стратегийн зорилт тус бүрийг хоорондоо уялдаа холбоотой, давхцалгүй, тодорхой болгох шаардлагатай. Мөн “Монгол мал” үндэсний хөтөлбөр зэрэг бусад бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс ялгаатай, илүү малчин хүн рүү чиглэсэн, тэдний нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх нь чухал байна.

Тус бодлогын үр дүнг сулруулах нэг шалтгаан нь санхүүжилтийн асуудлыг оруулж өгөөгүйтэй холбоотой. Тиймээс дараагийн удаа тус бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулахдаа зорилт тус бүрт зарцуулах төсвийг эх үүсвэртэй нь хамт оруулах шаардлагатай.

Тодорхой, оновчтой шалгуур үзүүлэлт тогтоож, түүнийг тогтмол хэмжих арга зүйг боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй. Нэг шалгуур үзүүлэлтэд олон үр дүнг хэмжих олон үзүүлэлт оруулахгүй байх, тоон үзүүлэлтээр хэмжигдэх шалгуур үзүүлэлтийн



хувьд зорилтот түвшинг бодлого хэрэгжих үе шат тус бүрт тодорхой тавьж өгөх хэрэгтэй.

Бодлогын баримт бичигт малчдын боловсрол, соёл, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх зэрэг бодлогын арга хэрэгслийг түлхүү оруулах, мөн хөдөөгийн ядуурлыг бууруулах, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, малчид нэмэлт орлого олох боломж, нөхцлийг бүрдүүлэх, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэх чадавхыг бэхжүүлэх асуудлыг түлхүү тусгах шаардлагатай.

Цаашид батлагдсан бодлогын баримт бичгийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэх, хүлээгдэж буй үр дүнд хэрхэн хүрэх, явцын болон эцсийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хэрхэн хийх талаар нэгдсэн ойлголт бий болгох уулзалт семинарыг ХХААХҮЯ-ны ХШҮДАГ тодорхой давтамжтайгаар, эсвэл бодлого хэрэгжихээс өмнө зохион байгуулах шаардлагатай. Ингэснээр орон нутгийн мэргэжилтнүүдийн тус бодлогын талаарх мэдлэг, мэдээлэл сайжирч бодлогын хүлээгдэж буй үр дүнд эерэг нөлөө үзүүлж, шалгуур үзүүлэлтийг хангах боломж нэмэгдэнэ.

Аймаг, нийслэлийн ХХААГ-аас өгч байгаа гол зөвлөмжүүд нь

Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх,
Орон нутагт бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй болгоход төсөв, санхүүжилтийг оновчтой, шийдвэрлэх,
Малчдын эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, мэдээллээр хангах,
Малчин өрхийн гишүүдийн боловсролыг сайжруулах, аж амьдралын хэв маягт нийцсэн сургалтын тогтолцоог бий болгох,
Бэлчээрийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх,
Малчин өрхүүдийн хорших, гарааны бизнес эрхлэх бизнесийн таатай орчинг бүрдүүлэх боломжоор хангах.



ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ҮСХ (2019) Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, Улаанбаатар, Монгол Улс,
http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=XAA%202018_last.pdf&ln=Mn

УИХ (2009) Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, 39-р тогтоол,
<https://www.legalinfo.mn/annex/details/3305?lawid=6505>

ХХААХҮЯ (2019) Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч танилцуулга: 2018 оны жилийн эцсийн байдлаар, <http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/huuli2018.pdf>

ХХААХҮЯ (2019) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт (2018 оны жилийн эцсийн байдлаар), [http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tailany20181\(1\).pdf](http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tailany20181(1).pdf)

ХХААХҮЯ (2019) Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга (2018 оны жилийн эцсийн байдлаар),
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/zghot20184.pdf>

ХХААХҮЯ (2019) “Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ажлын товч танилцуулга”,
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/AimagUnelgee20190221.pdf>

МУЗГ (2017) Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам,
<https://www.legalinfo.mn/annex/details/7750?lawid=12578>

ХХААХҮЯ (2019) Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга (2018 оны жилийн эцсийн байдлаар),
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/zghot20184.pdf>

ХХААХҮЯ (2019) “Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ажлын товч танилцуулга”,
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/AimagUnelgee20190221.pdf>

МУЗГ (2017) Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам,
<https://www.legalinfo.mn/annex/details/7750?lawid=12578>



ХХААХҮЯ (2018) "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого" –ын 2017 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар,


ХХААХҮЯ (2019)"Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын 2 дахь үе шатны төлөвлөгөөний 2018 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар

ХХААХҮЯ (2018, 2019) "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын 2 дахь үе шатны төлөвлөгөөний жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар



ДОЛОО. ХАВСРАЛТ

7.1 ХАВСРАЛТ 1. БҮХ АЙМГУУДЫН ХХААГ-Т ХҮРГҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
И-мэйл: mofa@mofa.gov.mn, Вэбсайт: www.mofa.gov.mn

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
НАРТ

2019 09 18 № 01/3581
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-тай ажил гүйцэтгэх 190820/10-304, 190820/10-303 тоот гэрээг тус тус байгуулан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгүүлж байна.

Иймээс үнэлгээний ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хавсралт хүснэгтийн дагуу үнэн зөв бөглөж 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор tumee_0329@yahoo.com, batnaran@mul.s.edu.mn имэйл хаяг болон эх хувиар ирүүлнэ үү.


Холбоо барих утас: 99032932, 99839839

Хавсралтын мэдээллийн файлыг дараах линкээс татаж авна уу.

<https://www.dropbox.com/s/x09zu3dkbubnhvm/havsralt.xlsx?dl=0>

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00006289

Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны
09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/384
1 дүгээр хавсралт

1. “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилттэй холбоотой тоо, мэдээ
1.1 “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтэд төсөвлөсөн төсөв,
төсвийн зарцуулалт, огноо

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019
1	Монгол мал үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн орон нутгийн төсөв (Аймгийн хэмжээнд) (Төгрөг)				
1.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Төгрөг)				
1.2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Төгрөг)				
1.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтад зориулан зарцуулсан зардал (Төгрөг)				
1.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлахад зарцуулсан зардал (Төгрөг)				
1.5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Төгрөг)				
1.6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.10	Дэд бүтцийн зардал (зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Төгрөг)				
1.11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Төгрөг)				
	Нийт				

- 1.2 “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн үр дүн, алдаа дутагдал, санал, шүүмж

№	Үзүүлэлт	Монгол мал үндэсний хөтөлбөрийн II үе шат хэрэгжиснээр		
		Гарсан үр дүн	Алдаа дутагдал	Санал, шүүмж
2.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээ			
2.2	Малын генетик нөөц, үржил селекц			
2.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт			
2.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлах			
2.5	Хадлан бэлтгэл			
2.6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл			
2.7	Малчдын эрүүл мэнд			
2.8	Малчдын боловсрол			
2.9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх			
2.10	Дэд бүтэц (зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)			
2.11	Эрчимжсэн мал аж ахуй			

Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны
09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/337/ албан тоотын
2 дугаар хавсралт

2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-той холбоотой тоо мэдээ
2.1 “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д төсөвлөсөн орон нутгийн төсөв,
төсвийн зарцуулалт, огноо

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019
1	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогод төсөвлөсөн орон нутгийн төсөв (Аймгийн хэмжээнд) (Төгрөг)				
1.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Төгрөг)				
1.2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Төгрөг)				
1.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтад зориулан зарцуулсан зардал (Төгрөг)				
1.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлахад зарцуулсан зардал (Төгрөг)				
1.5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Төгрөг)				
1.6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Төгрөг)				
1.10	Дэд бүтцийн зардал (зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Төгрөг)				
1.11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Төгрөг)				
-	Нийт				

2.2 “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын үр дүн, алдаа дутагдал, санал, шүүмж

№	Үзүүлэлт	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэрэгжиснээр		
		Гарсан үр дүн	Алдаа дутагдал	Санал, шүүмж
2.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээ			
2.2	Малын генетик нөөц, үржил селекц			
2.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт			
2.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлах			
2.5	Хадлан бэлтгэл			
2.6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл			
2.7	Малчдын эрүүл мэнд			
2.8	Малчдын боловсрол			
2.9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх			
2.10	Дэд бүтэц (зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)			
2.11	Эрчимжсэн мал аж ахуй			

7.2 ХАВСРАЛТ 2. УВС АЙМАГТ АЖИЛЛАСАН ИЛТГЭХ ХУУДАС

Төрөөс малчдын талаар баримтлах бодлого болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Увс аймагт ажилласан илтгэх хуудас

2019 оны 08-р сарын 29-ний өдөр Увс аймгийн ХХААГ-ын дарга болон Мал аж ахуйн албаны дарга нартай бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй холбоотой уулзалт хийсэн.

Энэхүү уулзалтаар Төрөөс малчдын талаар баримтлах бодлого болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн түвшинд хийсэн ажил, үр дүн (аймгуудаас ирсэн мэдээлэлд харуулсан) болон тулгамдаж буй асуудал, цаашид анхаарах зүйлсийг тодруулсан. Үүнд:

Малыг ээмэгжүүлэх ажил бүрэн бус, малын бүртгэлжүүлэлт хангалттай бус.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв, мөнгө дутагдалтай.

Малын генетик нөөцийн болон Малын эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг ижил түвшинд авч үзэх. Өөрөөр хэлбэл Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд зориулсан төсөв байхгүй, харин Малын эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтэд зориулан төсөв батлагдсан.

Аймгийн ХХАА-н газрын удирдлагын бүтэц оновчгүй, ХХААГ-аас Мал эмнэлгийн алба тусгаарлаж, Мал эмнэлгийн газар (МЭГ) байгуулагдсан нь хоорондын ажил үүргийн уялдаа, харилцаа алдагдсан. Аймгийн МЭГ босоо тогтолцоотой болсон нь ХХААГ-тай хамтран ажиллах байдал суларсан.

Малчдын тулгамдаж буй нийгмийн асуудлын нэг болох 6 настай хүүхдийг сургуульд оруулдаг болсон нь гэр бүл 2 тусдаа байх, үүнээс хамааран малчдын эрүүл мэнд, гэр бүл салалт нэмэгдэх болсон.

1990-ээд оны эхэн үеийн ТТЭЗ-ийн задралаар өмнө нь ажиллаж байснаа, ЗЗЭЗ-ийн харилцаанд шилжихэд ажилгүй байж байгаад дараа нь малчин болсон хүмүүсийн тэтгэврийн асуудлыг шийдвэрлэх.

Эрчимжсэн мал аж ахуй сул, хуучны тогтолцоо, арга барилтай. Аймгийн хэмжээнд 9-10 аж ахуй л эрчимжсэн байдлаар үйл ажиллагаа явуулж байна.

Тэжээлийн чиглэлийн төрөлжсөн аж ахуй байхгүй, 3 гурилын үйлдвэрийн хүрээнд л хаягдал хивэг гаргаж, малын тэжээлд зориулж байна. Тэжээлийн хэрэгцээний ихэнх хувийг ОХУ болон төвийн бүсээс хангадаг.

Импортоор нарийн ноос орж ирж, ченжээр дамжин төвийн бүс рүү явж байна.

Түүхий эдийн боловсруулах цехийн хувьд арьс, шир боловсруулах 1 цех идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилттэй сумын хэмжээнд арьс, шир боловсруулах хүчин чадалтай 1 цех байгуулагдсан.

Малын бэлчээрийн даац хэтэрснээс шалтгаалан малын бэлчээрийн усан хангамж багассан. Мөн зарим усны ундарга ширгэсэн нь сөргөөр нөлөөлсөн.

Дээрх баримт бичгүүдийн хэрэгжилтэд зориулсан санхүүгийн нөөцийн дутагдалтай байдлыг шийдэхэд уул уурхайгаас олсон орлогыг зөв зохистой хуваарилах явдал юм гэж үзсэн байна.

Өвөл, хаврын улиралд өвс, тэжээлийн хомсдол үүсдэг.



Монгол мал хөтөлбөрийн хүрээнд жилд 5 худгийг 100 сая төгрөгт багтаан гаргасан.
Малын ангилалт, ялгалтыг 2-3 жилд 10 сая төгрөгөөр хийдэг.
Мөн малчдын нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө, санхүү байхгүй
байна гэж үзсэн байна.

Илтгэх хуудас бичсэн:

Г.Энх-Амгалан



7.3 ХАВСРАЛТ 3. АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС ТМТББ-Т ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорнод, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд, мөн Улаанбаатар хотын орон нутгийн төсвөөс “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд зарцуулалт хийгдээгүй гэж эдгээр аймаг, нийслэлийн ХХААГ мэдэгдсэн болно.

1. Булган аймгийн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд төсөвлөсөн төсөв

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Мян.төг)	-	17,974.0	18,981.5	-
2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Мян.төг)	-	-	-	-
3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтанд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	-	21,500.0	26,500.0	58,000.0
4	Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлахад зарцуулсан зардал (Мян.төг)	180,000.0	90,000.0	180,000.0	90,000.0
5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Мян.төг)	25,000.0	25,000.0	25,000.0	25,000.0
6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Мян.төг)	-	15,000.0	3,000.0	-
7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Мян.төг)	4,900.0	4,902.0	5,584.7	6,146.0
8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Мян.төг)	10,750.0	11,450.0	19,668.2	43,496.0
9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Мян.төг)	63,000.0	63,000.0	178,560.0	149,410.0
10	Дэд бүтцийн зардал (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Мян.төг)	120.0	-	-	12,750.0
11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	1,500.0	-	1,000.0	-
Нийт (Мян.төг)		285,270.0	248,826.0	458,294.4	384,802.0

Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ



2. Говь-Алтай аймгийн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд төсөвлөсөн төсөв

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Мян.төг)	-	-	-	-
2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Мян.төг)	-	-	-	-
3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтанд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	10,000.0
4	Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлахад зарцуулсан зардал (Мян.төг)	-	74,900.0	75,000.0	80,000.0
5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Мян.төг)	42,200.0			
6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	-
7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Мян.төг)	-			
8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	-
9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	-
10	Дэд бүтцийн зардал (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Мян.төг)	-	-	-	-
11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	-
Нийт (Мян.төг)		42,200.0	74,900.0	75,000.0	90,000.0

Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ

3. Дархан-Уул аймгийн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд төсөвлөсөн төсөв

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Мян.төг)				
2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Мян.төг)	540,000	9,066,595	690,000	803,200
3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтанд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	-	8,026,100	17,000,000	3,018,400
4	Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлахад зарцуулсан зардал (Мян.төг)	11,000,000	9,100,000	5,858,500	11,000,000
5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Мян.төг)	11,950,000	27,000,000	26,000,000	6,300,000
6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Мян.төг)	-	-	-	-
7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Мян.төг)				
8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Мян.төг)	2,006,000	1,838,800	1,942,400	1,858,800
9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Мян.төг)	40,250,000	45,050,000	53,530,000	10,250,000
10	Дэд бүтцийн зардал (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Мян.төг)				
11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Мян.төг)	41,000,000	44,000,000	82,000,000	60,000,000
